



**Хууль зүй, дотоод
хэргийн яам**



**“Шүүх, эрх зүйн
шинэчлэлт” төсөл**

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 2

Гарын авлага

Зөвлөх: Д. Наранчимэг

**Боловсруулсан: Г. Амаржаргалан
Д. Аюуш
Ц. Давхарбаяр**

*Энэхүү гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас
хэрэгжүүлж буй Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар 2007

DDC 346,02'023
Н-294

Гэрээний эрх зүй-2 Гарын авлага

Гарын авлага болон хөтөлбөр боловсруулсан:

Зөвлөх:

Д. Наранчимэг, дэд профессор

Багийн гишүүд:

Г. Амаржаргалан, LLM

Д. Аюуш, LLM

Д. Давхарбаяр, LLM

Хэвлэлийн хэмжээ: 9.1 х.х

Номын хэмжээ: 176х250/12

Хэвлэсэн газар: "Соёмбо принтинг" ХХК

ISBN 978-99929-4-137-5



“ШҮҮХ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ” ТӨСЛИЙН ТУХАЙ

Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудад



*“Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн зохицуулагч
Д.ОЮУНЧИМЭГ*

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл 2002 оноос хэрэгжээд дуусах шатандаа орж байна.

Энэ төслийн хүрээнд эрх зүйн дээд боловсролыг чанаржуулах чиглэлээр эхний шатны зарим ажлыг хийж дуусгалаа. Эдгээр ажлын үр дүн нь таны гар дээр очиж буй энэ гарын авлага юм. Бид энэ ажлыг зохион байгуулахдаа гадаадын зөвлөх гэхээсээ монголчууд бидний оюун ухаанд тулгуурлаж, дотоодын эрдэмтэн, багш нараар хийлгэсэн юм. Энэ номыг бүтээхэд хууль зүйн сургуулиудаас нэр хүндтэй, туршлагатай ахмад багш, нөгөө талаар идэвхтэй, санаачлагатай, хийж бүтээе, өөрийгөө боловсрууля гэсэн эрмэлзэлтэй залуу багш нарыг баг болгон оролцуулсан юм. Энэ гарын авлагыг бүтээх явцад багш нар хамтран ажиллаж, бие биенээсээ харилцан суралцаж, цаашид судалгаа шинжилгээний ажил, эрх зүйн сургалтын шинэчлэлтийг хамтран хийхэд үр дүнд хүрнэ гэдгийг харуулсан болно.

Оюутанд зориулсан цогц гарын авлага (хичээлийн хөтөлбөр, тойм лекц) нь Монголд анх удаагаа гарч байгаа билээ. Оюутны гарын авлага нь тэдний судалж буй хичээлд хандах хандлагыг өөрчилж, “бэлэнчлэх” сэтгэлгээнээс ангижруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Төсөл бол тодорхой хугацаанд хэрэгжээд дуусдаг жамтай. Харин төсөл хэрэгжүүлэх явцад танилцсан, хамтарч ажилласан багш нар цаашдаа өөрсдийгөө боловсруулах, сургалтынхаа арга барил, чанарыг сайжруулах чиглэлээр хийж эхэлсэн ажлаа үргэлжлүүлнэ гэдэгт найдаж байна. Хичээлийн хөтөлбөр, оюутны гарын авлага бүтээхэд оролцсон 100 орчим эрдэмтэн, багш нар болон энэ ажлыг гардан зохион байгуулж, уялдаа холбоог нь хангах талаар идэвх зүтгэлтэй ажилласан төслийн ажилтан Б.Сарантуяад талархал илэрхийлье.

Үр дүнд чиглэсэн сургалтын хөтөлбөр



“Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн зөвлөх У.ТУЯА

Оюутан залуус та бүхэнд их мэдлэгийг хуримтлуулах нь чухал уу, харин уг мэдлэгээ ашиглах чадвар, мэргэжлийн үнэт зүйлсийг эзэмших нь чухал уу. Аль замыг чухал гэж сонгосноос таны суралцах арга барил, цаашлаад сургалтад хандах хандлага тань тодорхойлогддог байна. Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулахад ч энэ хоёр талаас авч үзэх хэрэгтэй болдог.

Бид 2003 оноос Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг сайжруулах” дэд төслийн хүрээнд энэхүү сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулахдаа дараах шаардлагыг харгалзсан бөгөөд оюутан таныг ч энэ тухай мэдэж сургалтын хөтөлбөр, гарын авлагаа ашиглахыг зөвлөж байна. Үүнд:

- ❖ Оюутан ямар зорилгоор уг хичээлийг судалж, ямар үр дүнд хүрэхээ мэдэж байх ёстой.
- ❖ Мэргэжлийн мэдлэг нь мэргэжлийн ур чадвар болон хөгжиж, үнэт зүйл болон төлөвшсөн байх нь чухал. Иймээс мэдээлэл болгоныг боловсруулах бие даалтын ажил оюутанд хэрэгтэй.

ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН БАГ



Овог нэр: Даваасүрэнгийн Наранчимэг

Эрдмийн зэрэг цол: Дэд профессор

Эрхэлж байгаа албан тушаал: Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Отгонтэнгэр Их сургуулийн ректор, МӨХ-н гишүүн, өмгөөлөгч

Бүтээлийн жагсаалт: Ном, сурах бичиг 4, Редакторлосон ном 4, Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл 30 гаруй, Боловсруулсан хуулийн төсөл 4,

Сургалтын чиглэл: Иргэний эрх зүйгээр мэргэшсэн



Овог нэр: Ганболдын Амаржаргалан

Мэргэжлийн зэрэг, цол: Хууль зүйн ухааны магистр

Эрхэлдэг ажил, албан тушаал: Шихихутуг ХЗДС-д багш

Бүтээлийн жагсаалт: Бизнесийн эрх зүй, гэрээний эрх зүйн чиглэлээр эрдэм шинжилгээний 5 өгүүлэл нийтлүүлж, онол практикийн бага хурлаар хэлэлцүүлж байсан.

Судалгааны ажлын чиглэл: Гэрээний эрх зүйн чиглэлээр судалгааны ажил хийж байна.



Овог нэр: Цэвээнсүрэн Давхарбаяр

Эрдмийн зэрэг цол: Хууль зүйн магистр, докторант

Эрхэлж байгаа албан тушаал: МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш

Бүтээлийн жагсаалт: "Хууль зүйн туслалцаа" 2005 он.

Гарын авлага, "Эрх зүйн хөтөч" 2007 он. Гарын авлага, Эрдэм шинжилгээний өгүүлэл 2.

Иргэний эрх зүйн өмчийн болон гэрээний эрх зүйн чиглэлээр судалгааны ажил хийдэг.



Овог нэр: Дунхүүгийн Аюуш

Боловсрол эрдмийн зэрэг: Хууль зүйн магистр, докторант

Эрхэлж буй ажил, албан тушаал: МӨХ-ын гишүүн, Өмгөөлөгч, ОТИС-ийн ХЗС-ийн Бизнесийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч

Эрдэм шинжилгээний бүтээл: Ном, гарын авлага 2, Өгүүлэл, нийтлэл 4.

Сургалтын чиглэл: Иргэн, бизнесийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн.



ӨМНӨХ ҮГ

Дэлхийн банкны "Шүүх, эрх зүйн шинэчлэлт" төслийн эрх зүйн боловсролыг сайжруулах дэд төслийн хүрээнд эрх зүйн боловсрол эзэмшиж буй оюутан, залуучууд төдийгүй энэ салбарын багш нарт зориулан "Гэрээний эрх зүй-1\Гэрээний эрх зүй-2" хичээлийн хөтөлбөрийг хууль зүйн их, дээд сургуулиудын эрдэмтэн, багш нарын ажлын хэсэг боловсруулсан.

Дээрх хичээлийн хөтөлбөрийг сургалтад туршин, хэд хэдэн үе шаттайгаар сайжруулсаны эцэст уг хөтөлбөрийн дагуу хичээлийн агуулгыг тоймлон багтаасан "Гэрээний эрх зүй-2" гарын авлагыг ажлын хэсгээс боловсруулаад байна.

Энэхүү гарын авлагыг боловсруулахдаа оюутан, суралцагчдад илүү ойлгомжтой байх үүднээс агуулгыг схемчлэн, бататгах дасгал, сорил, даалгавар, хэрэглэгдэхүүнийг сэдэв бүрт багтаасан болно.

Гэрээний тусгай төрлүүд нь өөр өөр агуулга, хууль зүйн үр дагавартай хэдий ч үүргийн нийтлэг үндэслэлийн хүрээнд нийтлэг шинж, томъёолол, иргэний хуулийн зохицуулалтын дагуу гэрээний талуудын эрх, үүрэг тодорхойлогддог утгаараа гэрээний агуулга хэсгийг гарын авлагад дахин давтах шаардлагагүй гэж үзлээ.

Оюутан энэхүү гарын авлагаас сэдэв бүрийн чиглэмж, ойлголтыг аван цаашид хэрэглэгдэхүүний тусламжтайгаар бие даан суралцаж, сэдэв болон бүлгийн зорилгод хүрэх боломжтой юм.

Гэрээний эрх зүйг сонирхон суралцагч төдийгүй энэ салбарын судлаач багш та бүхнийг энэхүү гарын авлагын талаарх саналаа тус төсөл болон ажлын хэсэгт ирүүлж, хамтран ажиллахыг хүсье.

Танд баярлалаа.

Багийн гишүүд

ГАРЧИГ

Өмнөх үг	5
----------	---

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ-2 ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

1. Гэрээний эрх зүй-2 ХИЧЭЭЛИЙН тодорхойлолт	7
2. Гэрээний эрх зүй-2 хичээлийн арга зүй	10
3. Гэрээний эрх зүй-2 хичээлийн үнэлгээ	24

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ-2 ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

Нэгдүгээр бүлэг:	Бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг, төрөл, онцлог	28
1.	Худалдах, худалдан авах болон арилжааны гэрээ	28
2.	Бэлэглэл	34
3.	Зээлийн гэрээ	37

Хоёрдугаар бүлэг:	Бусдын эзэмшил ашиглалтанд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг, төрөл, онцлог	41
1.	Эд хөрөнгө хөлслөх болон орон сууд хөлслөх, эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах гэрээ	41
2.	Түрээсийн гэрээ	45
3.	Франчайз	49

Гуравдугаар бүлэг:	Ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг, төрөл, онцлог	52
1.	Ажил гүйцэтгэх гэрээ	52
2.	Хөлсөөр ажиллах, хөдөлмөрийн гэрээ	56
3.	Аялал жуулчлалын гэрээ	58
4.	Тээвэрлэлтийн гэрээ	62
5.	Хөрөнгө итгэмжлэх гэрээ	66
6.	Зуучлал, худалдааны зуучлагч, комиссийн гэрээ	70
7.	Даалгаврын гэрээ	74
8.	Илгээмжийн гэрээ	79
9.	Хадгалалтын гэрээ, барааны агуулахад эд хөрөнгө хадгалах гэрээ	82
10.	Даатгалын гэрээ	86
11.	Хамтрйн ажиллах гэрээ	91
12.	Асран тэтгэх гэрээ	96
13.	Үнэт цаасны эргэлтээс үүсэх үүрэг	98

Дөрөвдүгээр бүлэг:	Зээл тооцооны үүрэг, төрөл, онцлог	105
1.	Төлбөр тооцоо	105
2.	Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ	110
3.	Мөнгөн хадгаламжийн гэрээ	114
4.	Банкны баталгаа болон батлан даалтын гэрээ	117
5.	Тооцоо нийлэх гэрээ	123



НЭГ. ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ-2 ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ-2 ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Гэрээний эрх зүй-2 хичээлийн танилцуулга

Хичээлийн нэр: Гэрээний эрх зүй-2
Нийт цаг: 48 цаг /16 цаг лекц, 32 цаг семинар/
Кредит: 2 кр
Залгамж холбоо: Энэ хичээлийг Үндсэн хуулийн эрх зүй болон Иргэний эрх зүй, Гэрээний эрх зүй-1 хичээлийн дараа судалвал зохино.

д/д	Заавал судалсан байх хичээл	Үндэслэл
1.	Үндсэн хуулийн эрх зүй	Үндсэн хуулийн эрх зүй нь аливаа салбар эрх зүйн увидас, гол эх сурвалж болдог утгаараа гэрээний эрх зүйг судлахад уг эрх зүйн харилцаанд оролцогчоос өөрийн эрхээ хэрэгжүүлэх, хамгаалах, бусдын эрхийг хүндэтгэх, тэгш эрхийн зарчмыг мөрдлөг болгон зан үйлийг журамлахад үндсэн хуулийн эрх зүйн үзэл санаа, зарчмыг удирдлага болгоно.
2.	Иргэний эрх зүй	Хувийн эрх зүйн үндсэн салбар болох иргэний эрх зүйн үндсэн ойлголт категориудыг /хэлцэл, төлөөлөл, хөөн хэлэлцэх хугацаа г.м/ судалж, танин мэдсэнээр гэрээний эрх зүйг гүнзгийрүүлэн судлах болно.
3.	Гадаад хэл	Гэрээний эрх зүй төдийгүй бусад салбар эрх зүйн хичээлийн лекцээр олсон мэдлэгийг бататган гүнзгийрүүлэх, бие даан суралцах, семинарын хичээлд бэлтгэх гадаад хэл дээр аливаа эх сурвалж, ном, сурах бичиг, сонин сэтгүүл, интернэтсайтыг ашиглан мэдээлэл, практик жишээ олж авахад чухал ач холбогдолтой тул гадаад хэлний хичээлийг судласан байх шаардлагатай.

Үнэлгээ: Хичээлийн явцад оюутан үнэлгээний 70 хувийг идэвх оролцоо, бие даалтын ажил, явцын шалгалт шүүлгээр цуглуулна. Эцсийн шалгалтаар үнэлгээний 30 хувийг авна.

Гэрээний эрх зүй-2 хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжин, өмчийн олон төрөл хэлбэр үүсэж улмаар эдийн засгийн хүрээн дэх нийгмийн харилцаа нь хөгжлийн тодорхой

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 2

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ-2 ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

чиг хандлагатай уялдан байнга хувьсан өөрчлөгдөж тэдгээр харилцааг хууль тогтоомжоор зохицуулах зайлшгүй шаардлага бий болсоор ирсэн. Гэхдээ нийгмийн бүхий л харилцааг хууль тогтоомжоор зохицуулах боломжгүй юм.

Энэ хичээлийг судалснаар гэрээний тусгай төрлүүдийг гүнзгийрүүлэн судалж онол, практикийн мэдлэг, гэрээ байгуулах чадварыг эзэмшиж түүнийгээ ажил мэргэжил төдийгүй өдөр тутмын амьдрал ахуйдаа хэрэглэж сурна.

Бид алхам тутамдаа гэрээний эрх зүйн харилцаанд оролцож байдаг. Иймээс өөрсдийн болоод бусдын эрх ашиг сонирхолыг зүй зохистой илэрхийлэх, хамгаалах, хэрэгжүүлэхийн тулд гэрээний төрлүүдийг нарийвчлан судалж зөв танин мэдэж, ашигтай зөв сонголт хийх, эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зайлшгүй шаардлага гарч байдаг.

Гэрээний эрх зүй-2 хичээлийн зорилго

Эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцаанд оролцогчид нь зан үйлийн горимоо өөрсдөө тохиролцон тогтоох боломжийг олгосон гэрээний тусгай төрлүүдийн талаар онолын мэдлэг олгож тэдгээр гэрээг онолын үндэслэлтэй байгуулах дадалтай болгох, гэрээтэй холбоотой аливаа маргааныг шийдвэрлэх явцад өөрийн болон бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чадвартай болгоход хичээлийн зорилго оршино.

Гэрээний эрх зүй-2 хичээлийн зорилт

- Гэрээний тусгай төрлүүдийн талаар онол, практикийн мэдлэгийг эзэмших
- Гэрээ байгуулах хийгээд боловсруулах дадал дүйтэй болох
- Гэрээ боловсруулах талаар өөрийн мэдлэгийг бүтээх
- Гэрээний зөрчилтэй холбоотой маргаан шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх чадвартай болох

Гэрээний эрх зүй-2 хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цагийн хуваарилалт

№	Бүлгийн нэр	Лекц, семинарын хичээлийн сэдвийн нэр	Цаг
1.	Бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг, төрөл, онцлог	Худалдах, худалдан авах болон арилжааны гэрээ	2
		Бэлэглэлийн гэрээ	2
		Зээлийн гэрээ	2



2.	Бусдын эзэмшил, ашиглалтанд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг, төрөл, онцлог	Эд хөрөнгө хөлслөх болон орон сууц хөлслөх, эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах гэрээ	2
		Түрээсийн гэрээ	4
		Франчайз	2
3.	Ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг, төрөл, онцлог	Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээ	2
		Аялал жуулчлалын гэрээ	2
		Тээвэрлэлтийн гэрээ	2
		Хөрөнгө итгэмжлэх гэрээ	2
		Зуучлал, худалдааны зуучлагч, комиссийн гэрээ	2
		Даалгавар ба илгээмжийн гэрээ	2
		Хадгалалтын гэрээ	2
		Даатгалын гэрээ	4
		Хамтран ажиллах гэрээ	2
		Асран тэтгэх гэрээ	2
		Үнэт цаасны эргэлтээс үүсэх үүрэг	2
4.	Зээл тооцооны үүрэг, төрөл, онцлог	Төлбөр тооцоо	2
		Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ	2
		Мөнгөн хадгаламжийн гэрээ	2
		Банкны баталгаа болон батлан даалтын гэрээ	2
		Тооцоо нийлэх гэрээ	2
Нийт			48

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ-2 ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА ЗҮЙ

Гэрээний эрх зүй-2 хичээлийн арга зүйд тавигдах шаардлага

Гэрээний эрх зүй-2 хичээлийг судлах үндэслэл, хичээлийн зорилго, зорилттой уялдан уг хичээлийг заах арга зүйд дараах шаардлага тавигдана.

Үүнд:

- Хичээлийн зорилгыг хангахуйц арга, хэлбэрийг сонгох, тэр нь хичээлийн агуулгад тохирсон байх,
- Гэрээний эрх зүй-2 хичээлээр гэрээний эрх зүйн ерөнхий ангиар зохицуулагдах харилцааны онцлог, мөн чанарын талаар мэдлэг бүтээн амьдралд хэрэглэх, гэрээний тусгай төрлүүдэд уялдуулан хэрэглэх чадвар эзэмших нөхцөл боломжийг хангах,
- Оюутнууд хичээлд жигд, вдэвхитэй оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх,
- Хичээлийн агуулга нь практикт нийцсэн байх.

Мэдээлэл түгээх арга

Лекцийн арга /Lecture/

Лекцийн арга нь сэтгэлгээний мэдлэг, ойлголтын түвшний зорилтыг хангахад тохиромжтой байдаг бөгөөд гэрээний эрх зүй-2 хичээлийн агуулгыг судлахад лекцийн аргыг тодорхой сэдвүүдээр ашиглана.

Оюутанд их хэмжээний мэдээллийг хүргэхийн тулд лекцийн явцад бичүүлдэг уламжлалт аргаас аль болох татгалзах нь зүйтэй. Хичээл зааж буй багш цуглуулсан мэдээллээ хураангуй хэлбэрт оруулан урьдчилан тараасан байвал зохино. Харин хичээлийн явцад оюутан өөрөө хүсвэл уг хураангуй дээр чухал гэсэн зүйлээ бичиж тэмдэглэж авч болно. Иймд багш ойлгоход нарийн төвөгтэй зүйлийг тайлбарлан таниулах болон гагцхүү олон цаг зарцуулан янз бүрийн эх сурвалж уншиж байж сая нэг төсөөлөл авах төвөгтэй сэдвийг цогц байдлаар хүргэхийн тулд лекцийн аргыг ашиглах нь илүү тохиромжтой. Лекцийн хичээлд, зураг, бүдүүвч болон бусад үзүүлэн таниулах материал өргөнөөр ашиглах нь цаг хэмнэх, оюутны хүлээж авах чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Гэрээний эрх зүй-2 хичээлийн ихэнхи сэдвийг зөвхөн лекцийн аргаар заахад төдийлөн тохиромжгүй байдаг учир тохиолдол шинжлэх, хэлэлцүүлэг явуулах, шалтгаан үр дагаврыг тодорхойлох, өртөөчлөн мэдлэг түгээх зэрэг оролцооны аргуудтай хослуулан ашиглах нь зүйтэй.

Лекцийн аргыг хэрэглэхэд анхаарах зүйлс:

- Хүн анхаарлаа дунджаар 15-20 минут төвлөрүүлдэг тул лекц урт хугацаагаар үргэлжлэх ёсгүй бөгөөд боломжтой нөхцөлд сургалтын үр ашгийг дээшлүүлэх үүднээс хэлэлцүүлэг, дүрд хувирах, биечлэн үзүүлэх зэрэг бусад аргыг нэмж ашиглах нь зүйтэй.
- Хүн нэг зэрэг долоогоос илүү мэдээллийг тогтоох боломжтой гэж судлаачид дүгнэсэн байдаг.
- Барууны судлаачдын дүгнэснээр оюутнуудын 60-65 хувийнх нь харааны ой, 20-25 хувийнх нь сонсох ой илүү хөгжсөн байдаг ба хүмүүсийн 15-20 хувь нь үйл хөдлөлөөр дамжуулж сурдаг.



Багш ярихын хажуугаар үзүүлэн таниулах материал ашигласан тохиолдолд суралцагчдын тогтоох мэдээллийн хэмжээ 25 хүртэл хувиар нэмэгддэг бол заалгасан зүйлээ туршиж хэрэглэсэн нөхцөлд энэ үзүүлэлт 70 хувь хүртэл өсдөгийг багш бүр анхаарах шаардлагатай.

Гэрээний эрх зүй-2 хичээлийг лекцийн аргаар заахдаа уг аргыг лекцийн зорилго, бүтэц, агуулгатай нийцүүлэн төлөвлөх шаардлагатай.

Тухайлбал, хэвлэгдээгүй, нийтийн хүртээл болоогүй мэдээллийг дамжуулах, олон эх сурвалжаас авсан мэдээллийг нэгтгэн дүгнэж оюутнуудад хүргэх зорилготой байх бөгөөд лекцийн агуулгыг хамгийн чухал, хэрэгтэй, сонирхолтой гэсэн байдлаар ангилж аль болох хамгийн чухал хэсгийг нь оюутанд хүргэх нь зүйтэй.

Эвлүүлгийн арга /Jacksaw/

Энэ арга нь богино хугацаанд их мэдээлэл олж авах боломж олгодог ба лекцийг орлуулахад ашигладаг. Тухайлбал, үүргийн гүйдэтгэлийг хангах аргуудыг гэрээний үүрэгт оновчтой хэрэглэх нь, тусгай төрлийн гэрээний үүрэгтэй холбоотой хичээлийг энэ аргаар явуулбал тохиромжтой.

Зорилго: Оюутнууд бие биедээ заах, сургах боломж олгодог ба тухайн хичээлээр мэдээлэл олж авахад хүндрэлтэй хичээлийг тайлбарлах, асуулт тавих, бусадтай харилцах ба сонсох чадварыг амьдралд хэрэглэхэд илүү үр дүнтэй.

Гэрээний эрх зүй-2 хичээлийн зарим сэдвийг судлахад оюутнуудад дэлгэрэнгүй мэдээлэл шаардагддаг ба энэ тохиолдолд тухайн мэдээлэл, лекцийн агуулга болон бусад нэмэлт хэрэглэгдэхүүнийг жижиг багийн тоогоор хувааж бэлтгэсэн байна.

Бэлтгэсэн материалаа нэг дугтуйнд хийж багуудад тарааж өгнө. Багийн гишүүд өгөгдсөн сэдвийн дагуу өөр өөрсдийн санал бодлыг уг цаасан дээр бичнэ. Тэдэнд "мэргэжилтэн" болоход хангалттай хугацаа өгөх хэрэгтэй учир баг бүр дээр багш очиж материалаа ойлгож байгаа эсэх, бусдад хэрхэн тайлбарлах талаар ярилцаж туслах хэрэгтэй байдаг.

Хүн бүр багш /Each one teach one/

Бүлэг сэдвийг танилцуулахад болон үзсэн сэдвийн агуулга, ухагдахуунуудыг дүгнэх, лекцийн агуулгыг оюутнуудад хүргэхэд энэ аргыг гол төлөв ашиглана.

Зорилго: Сургалтын үйл явцад идэвхтэй оролцох болон бие биетэйгээ санаа бодлоо солилцоход оюутнуудад ихээхэн ач холбогдолтой. Энэ аргыг ашигласнаар хичээлээр заавал эзэмших ёстой агуулга болон ухагдахууны талаар ерөнхий ойлголт өгөх ба оюутнуудын сонирхлыг өдөөж, асуулт тавихад хүргэнэ.

Хэрэгжүүлэх дараалал:

- Лекцийн агуулга, мэдээллийг утгат хэсгээр нь хувааж, тарааж өгөх зорилгоор жижиг цаасан дээр бичиж бэлдэнэ. Энэ нь таны сургалтад оролцогчдын тоогоор байх ёстойг анхаарч оролцогч бүрт тараана.
- Оюутнууд мэдээллийг уншсаны дараагаар уг уншсан зүйлийнхээ агуулгыг ярих, зураглал, бүдүүвчээр илэрхийлэх зэргээр бусдад түгээх бэлтгэлээ хийнэ.

Энэ үед багш тусламж шаардлагатай хүн дээр очиж зөвлөгөө өгч, тайлбарлаж болно.

- Бэлтгэх хугацаа дууссаны дараа тэд мэдээллээ бие биедээ танилцуулж ангиа тойрон явна. Хүн бүр өөрт байгаа мэдээллээ танилцуулж, бусдаас мэдээлэл авч дуустал энэ ажил үргэлжилнэ. Зорилго нь бусадтай мэдээлэл солилцох буюу өөрт буй мэдээллээ бусдад тарааж, шинэ мэдээлэл бусдаас олж авахад оршино.

Энэ ажлыг дууссаны дараа багш бие биенээсээ юу мэдсэн, ямар шинэ мэдээлэл авсан тухай, энэ мэдээлэл өөрт нь ямар хэрэг болох тухай ярилцуулна.

Ярилцлагын явцад оюутнуудад юу хэрэгтэй байгаа, тэдний бие биеэсээ авсан мэдээллийг хэрхэн цэгцлэх шаардлагатайг багш ажиглаж, тэр дагуу нэмэлт мэдээллийг өгнө.

Оролцооны арга

Тохиолдол шинжлэх /Case method/

Тохиолдол шинжлэх арга нь суралцагчдад эрх зүйн хэм хэмжээг амьдралын тодорхой жишээн дээр үндэслэн хэрэглэж сурахад туслахад чиглэгдсэн асуултын аргад тулгуурласан хэлбэр юм. Тодорхой жишээ гэдэг нь түүхэн явдал, бодит хэрэг, зохиомол үйл явдал, шүүхийн мэдээ зэрэг суралцагчдад нийгэм, эрх зүй, хүний эрхийн асуудлаар шинэ сэргэг ойлголт, мэдлэг өгөх, асуудалд олон талаас нь шүүмжлэлтэй, нухацтай хандах сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдэж ашиглагдах хэрэглэгдэхүүн юм.

Сургалтын тохиолдлууд ихэвчлэн эх бичвэрийн хэлбэртэй байдаг боловч кино болон дүрс бичлэг, дуу хураагчид бичигдсэн, дүр бүтээж тоглох болон бусад хэлбэрээр байж болно.

Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхийн тулд амьдрал, практикт гарч байсан гэрээний эрх зүйтэй холбоотой хэрэг маргааны талаарх янз бүрийн мэдээлэл, хууль тогтоомж, эрх зүйн актууд болон холбогдох гарын авлагуудыг бэлтгэсэн байх зайлшгүй шаардлагатай.

Зорилго: Сургалтын энэ арга нь суралцагчийг ямар нэгэн бодит баримтын талаар асуулга тавих, тухай бүрийн тодорхой нөхцөлүүдэд чухам ямар элемент нь чухал болохыг тодорхойлж, тэдгээрийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж, тохиолдол бүрт эргэцүүлэн бодож байх боломж олгодог. Тохиолдлыг шинжлэх явцдаа суралцагчид нь цээжлэн тогтоох эхний хэлбэрээс эхлээд бодит баримтыг үнэлэх хүртэлх сэтгэхүйн үйлүүдийг хийж даддагажих болно. Түүнчлэн оюутнууд шүүхийн шийдвэр болон хэрэг маргаанд дүн шинжилгээ хийх, хууль хэрэглэх дадал, арга зүй олгох, гэрээ байгуулах, оюутнуудын уг хичээлийг сонирхон судлах идэвхийг өрнүүлэхэд энэ аргын зорилго оршино.

Тохиолдол шинжлэх аргыг яагаад хэрэглэдэг вэ?

- Тоймлосон дүгнэлт, тодорхой үзэл санааг гаргадаг.
- Харьцангуй өндөр түвшинд хийсвэрлэн сэтгэх боломжийг хангадаг.
- Суралцагчдын дотоод сэтгэлгээний дадлага, чадварыг хөгжүүлж, бие



даасан задлан шинжилгээ хийх болон шийдвэр гаргах хүнд бэрх сэтгэн бодох үйлдэлд дасгана.

- Хүний сэтгэл, хөдлөл, мэдрэмжийг таниулахын зэрэгцээ суралцагчдын дүрслэн бодох сонирхол, сэтгэлгээг өдөөдөг.
- Танхимд суралцаж буй суралцагчдыг бодит амьдралын туршлага, жишээтэй сэтгэлгээний хувьд холбоотой байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Суралцагчдад мэдсэн, сурсанаа хэрэглэх боломж олгохын зэрэгцээ хүний эрх, эрх зүйн салбарт шинэ үзэл санаа, ойлголт, зарчмыг хөгжүүлэхэд нөлөөлнө.

Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхэд тавих хязгаарлалт болон санамж:

Хэдийгээр авч байгаа тохиолдол нь бодит байдлын тусгал болдог ч жинхэнэ бодит байдал хараахан биш юм. Нэг ч жишээ жинхэнэ бодит байдлыг орлохгүйг санах хэрэгтэй. Зарим тохиолдолд жинхэнэ байдал дээр шийдвэр гаргахдаа танхимын сургалтын жишээнд үзүүлж хэрэглэх аргагүй тийм үл мэдэгдэм, үл ойлгогдох баримтад үндэслэхэд хүрдэг ч бий.

Сургалтад хэрэглэгдэж буй жишээ бүр нь өөрийн тодорхой үзэл бодол, мэргэжлийн түвшин бүхий хүн /багш/-ээр дамжиж суралцагчдад хүрдгийг мартаж аргагүй. Уг аргыг хэрэглэх нь үлэмж цаг хугацаа шаардана. Энэ нь бусад хичээл, сэдвийн цагт эсрэгээр нөлөөлдөг. Иймээс тохиолдол нь маш сайн шилж авсан, баялаг агуулгатай, өгөөжтэй, суралцагчдын дадлага, чадварыг үнэхээр хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой.

Зөвхөн ганцхан тохиолдлыг шинжилснээр суралцагчид маш том дүгнэлтэд хүрч болох юм. Мөн нэг сэдэв дээр хэд хэдэн жишээ, эсвэл өгсөн жишээн дээрх статистик тоо баримт дээр ажиллах боломжтой. Ердийн танхимын нөхцөлд багш нь энэ аргаар хичээл явуулахад лектор биш ярилцлагыг хөтлөгчийн дүрд тоглох болно. Гэтэл багш бүр энэ үүрэгтээ бэлэн үү? Зарим тохиолдолд хууль, эрх зүй тэр бүр ойлгомжтой биш, тэгээд ч цоорхой ихтэй байдаг. Батлагдсан хуулиудын эдгээр дутагдал нь сургалтын жишээг танхимын нөхцөлд заахад хүндрэлтэй. Ийм тохиолдолд багш, суралцагчид ямар хууль батлагдсан байх ёстой байсан, хуулийг хэрхэн өөрчлөн сайжруулж болох, ийнхүү өөрчлөн сайжруулахад оролцох арга замуудын талаар ярилцахад хүрдэг.

Энэ аргыг хэрэглэхдээ нэг багшид 20-оос илүүгүй оюутан оногдохоор тооцоолох хэрэгтэй бөгөөд илүү олон оюутантай багш нэгэн зэрэг ажилласан тохиолдолд хичээлийн зорилго, үр дүнд муугаар нөлөөлдөг.

Холбогдох гарын авлага /гарын авлага, дасгал, хураамж зэрэг/, материал, хууль тогтоомжоор зайлшгүй хангагдсан байх ёстой бөгөөд энэ шаардлага хангагдаагүй тохиолдолд хичээлийг үр дүнтэй явуулах боломжгүй.

Багшийн хувьд хууль, хяналтын байгууллагад хоёроос дээш жил ажилласан, онол, практикийн өндөр мэдлэг, чадвартай байх учиртай.

Тохиолдлыг бэлтгэх:

Тохиолдлыг сонгож авах болон боловсруулахдаа дараах шалгууруудыг анхаарах хэрэгтэй.

- Хүмүүсийн амьдрал, гэрээний эрх зүйн практикт олонтоо тохиолддог маргаантай асуудлуудыг тусгасан өөрөөр хэлбэл, бодит байдалд туйлын нийцсэн эсэх,
- Суралцагчдад сонирхолтой бөгөөд зохимжтой эсэх,

- Тохиолдолд авсан нөхцөл нь суралцагчдын зүгээс задлан шинжилгээ хийж, өөрсдийн эргэцүүлээ бодож боловсруулах боломж олгохуйц байгаа эсэх,
- Эерэг, сөрөг баримт нотолгоог гаргаж болохуйц тэнцлийг хангаж чадсан эсэх.

Үе шат:

Нэг. Шийдвэр гаргахад бэлтгэх үе

Аливаа шийдвэрийг гаргахад хангалттай сайн мэдээлэл, баримт нотолгоо цуглуулж боловсруулах хэрэгтэй байдаг. үүний нэг адил тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахын тулд ч бэлтгэл ажил хэрэгтэй. Үүнд:

- Тухайн тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг өгөх. Мэдээллийг өгөх олон янзын арга байдаг. Тухайлбал, уншуулах, бага хэмжээний лекц сонсох, видео бичлэг үзэх гэх мэт.
- Тохиолдлыг уншуулах. Энэ үед суралцагчдад тохиолдол /шүүхээр хянан хэлэлцэх ажиллагаа/-ын эцсийн үр дүн, шийдвэрийг мэдээлэхгүй байх хэрэгтэй. Уг асуудлын бодит төгсгөлийг нилээд хожим нь авч үзэх болно. Цаашдаа суралцагчдын анхаарлыг бодит баримтын учрыг олоход чиглүүлэх хэрэгтэй. Юуны түрүүнд тохиолдлын үйл явдлыг сайтар ойлгуулах нь чухал. Дараахь асуултад хариулт авах замаар тэдний ойлголтыг гүнзгийрүүлж болно.
- Уг тохиолдолд /шүүхээр хянан хэлэлцэх ажиллагаа/ чухам юу болсон бэ?
- Уг маргаанд ямар хүмүүс, аль аль талууд оролцсон болох?
- Оролцсон талууд болон хүмүүсийн үйлдсэн, хийсэн зүйл нь чухам ямар учир шалтгааны улмаас үйлдэгдсэн болох?

Ямар нөхцөлүүд чухал болох, ямар баримт, юу дутагдаж байна вэ?

Хичээлийн энэ үед бүх суралцагчид бүгд нэг ижил баримтад тулгуурлах ёстой бөгөөд энэ үндсэн дээрээ идэвхтэй ажиллах ёстой тул багш танд сургалтын энэ шатанд анхааралтай байх нь маш чухал. үүний хамт уншлагын дадал суугаагүй суралцагчдад ч энэ үе нь их ач холбогдол, нөлөөлөлтэй байдаг.

Багшийн зүгээс өөрөө асуулт боловсруулж суралцагчдад тавьж ч болно, эсвэл өөр нэг хувилбар нь тэднээр өөрсдөөр нь ажиллуулж, асуулт боловсруулж ч болох юм. Ингэхдээ хоёр хоёроор нь ажиллуулах бөгөөд нэг нь чухал баримтууд дээр товч дүгнэлт хийж байхад хоёрдахь нь асуултуудыг боловсруулан бэлтгэж байх юм.

Хоёр. Шийдвэр гаргах үе

Суралцагчид хэрэгтэй мэдээллээ авч, тохиолдлыг хангалттай сайн судалж, ойлгосны үндсэн дээр шийдвэр гаргах үйл ажиллагаандаа орно. Тэдний шийдвэр гаргах үйл явцыг багш олон аргаар зохион байгуулж болно.

Гэрээний эрх зүй-2 хичээл нь иргэний эрх зүй, гэрээний эрх зүй-1 хичээлийн нэгэн адилаар амьдралд ойрхон, практикаар байнга шалгагдаж байдаг учир энэ хичээлийг заах гол арга нь тохиолдол шинжлэх арга юм. Энэ аргыг хэрэглэхийн тулд эхлээд оюутнуудад тухайн сэдвээр лекцийн хичээл орж, тодорхой ойлголт огссон байх нь манай өнөөгийн нөхцөлд тохиромжтой.

Дуудлага худалдааны арга

Энэ арга нь оюутнуудад урьдчилан өгөгдсөн мэдлэгийг бататгах, сэргээх, мэдээллийг дүгнэхэд оюутнуудын идэвхитэй оролцоог шаардаж байдаг.



Анхаарах зүйл: тухайн асуудлаар дадал, чадвар төлөвшүүлэх аргуудтай хослуулан хэрэглэхэд тохиромжтой. Ялангуяа мэдээлэл түгээх аль нэг аргыг хэрэглэсний дараагаар оюутнуудад урьдчилан танилцуулсан дүрмийн дагуу уг аргыг ашиглана.

Бэлтгэх материал: 500, 1000, 5000, 10000-ийн дэвсгэртийг орлуулан хийсэн загваруудыг бэлтгэнэ.

Хэрэгжүүлэх дараалал:

- 3-4 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг тус бүрт бэлтгэсэн мөнгийг адил хэмжээтэй өгөөд ашигтай мэдээллийг аль болох хямд үнээр худалдаж авахыг анхааруулна.
- Лекцийн хичээлээр өгөгдсөн мэдээллийг зэрэглэн ангилж, тус бүрийг мөнгөөр урьдчилан үнэлсэн байна.
- Багш өгүүлбэрүүдийг дараалан уншиж үнэ хаялцах ба бүлгүүд тохирсон үнээр худалдаж авсаар мөнгөө дуустал үнэ хаялцана.
- Уг аргын эцэст хамгийн чухал олон мэдээллийг өөрт байгаа мөнгөндөө багтааж авч чадсан бүлэг түрүүлж зохих урамшуулал хүртэнэ. Зарим бүлэг ашиггүй цөөн мэдээллийг бүх мөнгөөрөө авчихсан байдаг зэрэг олон янзын үр дүн гарч болно. Тухайлбал, тодорхой төрлийн гэрээний маргааныг оюутнуудад танилцуулж, оюутнуудаас урьдчилан бэлтгэсний дагуу гэрээний зүйлчлэлүүдийг санал болгон дууддага худалдаа явуулж болно.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга

Энэ арга нь эсрэг, тэсрэг үзэл бодлыг оюутнууд хамтран хэлэлцэх, өөрийн санал бодол, байр суурийг илэрхийлэх, хамгаалах, мэдээлэл солилцох, өрсөлдөгчийн үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх чадвартай болгох зорилготой.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах аргаар хичээлийг явуулахад оюутанд эсрэг, тэсрэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, ойлгож, няцаах, нотолгоог дэвшүүлэх чадвар хөгжих, байр суурь, санал боддоо чөлөөтэй илэрхийлэх чадвар, хандлага төлөвших боломжтой.

Суралцагчдаас, уг хэрэгт тэдний үзэж байгаагаар хамгийн чухал маргаантай асуудлууд нь юу болохыг асууснаар багш уг сэдэвт холбогдолтой хэлэлцүүлэг, ярилцлагаа эхэлж болох юм. Хичээлийг явц, дүнгээс шалтгаалаад олон төрлийн /хууль эрх зүй, төр-нийгмийн бодлогын эсвэл ёс суртахууны эсвэл практикийн холбогдолтой гэх мэт/ асуудлууд гарч болох юм.

Хууль зүйн ажиллагаанд асуултууд нь гол төлөв хууль эрх зүйтэй холбоотой байдаг. Гэвч үүний хамт, дээр дурдсан бусад төрлийн асуултуудыг ч нэгэн адил авч үзнэ. Суралцагчид эхлээд авч үзэж буй тохиолдлын хамгийн маргаантай болох гол зүйлийг нь ойлгох нь чухал бөгөөд үүнгүйгээр тэдэнд уг тохиолдлын бусад зүйлийг ойлгоход бэрхтэй болно.

Багшийн зүгээс суралцагчдын түвшин болон уг аргаар ажиллах дадлага туршлага зэргийг харгалзан өөрөө уг жишээний гол маргаантай хэсгийг нь тайлбарлан ярьж ч болох талтай. Ингэж багшийн эсвэл суралцагчдын өөрсдийн хүчээр тодорхой ойлгож авсан асуудлын гол хэсгийг дараа дараагийн үзэх зүйлүүдээс гоц ялган салгах нь чухал юм.

Үүний дараа суралцагчид баримт, нотолгоо олох, боловсруулах болон тэдний гаргасан баримт нотолгоо нь нэг үзэл санааг дэмжиж, нөгөөг эсэргүүцэх нь ойлгомжтой. Энэ явцдаа тэд олон талыг хамарсан дараах асуудлуудыг хөндөн ярилцаж болно.

Маргалдагч үзэл санаа бүрийг дэмжих буюу эсэргүүцэх ямар баримт, учир шалтгаан байж болох? Аль нь үнэмшил муутай болох? Яагаад?

Энэ асуудлыг өөр арга замаар шийдвэрлэж болох?

Нийгэм болоод маргалдагч талуудын хувьд энэхүү асуудлыг яаж, хэрхэн шийдвэрлэснэр ямар үр дагавар учирч болох?

Баримт нотолгоо, учир шалтгаан болон шийдвэр бүрийн давуу тал нь юу болох?

Суралцагчдыг хууль зүйн баримт, шалтгааныг ашиглах, мөн бизнесийн хууль тогтоомжийн ойлголт, үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээг уг сэдэвтэй холбон үзэж судалж чадаж байгаагийн төлөө, мэдэж байгаагийнх нь хувьд шалгаж урам өгөх нь чухал. Янз бүрийн нотолгоо, баримт, учир шалтгааныг тодруулж хэлэлцэх явцад бусдын буюу өөр нотолгоо, үндэслэлд хүлээцтэй, тэвчээртэй хандах, мөн хэлэлцүүлгийн ил тод байдаг хангасан тийм уур амьсгал бүрдүүлэх нь зохистой байдаг.

Суралцагчдаас шүүн хэлэлцэж буй ямар ч асуудал, санаа бодол, хүсэлт нь эвтэй, зөтэй байдал, маргаан зөрүүтэй аль ч үед адил тэгшээр хэлэлцэгдэж, яригдах ёстойг ойлгосон байх ёстой. Өөрөөр хэлбэл, суралцагчид бусдыгаа сонсдог, үзэл санааг нь хүндэтгэдэг, бодит хандаж, үнэлэлт өгөх чадвартай байна гэсэн үг.

Энэ үешатанд тэдний бүх учир шалтгаан, нотолгоог сонссоны дараа шийдвэр гаргахад анхаарлыг төвлөрүүлэх нь зөв юм. Тэднээс гаргасан шийдвэрийнх нь үндэслэлийг заавал асуух хэрэгтэй. Хэрэв шийдвэрийг багш гаргасан буюу уншиж сонгосон бол дараа нь заавал сурагчдаар үнэлэлт өгүүлэх хэрэгтэй. Тэд багшийн уншсан сэдэвтэй санал нийлж байна уу? үгүй юу? Яагаад? Энэ шийдвэр нь уг ажиллагаанд холбогдогч талуудад хэрхэн тусч байна вэ? Нийгэмд ямар үр дагавар авчрах вэ? гэх мэтээр асуух нь тэдний үнэлэлт, дүгнэлтээ хэлэх боломжийг хангана.

Хэрэв шийдвэрийг суралцагчид өөрсдөө гаргасан бол тэд уг шийдвэрийг гаргах болсон шалтгаан, үндэслэлийг хэрхэн тайлбарлаж байгааг анхаарах нь зүйтэй. Энэ бүхний эцэст, хэрэв авсан тохиолдол нь шүүхээр шийдвэрлэгдсэн бодит хэрэг байсан бол багш шүүхийн шийдвэрийг нь хэлж өгөх нь зүйтэй. үүнийг хийхдээ, суралцагчид зөвхөн байгаа баримтад тулгуурлан өөр шийдвэр гаргаснаараа буруутай мэтээр өөрсдийгөө ойлгох тийм байдал гаргахааргүйгээр хийх нь чухал. үүний тулд багш дараахь загвар асуултуудаас ашиглаж болох юм. Үүнд:

- Суралцагчдын гаргасан болон хуулийн байгууллагын гаргасан шийдвэрүүдийг харьцуулан үзэж, аль нь юуны учир илүү давуутай болохыг хэлнэ үү.
- Шүүх яагаад өөр шийдвэр биш, чухам тэрхүү шийдвэрийг гаргах болов? Энэхүү шийдвэрийг гаргахад ямар учир шалтгаан нөлөөлөв?
- Та нар энэ шийдвэртэй санал хэрхэн нийлж байна вэ? Танд энэ шийдвэр хэрхэн нөлөөлж байна? Бусад хүмүүст бол яаж нөлөөлөх вэ? Энэ шийдвэрийн нөлөө, ач холбогдол ямар байх вэ? гэх мэт.
- Хичээлээр хэлэлцэх маргаантай асуудлыг сонгох шалгуур:
- Асуудлыг олон талаас нь авч хэлэлцэх боломжтой, үнэхээр маргаантай асуудал мөн эсэхийг тогтооно.
- Хуулийг дээдлэхэд болон ардчиллыг хөгжүүлэхэд энэхүү асуудал нь чухал ач холбогдолтой эсэх
- Энэ асуудал нь тухайн ангид хэлэлцэхэд тохиромжтой болон суралцагчдын хувьд ач холбогдолтой эсэх



Маргаантай асуудлыг хэлэлцэхэд баримтлах дүрэм:

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд хувь хүний үзэл бодлыг хөндөх ба сэтгэлийн хөдөлгөөн үүсгэдэг учраас заримдаа түүнийг зохион байгуулалттай дарааллаар хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Иймээс хичээлийг зохион байгуулалт сайтай явуулах, үүссэн маргаантай байдлыг хяналтандаа байлгахад дараахь дүрэм нь багшид тус болно. Тухайлбал,

- Нотолгоо болон багтай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлнэ.
- Цаг барьж, ганцаараа ярихаас зайлсхийнэ.
- Уриа хэрэглэхээс зайлсхийнэ.
- Маргааныг хийсвэр түвшинд хүргэхээсээ өмнө тодорхой асуудлуудаар ярилцана.
- Таны байр сууринд эргэлзэх бололцоог бусаддаа олгоно.
- Өөрийн байр суурийн эргэлзээтэй зүйл, хүнд хэцүү болон сул талуудыг хүлээн зөвшөөрнө.
- Бусдын санааг өөрчлөн хэлэх замаар ойлгож сурна. Ийм дадалтай болгохын тулд бусдаас сонссоноо өөрчлөн хэлж сурна. Үзэл бодол болгонд хүндэтгэлтэй хандана.

Хэрэгжүүлэх дараалал:

- Ангийн булангуудад хэлэлцэх асуудлын сэдвээс хамааран "Санал бүрэн нийлж байна", "Санал нийлж байна", "Шийдээгүй буюу эргэлзэж байна", "Ханал нийлэхгүй байна", "Санал бүрэн нийлэхгүй байна" эсвэл "Маш зөв", "Зөв", "Буруу", "Маш буруу" гэсэн бичиг бүхий цаасыг дээрх дарааллаар байрлуулсан байна.
- Энэ дасгал ажлыг хэрхэн хийх талаар дүрэм зохиогоод түүнийгээ хэлэлцэж батална.
- Хэлэлцэж буй асуудлын хүрээнд суралцагчид өөрсдийн байр суурийг илтгэсэн бичиг бүхий буланд очиж зогсоно.
- Суралцагчдыг өөрсдийн байр суурийг тодруулж тайлбарлахыг хүснэ. Бүх суралцагчдыг хамруулах үүднээс ижил сонголттой сурагчид нэг багийг үүсгэж ярилцаад байр сууриа танилцуулахад бэлдэнэ.
- Өөрсдийн байр суурийг тайлбарласны дараа хэн нэг нь байр сууриа өөрчилж өөр буланд очихыг хүсэж байгаа эсэхийг асууна. Хэрэв өөрчлөх хүсэлтэй хүн гарвал яагаад ингэх болсон шалтгааныг асууна.
- Эсрэг баримтлалуудын дэвшүүлсэн үндэслэлээс аль нь хамгийн үнэмшилтэй байсныг асууна.

Мэдлэгийн өртөөний арга

Мэдлэгийн өртөөний арга нь оюутнуудад олон талт, ижил төстэй ойлголтуудыг нэг дор, багцлан хүргэх, харилцан бие биенээсээ мэдээлэл авч, санал солилцоход тохиромжтой арга юм. Энэ арга нь заах аргыг хөдөлгөөнт байдалд оруулдаг төдийгүй сургалтын явцыг идэвхижүүлэх, тоглоомын аргуудтай хослон хэрэглэгдэх боломжтой умраас оюутнуудыг залхаах, уйдаах, улмаар сургалтын дүнд сөргөөр нөлөөлөх байдалд хүргэхгүй талтай.

Энэ арга нь хичээлийн бүлэг сэдвийг үзэж дууссаны дараагаар дугнэлт хичээл явуулах эсвэл нээлттэй хичээл, бүх анги, курсыг хамарсан өдөрлөг байдлаар хичээлийг явуулахад боломжтой.

Өртөөчилсөн арга нь гэрээний эрх зүй хичээлийн хүрээнд хоорондоо адил төсөөтэй бөгөөд нэг бүлэг сэдэвт хамаарах өргөн агуулгатай хичээлд хэрэглэвэл илүү тохиромжтой. Тухайлбал, бусдын эзэмшил, ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг сэдвээр энэ аргыг ашиглан семинарын хичээлийг явуулахад эд хөрөнгө хөлслөх гэрээ, орон сууц хөлслөх гэрээ, түрээсийн гэрээ, лизингийн гэрээ, франчайзийн гэрээ, эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах гэрээ гэсэн сэдвээр нэрлэгдсэн өртөөнүүдэд хувааж өртөөчлөн сургалтыг явуулах боломжтой юм.

Энэ аргыг хэрэглэхэд багшийн зүгээс анхаарах хэд хэдэн зүйл бий. Үүнд:

- Мэдлэгийн өртөө бүрийн хэрэглэгдэхүүн нь оюутнуудад зөвхөн мэдээлээд зогсохгүй, өөрсдөө оролцон суралцахад зориулан бэлтгэгдсэн байх,
- Мэдээлэл болон мэдлэгийн өртөөг хэрхэн ашиглаж, үр дүнд хүрч байгаа эсэхийг сургагч оюутнуудын тусламжтайгаар багш хянаж байх,
- Сургагч оюутнаас өгөх мэдээлэл, оюутнуудын өөрсдөө олж авах мэдээлэл үнэн зөв, бодитой болж байгааг багш хянах, үүний тулд мэдээлэл болон оролцооны аргыг урьдчилан нягт боловсруулах.

Багш болон сургагч оюутан хариуцлагатай ажиллах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хайхрамжгүй байх, тоомжиргүй хандах нь бодитой бус мэдээлэл түгээгдэх, сургалтын аргыг үр дүнгүй болоход хүргэнэ.

Мэдлэгийн өртөө аргын аргачлал:

- Юуны өмнө ямар сэдвүүдээр хичээл явуулахыг төлөвлөн уг сэдвүүдээр нэрлэгдсэн мэдлэгийн өртөөнүүдийг байгуулна. Өртөө бүрийн сургагч оюутнуудыг /өртөө бүрт 2/ багш урьдчилан бэлтгэх бөгөөд тухайн асуудлаар мэдлэг түгээх, тайлбарлах, оюутнуудыг хичээлд татан оролцуулах бүх талын бэлтгэлийг хангана.
- Сургагч оюутнуудтай хамтран өртөө бүрт байх самбар, танилцуулах хуудас, тараах материалыг урьдчилан сайтар бэлтгэвэл зохино.
- Өртөө бүрт байх самбаруудыг тойрог хэлбэрээр байрлуулж, нүүрийг нь гадагш харуулах нь өөр өөр өртөөнд ажиллаж байгаа багт саад болохгүй сайн талтай.
- Олон хүнийг нэгэн зэрэг ажиллуулах нь эмх замбараагүй байдлыг бий болгох талтай ч энэ асуудаар багш хариуцлагатай ажиллана.
- Өртөө бүрийн сургагч оюутнууд харилцан уялдаатай, зэрэг ажиллах нь чухал. Өртөөнд байх цагийг урьдчилан тогтооно /оролцогчдын тоо, сэдвээс хамаарч/.
- Оюутнуудыг хэд хэдэн /5 бол тохиромжтой/ дэд бүлэгт тухайн ангийн тоонд багтаан /30-50 тохиромжтой/ хуваана. Бүлгүүдийг урин өртөөчлөх аргын журам, аргачлал, аялалын замыг тайлбарлаж өгнө.
- Өртөө бүрт шаардлагатай мэдээллийг ямар нэг хэлбэрээр түгээх, харилцан ярилцах, санал боддоо солилцох, тодорхой тохиолдол дээр ажиллан, оюутнууд өөрсдөө оролцох байдлаар мэдлэг бүтээгдвэл зохино. Өртөө бүрийн эцэст санал асуулгын хуудас, эхний болон эцсийн урьдчилан бэлтгэсэн хялбар сорилоор мэдлэгийг үнэлж, үр дүнгээ хэлэлцэнэ.




Энэ арга нь урьдчилан бэлтгэх хэрэглэгдэхүүн ихтэй, сургагч оюутан, багшаас идэвхтэй хариуцлагатай ажиллагааг ихээхэн шаардлаг ч бүлэг сэдвээр нэгэн зэрэг мэдээлэл түгээх, оюутнуудыг татан оролцуулах, харилцан санал солилцох, адил төсөөтэй асуудлыг нэгэн дор харьцуулан ойлгоход ихээхэн тустай юм.

Энэ аргыг гэрээний эрх зүйн хүрээнд маргаантай асуудлын учир шалтгааныг олж тогтоох, оюутнуудаар олон талт асуудлыг хэлэлцүүлэн сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор хэрэглэнэ.

Яагаад модны арга


Яагаад, яагаад, яагаад буюу таван яагаадын аргачлал хэмээх дээрх аргын тусламжтайгаар талууд /багууд/ тухайн асуудлын учир шалтгааны гинжийг тодорхойлдог. Нэг гинжийн хүрээнд бүх шалтгааныг олж тогтоогоод яагаад гэсэн асуултад өөр хариулт олдохгүй болсон үед дахин огт өөр шалтгааныг авч түүнд яагаад асуулт тавин хариулах байдлаар ажиллана.



Шалтгаан үр дагаврын зураглал /Ишикавагийн зураглал буюу загасан ясны зураглал/

Зорилго: Аливаа асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хүчин зүйлсийг эрэмбэлэх, шалтгааныг тодорхойлох, оюутныг бүтээлчээр, идэвхтэй оролцуулах.

Тухайлбал: Гэрээ болон хэлцлийн харилцан хамаарал сэдвийг уг аргаар шинжилж болно.



Жижиг багаар ажиллах

Жижиг багаар ажиллах энэхүү арга нь бусдыг анхааралтай сонсох, нэгдсэн дүгнэлтэд хүрэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах, багаа төлөөлөх зэрэг чадварыг амьдралд хэрэглэх боломжийг оюутанд олгоно.

Зорилго:

Хамтран ажиллах болон бусдыг ойлгох зэрэг чухал чадваруудыг эзэмших боломжийг олгодгоос гадна өөр хоорондоо зөрүүтэй бодол санааг нийцүүлэхэд тусалдаг. Багаар ажиллахаддасгал дээр ажиллуулах шаардлага зүй ёсоор тулгардаг. Энэ тохиолдолд оюутнууд гэрээний эрх зүй хичээлээр үзсэн ойлголтоо амьдралд хэрэглэх чадварыг суулгахын тулд тодорхой сэдэв сонгон авч дасгалыг бэлтгэнэ.

Жижиг багаар ажиллуулахад юуг анхаарах хэрэгтэй вэ?

- Суралцагчид тухайн ажлыг гүйцэтгэх мэдлэг, дадал, чадвар эзэмшсэн байх ёстой. Эзэмшээгүй тохиолдолд тэд тухайн даалгаврыг хийж гүйцэтгэх ямар ч сонирхолгүй байх тул та үүнийг нэн түрүүнд мэдэх шаардлагатай.
- Багт зааварчилгааг маш тодорхой өгөх ёстой. Нэг дор /хэдий маш тодорхой ч/ хоёроос дээш зааварчилгаа өгөхгүй байх.
- Жижиг багт тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд хангалттай цаг хугацаа олгох ёстой. Түрүүлж ажлаа дуусгасан багийг бусаддаа саад болгохгүйн тулд юу хийлгэхээ сайтар төлөвлөсөн байна.
- 3-6 гишүүнтэй баг бүрдүүлэх. Жижиг багийн хувьд 6 гишүүнтэй байх нь хамгийн дээд хэмжээ байна.
- Бие дааж болон хамтаараа ажиллах чадварыг зэрэг хөгжүүлэх буюу тэнцвэртэй байлгахыг зорьсон асуудал, даалгаврыг өгөх ёсгүй. Учир нь жижиг багаар ажиллах аргыг ширээ торйон сууж бие даан ажиллах чадварыг бус хамтаар ажиллах чадварыг хөгжүүлэхэд л ашиглах нь илүү тохиромжтой байдаг.

Энэ аргыг тодорхой зорилготойгоор, тохиромжтой үед, дүрмийн дагуу хэрэглэх ёстой болохоос биш зөвхөн лекцийг орлуулах нэг арга болгон ашиглаж үл болно.

Баг доторхи удирддагын асуудлыг мөн тооцож үзэх ёстой. Багаас нэг гишүүн хийсэн зүйлээ танилцуулах тохиолдолд тэр суралцагчийг шударгаар сонгоход анхаарах.

Багаар ажиллахад гарах дуу чимээг хүлээн зөвшөөрөх ёстой.

Жижиг багаар ажиллах явцад суралцагчид бие биөнийхээ нүдийг харах боломжтой байдлаар суусан байна. Гишүүн тус бүр бусад гишүүдээ төвөггүйгээр харж, харьцах ёстой.

Жижиг багаар ажиллахад бүлэг болгон хуваахдаа багш тодорхой асуудлуудыг анхаарч үзэх хэрэгтэй байдаг. Хэрвээ оюутнуудыг хүсэлтээр нь багт хуваагдан ажиллахыг хүсвэл өөрт илүү ойр дотно хүмүүсийг сонгон энэ нь хичээлийн үр дүнд төдийлөн сайнаар нөлөөлөхгүй. үүнээс зайлсхийхийн тулд дараахь арга барилыг ашиглах боломжтой. үүнд:

- Оролцогчдыг хэдэн бүлэгт хуваах гэж байгаа тоогоороо дараалуулан тоолуулах,
- Оролцогчдыг төрсөн он, сар, нэрийн эхний үсэг, ордынх нь нэрээр жагсаан зогсоох,
- Оролцогчдыг урьд өмнө хамтран ажиллаж байгаагүй хэн нэгнийг сонгохыг хүсэх,
- Өөр өөр өнгийн карт, дүрс өгөөд ижил өнгийн карт, дүрстэй хүмүүсийг нэг бүлэг болохыг хүсэх,
- Дугаар бүхий цаас тараан өгч өрөөн дотуур ижил тоотой цаас бүхий хүнийг олох гэх мэт



Сургалтыг идэвхжүүлэхэд чиглэсэн арга, дасгал

Сургалтын арга зүйд мэдээлэл түгээх, оролцооны зэрэг дээр дурдсан аргуудаас гадна тэдгээртэй хослуулан сургалтын явцад оюутнуудыг идэвхжүүлэх, өдөөх, анхаарал төвлөрүүлэх зорилгоор тусгай арга, дасгалуудыг хэрэглэх нь зүйтэй. Гэхдээ аль аргыг ямар сэдэв бүхий хичээл дээр, ямар аргуудтай хослуулан хэрэглэх талаар багш урьдчилан бэлтгэж, төлөвлөх хэрэгтэй.

Сургалтыг идэвхижүүлэх арга, дасгалуудыг гэрээний эрх зүй хичээлийн агуулгатай уялдуулан багш өөрийн арга барилаар баяжуулан хэрэглэж болно.

Мөс хайлуулах буюу танилцах дасгал

а/. Цасан өнхрүүш

Зорилго: Оюутнуудыг идэвхжүүлэх, алжаалыг тайлах, бие биөнийхээ нэрийг мэдэх,

Анхаарах зүйл: Жижиг багаар ажиллах үед тохиромжтой

Оролцогч бүр нэрээ хэлэхээс гадна нэрнийхээ үсгээр эхэлсэн ямар нэгэн тэмдэг нэр бодож олно. Тухайн хүний хувийн шиж чанарыг тодорхойлсон тэмдэг нэр байх нь чухал. Оролцогчид нэгэндээ тэмдэг нэр хэлж өгөх, давхцаж байгаа эсэхэд анхаарал хандуулах нь чухал. Дасгал дараах байдлаар явагдана. Үүнд: оролцогч эхлээд өмнөх хүнийхээ нэр, нэрний үсгээр эхэлсэн тэмдэг нэр хэлээд дараа нь өөрийн нэр, нэрний үсгээр эхэлсэн тэмдэг нэрийг хэлнэ. Дараагийн оролцогч түрүүчийн оролцогчийн хэлсэнийг бүгдийг давтаж хэлээд дараа нь өөрийн нэр, тэмдэг нэрийг мөн хэлнэ. Дасгал ийм маягаар цааш үргэлжилсээр сүүлчийн хүн бүх оролцогчийн нэр, тэмдэг нэрийг давтан хэлээд өөрийн нэр, тэмдэг нэрийг хэлнэ.

б/. Бөмбөг

Зорилго: Оюутнуудыг идэвхжүүлэх, алжаалыг тайлах, бие биөнийхээ нэрийг мэдэх,

Материал: Жижиг бөмбөг

Дасгал дараахь байдлаар явагдана.

Бүх оролцогчид тойрог болон зогсоно. Дасгалыг эхлэхдээ өөрийн нэр болон хэн нэгний нэрийг хэлэнгээ тэр хүн рүүгээ бөмбөгөө шиднэ. Бөмбөг авсан хүн өөрийн нэрээ мөн бөмбөгөө дамжуулах хүний нэрийг хэлэнгүүтээ бөмбөгөө шидэх байдлаар тоглоом өрнөх ба оролцогчид нэгнийхээ нэрийг лавлаж асуухгүйгээр, мөн бөмбөгөө хурдан дамжуулдаг болтол үргэлжлүүлэн тоглож болно.

Солилцооны арга

Зорилго: Тодорхой асуудлыг шинжлэхэд оролцогчдыг бүгдийг хамруулах, идэвхжүүлэх, бие даан асуудал дэвшүүлэн дүгнэх, шүүмжлэн хэлэлцэх

Анхаарах зүйл: Оролцогчид баг дотроо шийдвэрлэх асуудлаа зураг, график, хүснэгт гэх мэт аргуудаар илэрхийлэн хамтран ажиллана.

Хэрэгжүүлэх дараалал:

- Багийн гишүүдийг дугаарлана,
- Багшийн хэлсэн тоо, эсвэл оюутан өөрсдөө хэн нэгнийгээ сонгон багтаа үлдээж, үлдсэн хэсэг нь бусад багийн ажилтай танилцахаар явна. Энэ үедээ бүх багийн ажлыг тойрон явж танилцахаас гадна асуулт асууж, өөрсдийн саналыг хэлнэ.
- Багтаа үлдсэн хүн өөр багаас ирж байгаа хүмүүст өөрсдийн хийсэн ажлаа танилцуулна. Бүх оролцогчид өөрсдийн багтаа эргэн ирж, багтаа үлдсэн хүндээ бусдын санал бодлыг танилцуулж ярилцана. Багууд хийсэн ажлаа дахин хянаж, нэмэх, хасах зүйлийг тодорхойлон ажлаа нэгтгэнэ.

Марафон бичлэгийн арга

Энэ арга нь бага хугацаанд олон хүний саналыг гаргах, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой оролцооны арга юм.

Анхаарах зүйл: Тодорхой сэдэв үзсэний дараагаар хэрэглэж оюутнуудаар дүн шинжилгээ хийлгэнэ.

Хэрэгжүүлэх дараалал:

- Сургалтын агуулгыг харгалзсан оновчтой асуултыг урьдчилан бэлтгэнэ.
- Дээрх асуултад багийн гишүүн бүр нэг хуудас цаасан дээр өөрийн хариултаа бичээд баруун гар талын хүн рүүгээ дамжуулна. Ингээд анхны бичсэн хуудас эхний хүн дээр иртэл дамжуулна.
- Хариултауд нэлээд зөрүүтэй байвал баг дотроо ярилцах замаар цааш үргэлжлүүлж болно. Хэрвээ багийн гишүүд бүр бүгд ижил хариулт бичсэн байвал эхний хүнийг урамшуулж болно.

Марафон бичлэгийн аргыг аль болох хурдан хугацаанд тодорхой асуудлыг дүгнэн хэлэлцэх, оюутнуудыг идэвхижүүлэх, анхаарлыг төвлөрүүлэх болон хичээлийн төгсгөлд дүгнэх байдлаар хэрэглэхэд тохиромжтой.

Загвар хичээл. Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээний онцлог

Ажил гүйцэтгэх гэрээний төрлүүд, тэдгээрийн онцлог, нийтлэг тал, гарах үр дагаврыг танин мэдсэний үндсэн дээр тухайн төрлийн гэрээг байгуулах, хэрэглэх чадвар эзэмшин, цаашилбал тодорхой төрлийн гэрээг гүнзгийрүүлэн судлах бэлтгэлтэй болоход оршино

Хичээлийн агуулга:

- Ажил гүйцэтгэх гэрээний ойлголт, үндсэн шинж, төрөл, онцлог
- Ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, хөдөлмөрийн гэрээний ялгаатай ба төсөөтэй тал
- Ажил гүйцэтгэх гэрээний элементүүд
- Ажил гүйцэтгэх гэрээний төрөл, онцлог
- Талуудын эрх үүрэг
- Гэрээг зөрчсөнөөс үүсэх үр дагавар



Хичээлээр тавигдах асуулт:

- Өгөгдсөн тохиолдол дээр ажиллан ямар төрлийн гэрээ болохийг тодорхойлон тайлбар хийнэ үү?
- Гэрээний өгөгдсөн загварт талууд хүсэл зоригоо зөв илэрхийлж, хүссэн хууль зүйн үр дагавартаа хүрсэн эсэхэд дүгнэлт хийн хэрхэн талуудын ашиг сонирхолыг зохистой адил тэгш хангах талаар зөвлөмж бичнэ үү?
- Барилгын ажил гүйцэтгэх гэрээний бодит тохиолдол олж анализ хийнэ үү?
- Бүтээл туурвих ажил гүйцэтгэх гэрээний загвар боловсруулна уу?

Санал болгож буй арга:

- Дуудлага худалдааны арга
- Жижиг багаар ажиллах арга

Энэхүү сэдвээр хичээлийг явуул ахдаа дуудлага худалдааны аргыг жижиг бүлгээр ажиллах аргачлалыг хамт хэрэглэнэ.

Дуудлага худалдааны арга нь оюутнуудад урьдчилан өгөгдсөн мэдлэгийг бататгах, сэргээх, мэдээтлийг дүгнэхэд оюутнуудын идэвхитэй оролцоог шаардаж байдаг.

Анхаарах зүйл: Тухайн асуудлаар дадал, чадвар төлөвшүүлэх аргуудтай хослуулан хэрэглэхэд тохиромжтой.

Бэлтгэх материал: 500, 1000, 5000, 10000-ийн дэвсгэртийг орлуулан хийсэн загваруудыг бэлтгэнэ. Багш дээр дурьдсан гэрээний болон туслалцаа үзүүлэх, бусдын эзэмшил, ашиглалтанд эд хөрөнгө шилжүүлэх гэрээний гол нөхцөлд орох үндэслэлүүдээс тусгай цаасан дээр /том/ буулгасан байна.

Хэрэгжүүлэх дараалал:

- Ангийг 4-6 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг болгоно. Бүлэг тус бүрт бэлтгэсэн мөнгийг адил хэмжээтэй өгөөд ашигтай мэдээллийг аль болох хямд үнээр худалдаж авахыг анхааруулна. Гэхдээ дээр дурьдсан 3 гэрээний аль нэгийг тухайн бүлэг сонгосон байна. Дуудлага худалдаанд оролцоходоо өөрийн багийн сонгосон гэрээнд нийцэх нөхцлийг худалдаж авна.
- Лекцийн хичээлээр өгөгдсөн мэдээллийг зэрэглэн ангилж, тус бүрийг мөнгөөр урьдчилан үнэлсэн байна.
- Багш үгүүдийг дараалан уншиж үнэ хаялцах ба бүлгүүд тохирсон үнээр худалдаж авсаар мөнгөө дуустал үнэ хаялцана.

Уг аргын эцэст хамгийн олон мэдээллийг өөрт байгаа мөнгөндөө багтааж авч чадсан бүлэг түрүүлж зохих урамшуулал хүртэж болно. Зарим бүлэг ашиггүй цөөн мэдээллийг бүх мөнгөөрөө авчихсан байдаг зэрэг олон янзын үр дүн гарч болно.

Тухайлбал, тодорхой төрлийн гэрээний маргааныг оюутнуудад танилцуулж, оюутнуудаас урьдчилан бэлтгэсний дагуу гэрээний зүйлчлэлүүдийг санал болгон дуудлага худалдаа явуулж болно. Үүний дараа худалдаж авсан мэдээллээ дэс дараалалд оруулж, сонголт хийсэн гэрээний үндсэн шинж, гол нөхцөл нь юу болох талаар өөрсдийн материалд тулгуурлан эргэж ангид мэдээнэ. Багш багуудын дуудлага худалдааны явц болон багийн ажилд дүгнэлт өгнө.

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ-2 ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний зорилго

Гэрээний эрх зүй-2 хичээлийн явцад олж авсан мэдлэг, түүнийг практикт ашиглах чадвар хийгээд оюуны үнэт зүйлийн баримжаалалд гарсан өөрчлөлтийг бодитойгоор үнэлэхэд уг хичээлийн үнэлгээний гол зорилго оршино. Үнэлгээ нь бүхэлдээ зорилгодоо хүрч чадсан эсэхийг илрүүлэхэд чиглэгдэнэ.

Багш үнэлгээний дүнг дараахь зорилгоор ашиглана:

- давтан судлах шаардлагатай эсэхийг тогтоох
- сурч боловсрох эрмэлзлэлийг идэвхижүүлэх
- сургалтын үр дүнд хүрэх явцад оюутны мэдлэг, чадвар ямар түвшинд байгааг тодорхойлох
- багш өөрийгөө болон хичээл зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх

Үнэлгээний шалгуур

Үнэлэх зүйл	Үнэлэх жишиг шалгуур
Мэдлэг	- тодорхой асуултанд онолын үндэстэй хариулж чадаж байгаа эсэх - мэдлэгээ бусдад танилцуулж, тайлбарлаж чадаж байгаа эсэх - тухайн судлагдахууны тодорхойлолт гаргах, үндсэн ба үндсэн бусыг ялгах, харьцуулалт хийх, хамаарлыг тогтоох арга зүйг эзэмшсэн эсэх - хариулт болон үзэл бодлынхоо үндэслэл нотолгоог гаргаж байгаа байдал
Чадвар	- тодорхой онолын мэдлэгийг ашиглан (үндэслэл, нотолгоо болгох, жишээ баримт татах, тайлбарлах) тухайн асуудлыг тайлбарлаж, шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх - бодлого бодох, тохиолдол шийдвэрлэхдээ гэрээний эрх зүйн онолын мэдлэгээ ашиглаж чадаж байгаа эсэх - баримт бичиг боловсруулах чадварт суралцсан байдал - амаар болон бичгээр өөрийгөө ил илэрхийлэх чадварын хөгжлийн түвшин
Хандлага	- өөрийн үзэл бодол байр суурь, үнэлгээ дүгнэлтийг илэрхийлж чадаж байгаа эсэх, ийнхүү илэрхийлэхдээ бусдын үзэл бодол, байр сууринд хүндэтгэлтэй хандаж, түүнээс үнэ цэнэтэй зүйлийг олж харж, авч чадаж байгаа эсэх - багийн гишүүн байх, бусдыг төлөөлөх чадварын хөгжилт ялгаатай үзэл бодол байр сууринд хандах хандлага, түүнийг хүлээн зөвшөөрч байгаа байдал



Дээрхээс тадна оюутны мэдлэг, чадварын түвшнийг дараахь байдлаар ангилан, үнэлгээг ялгавартай тогтоож байх нь зүйтэй. үүнийг хамгийн энгийн буюу доод түвшнээс хамгийн төвөгтэй буюу дээд түвшинд хүрэх дарааллаар тодорхойлж болно. Үүнд:

Мэдлэг	Хамгийн доод түвшин. Голчлон тодорхой баримт, мэдээллийг тогтоож авах, сэргээн санах чадварыг авч үзнэ.
Ойлгоц	Өөрөө анхлан сэдэж олсон бус, өөрөөр хэлбэл, бусдын олж тогтоосон зүйлсийг оюутан наад захын түвшинд ойлгосон болохыг харуулж буй тайлбарлах, өөрийн үгээр илэрхийлэх, ургуулан бодож дүгнэлт хийх зэрэг чадвар юм.
Хэрэглээ	Оюутан мэдэж авсан ойлголт, зүй тогтол зэргийг урьд тохиолдож байгаагүй шинэ нөхцөл байдал, мөн практикийн тодорхой тохиолдолд хэрэглэх чадвар.
Анализ	Мэдээллийг бүрэлдхүүн хэсгүүдэд нь задлан хувааж, ялгаж зааглахыг хэлнэ.
Синтез	Бүрэлдхүүн хэсгүүдийг нэгтгэн бүхэл зүйл бий болгохыг хэлнэ. Оюутан урьд нь байгаагүй бүтцийн шинэ хувилбарыг бүтээх чадвартай байх ёстой.
Үнэлэлт	Хамгийн дээд түвшин. Бусдын бүтээсэн зүйл, түүний логик бүтэц, үндэслэл нотолгоо нь бүрэн гүйцэд хийгдсэн эсэхэд үнэлгээ өгөх зэргийг ойлгоно.

Дээрх чадварын түвшинг дотор нь дараах байдлаар ангилж болно. үүнд:

Сургалтын зорилго	Оюутны чадвар
заавал эзэмшсэн байвал зохих (essential)	мэдлэг, ойлгоц, хэрэглээ
Эзэмшсэн байвал сайшаалтай (desirable)	анализ, синтез, үнэлгээ

Сэдвийн жишиг үнэлгээ. Хадгалалтын гэрээ, барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээ

Зорилго: Гэрээний үүргийн тусгай төрлүүд болох хадгалалтын гэрээ, барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээний эрх зүйн зохицуулалтыг танин мэдэж, уг гэрээнүүдийг гэрээний үүргийн бусад төрөл, төсөөтэй гэрээнээс ялгаж зүйлчлэх чадвар эзэмшин, гэрээг байгуулах, гэрээний маргааныг шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх явцад хууль зүйн үнэлэлт өгөх дадал, хандлага эзэмшихэд оршино.

Мэдлэг үнэлэх шалгуур:

- Сэдвийн хүрээнд өртөгдөж байгаа нэр томъёоны агуулгыг мэдэж байгаа
- Хадгалалтын гэрээний ойлголт, онцлог, гэрээний агуулга, хариуцлага, хууль зүйн үр дагаврын талаар мэдлэгтэй байгаа эсэх
- Зочид буудалд эд зүйл үлдээх, түүнээс гарах хууль зүйн үр дагаврыг хадгалалтын ердийн гэрээнээс ялгаж тодорхойлон, энэ талаарх хуулийн зохицуулалтыг мэдэж байгаа эсэх
- Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээний эрх зүйн зохицуулалт, хууль зүйн үр дагаврыг танин мэдэж байгаа эсэх
- Агуулахын баримтын хууль зүйн ач холбогдлыг танин мэдсэн эсэх

Чадвар үнэлэх шалгуур:

- Хадгалалтын гэрээ байгуулан, түүнд заавал байх буюу гол, ердийн нөхцөлүүдийг зааглан тусгах чадвар эзэмшсэн эсэх,
- Хадгалалтын гэрээний онцлог төрлүүд буюу барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах, зочид буудал, амралт сувиллын газарт эд зүйл хадгалуулах зэрэг гэрээнд байх онцлог шинжийг харьцуулан тодорхойлох, ялгаж зүйлчлэх чадвар эзэмшсэн эсэх,
- Хадгалалтын гэрээг бусад төсөөтэй гэрээнээс ялгаж зүйлчлэх чадвар эзэмшсэн эсэх,
- Хадгалалтын гэрээнээс үүдэлтэй тодорхой маргаанд холбогдох хуулийг зүйлчлэх хууль зүйн зөвлөгөө өгөх чадвартай эсэх

Хандлага үнэлэх шалгуур:

- Хадгалалтын гэрээнээс үүдэлтэй хэрэг маргаанд үнэлэлт өгөх, бусдад хууль зүйн туслалцаа үзүүлэх явцдаа холбогдох хууль тогтоомж, гэрээний зохицуулалтыг үнэлж үзэх, энэ үндсэн дээр өөрийн шийдвэрт баттай зогсох, итгэл үнэмшилтэй байх ханддага төлөвшсөн эсэх,
- Гэрээг зүйлчлэхдээ зөвхөн нэг бус хэд хэдэн ялгах шинжийг тодорхойлон, харьцуулан үзэх, асуудлыг олон хувилбартайгаар үнэлж үзэн дүгнэлт хийхдээ бусдын шийддийг хүндэтгэх,
- Гэрээний загвар боловсруулах, гэрээ байгуулах болон бусдыг төлөөлөхдөө холбогдох хуулийн үзэл санаа, зорилгод харшлахгүй байх гэсэн байр сууринаас хандаж байгаа эсэх

Мэдлэг, чадварын тувшинг ялгавартай үнэлэх жишиг:

Мэдлэг	25 хувь
Ойлгоц	40 хувь
Хэрэглээ	55 хувь
Анализ	70 хувь
Синтез	85 хувь
Үнэлэлт	100 хувь



Зөвлөмж

Оюутан өөрийн мэдлэгийн түвшинг харуулах боломжийг олон арга хэлбэрээр нээлттэй болгох хэрэгтэй. Асуултад хариулах, багшаас асуулт асуух, бусад оюутны өгсөн хариултад тайлбар, шүүмж хэлэх, эссэ бичих, бодлого бодох, тохиолдол шинжлэх, шинэлэг мэдээлэл цуглуулж, дүгнэлт хийх, түүнийгээ бусад оюутнуудад танилцуулах гэх мэт арга хэлбэр байж болно. Эдгээрийн аль ч хэлбэрийг сонгосон оюутны мэдлэгийг дээрх зургаан түвшинд ялгавартай үнэлэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, бичгээр хийсэн ажлыг илүү хөдөлмөр зарцуулсан гэж үзэн илүүтэй үнэлэх хандлагаас зайлсхийвэл зохино. Оюутан хорин хуудас эссэ бичсэн боловч агуулга нь зөвхөн хамгийн доод буюу мэдлэгийн түвшинд эсвэл эсрэгээр хамгийн дээд буюу үнэлэлтийн түвшинд байж болох учраас оюутны хөдөлмөрийг бодитой дүгнэхийг багш байнга чухалчилж байх нь үнэлгээний зорилгыг хангахад өндөр ач холбогдолтой юм.

Хяналтын асуулт:

- Хадгалалтын гэрээний ойлголт, эрх зүйн зохицуулалтын онцлогыг та хэрхэн ойлгож байна вэ?
- Хадгалалтын гэрээ нь субъект, объект, агуулгаараа туслалцаа үзүүлэх болон бусдын эзэмшл, ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой бусад гэрээний үүргээс хэрхэн ялгагдаж байгааг тодорхой тохиолдолд анализ хийн хэлэлцэнэ үү?
- Хадгалалтын гэрээний дагуу практикт гарч байгаа маргааныг хэлэлцэн уг гэрээг байгуулах болон гэрээний зүйлчлэлд ямар алдаа гарч байгааг ярилцаарай.
- Хадгалалтын гэрээний загвар боловсруулан төрлийн шинжтэй эд хөрөнгө хадгалуулах, эд хөрөнгийг нийлүүлж хадгалах асуудлыг хэрхэн тусгах талаар харилцан бие биедээ зөвлөгөө өгнө үү?
- Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээ, ердийн хадгалалтын гэрээг харьцуулан онцлогийг тодорхойлно уу?
- Агуулахын баримтаар хадгалалтын зүйлийг эзэмшигчийн эрх хэрхэн тодорхойлогдож байгаа болон ач холбогдлыг дүгнээрэй.
- Хадгалалтын гэрээг бусдын эд хөрөнгийг үнэ төлбөргүйгээр ашиглах гэрээ, даалгаврын гэрээнээс хэрхэн, ямар шинжээр нь ялгаж зүйлчлэх талаар тохиолдол шинжилнэ үү?
- Худалдах, худалдан авах гэрээ, тээвэрлэлтийн гэрээ болон бусад гэрээний дагуу хадгалалтын гэрээ үүсдэг хэм хэмжээг түүвэрлэн хууль зүйн туслалцаа үзүүлэх, гэрээний төсөл боловсруулах, маргаантай асуудлыг шийдвэрлэх дадлага ажил, загвар шүүх хуралдаан зохион байгуулаарай.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ-2 ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

I бүлэг. БУСДЫН ӨМЧЛӨЛД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Бүлгийн зорилго: Гэрээний нэг талаас нөгөө талын өмчлөлд эрхийн болон биет байдлын доголдолгүй хөрөнгө шилжүүлэх, нөгөө тал нь төлбөр төлөх үүрэг хүлээдэг гэрээнүүдийн болон гэрээний үүргийн эрх зүйн зохицуулалтын талаар суурь мэдлэг олж, тухайн төрлийн гэрээ байгуулах, гэрээний зүйлээс хамааран тавигдах хууль зүйн шаардлагуудыг тодорхой гэрээ байгуулахад хэрэглэх чадвар эзэмшиж, тухайн төрлийн гэрээнээс үүдэн гарах маргааныг шийдвэрлэх, зөвлөгөө өгөх дадалтай болж хууль ёс, шударга ёс, гэрээний тэгш байдлыг хангах хандлага төлөвшинө.

1. Худалдах, худалдан авах гэрээ

Сэдвийн зорилго: Бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэх гэрээний үүргийн гол төрөл болох худалдах, худалдан авах гэрээ, түүний төрлүүд болон арилжааны гэрээний нөхцөл, онцлогийн талаар онол-практикийн мэдлэг эзэмшиж, тухайн гэрээг байгуулах чадвартай болно.



Нэр томъёоны тайлбар

Худалдагч - эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг өмчлөгч болох этгээд, гэрээний нөгөө талын өмчлөлд зохих шаардлага хангасан нөхцөлтэйгээр тухайн хөрөнгийг шилжүүлэх үүрэгтэй ба хэлэлцэн тохиролцсон үнийг шаардах эрх бүхий этгээд

Худалдан авагч - худалдагчаас эд хөрөнгийг шилжүүлэн авах, зохих үнийг төлөх үүрэг бүхий этгээд

Гуравдагч этгээд - бие даасан шаардлага гаргасан болон гаргаагүй, түүнчлэн тухайн харилцаа хэрэгжих болон хөндөгдөх нөхцөлд эрх, ашиг сонирхол нь тодорхой хэмжээгээр хөндөгдсөн иргэн, хуулийн этгээд

Биет байдлын доголдол - гэрээгээр тохирсон эд хөрөнгийн тоо ширхэг, хэмжээ, чанарын талаарх доголдол

Эрхийн доголдол - бусдад шилжүүлж байгаа хөрөнгийн талаар гуравдагч этгээд өөрийн эрхийн талаар гомдлын шаардлага гаргахаар бол; мөн хүчин төгөлдөр бус эрхийг хөрөнгийн бүртгэлд бүртгүүлсэн бол эд хөрөнгийн эрхийн доголдол гэнэ.



Худалдагч нь биет байдлын болон эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээж буй гэрээг худалдах, худалдан авах гэрээ гэнэ.

Худалдах,
худалдан
авах гэрээ
нь хамгийн
түгээмэл
хэрэглэгддэг
урьдчилан
тохиролцсон
болон
бодит, хариу
төлбөртэй,
энгийн болон
болзолт гэрээ
юм.

Гэрээний талууд болох худалдагч-худалдан авагч нь: Иргэн, хуулийн этгээд, нутаг дэвсгэрийн нэгж, төр. Эдгээр субъект нь эрх залгамжлал, төлөөлөл, итгэмжлэлээр дамжуулан оролцож болох ба өмчлөх эрхтэй эсэх нь чухал байдаг

Гэрээний зүйл нь: хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх байна

Гэрээний зүйлийн үнийг харилцан тохиролцож тогтоох боловч үнийг тодорхойлох аргыг зааж болно. Үнийг төлөх, үнийг тогтоохдоо тухайн гэрээнд өөр өөр аргыг хэрэглэж болно

Хэлбэрийн хувьд: амаар, бодит үйлдлээр болон бичгээр байгуулж болно. Гэрээний зүйл ямар шинжтэй байхаас шалтгаалан гэрээний хэлбэрийн хувьд хуулиар тусгай шаардлага тавигддаг

Энэ гэрээ тодорхой болон тодорхой бус хугацаатай байж болно. Хөрөнгийг шилжүүлэх, төлбөр төлөх аргаас хамаарч хугацаа үйлчилнэ



Худалдах, худалдан авах гэрээний онцлог:

- *Худалдагчийн хувьд*, хөрөнгийг олгох байдлаар худалдан авагчийн захиран зарцуулах эрхэд, хөрөнгийн дагалдах баримт бичгийг хамт, тодорхой тоогоор, тохирсон ассортиментоор /нэгэн төрөл бүлэг барааг өнгө, хэмжээ, загвар, төрлөөр нь ялгаж байгаа/, зохих иж бүрдлийн дагуу, зохих чанартай хөрөнгийг, гуравдагч этгээдийн шаардах эрхээс бүрэн чөлөөлөгдсөн /өөрөөр хэлбэл эрхийн доголдолгүй хөрөнгө байх шаардлагатай/, зохих сав баглаа, боодолтой шилжүүлэх үүргийг хүлээж байдаг. Түүнчлэн эд хөрөнгийн доголдолтой холбоотой эрх эдэлж, үүргийг хүлээнэ /ИХ 253-р зүйл/
- *Худалдан авагчийн хувьд*, гэрээнд өөрөөр заагаагүй бол барааг худалдагчийн байгаа газраас өөр газарт хүргэх, зөөх, тээвэрлэх, хүлээн авахтай холбогдсон зардлыг хариуцах үүрэгтэй байдаг. Мөн эд хөрөнгийн доголдолтой холбоотой тодорхой эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. /ИХ 254-р зүйл/
- *Үр шим болон эрсдэл шилжихдээ* худалдсан эд хөрөнгийг худалдан авагчид шилжүүлснээр тухайн эд хөрөнгийг ашигласны үр дүнд олсон үр шим болон уг эд хөрөнгө тохиолдлоор устаж, гэмтсэний эрсдэл худалдан авагчид шилждэг онцлогтой.
- Худалдан авагч худалдан авсан эд хөрөнгийг хугацаанд нь хүлээж аваагүй бол худалдагч хөрөнгийг *хадгалах үүрэгтэй* байдаг. Гэрээний нэг тал эд хөрөнгийг хүлээж авахгүй удаасан болон хадгалахтай холбоотой зардлыг төлөхгүй бол эд хөрөнгийг хадгалж байгаа тал түүнийг худалдах эрхтэй бөгөөд энэ эрхээ хэрэгжүүлэхээс өмнө нөгөө талдаа 7 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй



- Бусад төсөөтэй гэрээнээс ялгагдах онцлогтой. Худалдах, худалдан авах гэрээ нь өөрөө хэд хэдэн онцлог төрөлтэй байдгийг өмнө дурдсан. Юуны өмнө тодорхой тохиолдол нь ердийн худалдах худалдан авах гэрээ юу эсвэл зээлээр худалдах, худалдан авах, ирээдүйд эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ юу гэдгийг ялгах шаардлагатай. Эдгээр нь субъект, объектын хувьд төдийлөн ялгаатай бус ч худалдах худалдан авах нөхцөл, хугацаа, болзол тавьсан эсэхээс хамаарч өөр хоорондоо ялгагддаг онцлогтой. Түүнчлэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлдэг арилжаа болон бэлэглэлийн гэрээнүүдээс хариу төлбөрийн хэлбэр болон хариу төлбөр төлөх эсэхээрээ ялгаатай.

Арилжааны гэрээ



Арилжааны гэрээний онцлог:

- Арилжааны гэрээ нь бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэх гэрээний үүрэгт хамаардгаараа ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх гэрээний үүргээс ялгагдана
- Арилжааны гэрээгээр талууд харилцан хөрөнгийг солилцож, өмчлөлдөө шилжүүлнэ
- Хариу төлбөртэй бусад гэрээнээс мөнгөн хэлбэрээр бус харилцан нийцэж байгаа ашиг сонирхлын дагуу хөрөнгийн хариуд хөрөнгө шилжүүлж байдгаараа ялгагдана
- Мөн ижил төстэй гэрээнээс өмчлөх эрхийг үүсгэх байдлаараа ялгагдана. Эд хөрөнгийг харилцан солилцсон тэр үед өмчлөх эрх үүсдэг, шилждэг гэж үздэг. Гэхдээ үүргийн нийтлэг үндэслэлийн дагуу эд хөрөнгө шилжүүлэхээс өмнө өмчлөх эрх шилжиж болох гэрээний тохиролцоо байхыг үгүйсгэж болохгүй юм



Дасгал

1. Иргэн Тулга машины бизнес эрхэлдэг бөгөөд нэг сарын дараа ирэх машинаас 1 ширхэгийг 2 сая төгрөгөөр иргэн Баатарт худалдахаар тохиролцож, Баатар 2 сая төгрөгийг 6 хувийн хүүтэйгээр банкнаас зээлэн төлбөрийг урьдчилан хийсэн байна. Үүргийг гүйцэтгэх хугацаа, газар болон бусад нөхцлүүдийг харилцан тохиролцсонгүй. Ийнхүү тохиролцсоноос хойш 2 сар өнгөрөхөд Тулгаа уг машинаа машин ирээгүй шалтгаанаар худалдах боломжгүй болсон тухай хэлжээ. Баатар өгсөн мөнгө болон банкны хүүг нэхэмжилсэн байна. Хууль зүйн үндэслэлтэй юу?
2. Иргэн Мягмар өөрийн өмчлөлийн жип машиныг 7 сая төгрөгөөр найз Цэвлээд худалдахаар тохиролцжээ. Цэвлээ урьдчилгаа болгон 2 сая төгрөгийг төлсөн байна. Уг машиныг шилжүүлэхээс өмнө хүү нь унаж байгаад осолд орж гэмтээжээ. Эрсдлийг хэн хариуцах вэ?
3. Иргэний хуулийн 243-261-р зүйл, 274-275-р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох худалдагч, худалдан авагчийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

1. Худалдагч С худалдан авагч Х нар нь М-д түр хугацаагаар хөлсөлж байгаа микроавтобусаа 3 сая төгрөгөөр худалдсан. Х-д хэдийнээс эд хөрөнгийг шилжсэн гэж үзэх вэ?
 - a. эд хөрөнгийг шилжүүлэн өгснөөр
 - b. баримт бичгээ шилжүүлснээр
 - c. шаардах эрхээ шилжүүлэх тухай гэрээ байгуулснаар
 - d. төлбөр төлснөөр
2. Худалдан авагчид эд хөрөнгө шилжихээс өмнө өмчлөх эрх шилжсэн үед худалдагч эд хөрөнгийг хадгалах явцад гэнэтийн болон давтагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас эд хөрөнгө утсан бол
 - a. гэрээг цуцалж, худалдагч уг эд хөрөнгийн үнийг худалдан авагчид буцаан өгөх үүрэгтэй
 - b. худалдагч ижил төрлийн эд хөрөнгийг оронд нь шилжүүлэх үүрэгтэй
 - c. худалдагч хариуцлагаас чөлөөлөгдөнө
3. Худалдагч нь
 - a. худалдах худалдан авах гэрээний зүйлийг өмчлөгч нь иргэн, хуулийн этгээд, төр байна
 - b. гэрээний зүйлийг өмчлөгчөөс гадна эд хөрөнгийг хууль буюу гэрээний дагуу эзэмшигч иргэн, хуулий этгээд байж болно
 - c. тодорхой тохиолдолд өмчлөгч биш этгээд болон шударга эзэмшигч байж болно
 - d. A+B хамаарна
 - e. бүгд
4. Иргэн С өөрийн нэрээр авсан борцтой амтлагч үйлдвэрлэх эрхээ бусдад худалдахаар болж, ямар гэрээ байгуулах талаар эргэлзжээ. Ямар гэрээ байгуулах нь тохиромжтой вэ?
 - a. лицензийн гэрээ
 - b. лизингийн гэрээ
 - c. худалдах, худалдан авах гэрээ- Яагаад...
5. Хэд хэдэн этгээдэд гэрээний зүйлийг худалдсан байвал, аль гэрээ нь хүчин төгөлдөр вэ?
 - a. бүгд хүчин төгөлдөр бус
 - b. хамгийн анх гэрээ байгуулсан этгээдийн хувьд хүчин төгөлдөр
 - c. эзэмшилдээ оруулж авсан этгээдийн хувьд хүчин төгөлдөр



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/1- III дэд хэсэг, II хэсэг.
- Иргэний эрх зүй. Т.Мөнхжаргал Үүргийн тусгай төрөл. /1998 он/ 3-9-р хуудас
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 116-121-р хуудас
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 67-71-р хуудас
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он.
- ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 3-52 р тал, 156-158 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под. ред Платонова Д.И. 4-15 р тал, 32 р тал

2. Бэлэглэлийн гэрээ

Сэдвийн зорилго: Бэлэглэгчээс тусгай зориулалт заах буюу заахгүйгээр бусдын өмчлөлд эд хөрөнгийг хариу төлбөргүйгээр шилжүүлэх, бэлэг хүлээн авагч бэлгийг хүлээн авах эсвэл хүлээн авахаас татгалзах үндэслэл, журам, эрх зүйн зохицуулалтын онцлогийн талаар мэдлэг олж авах, бэлэглэл хандивын гэрээний ялгааг судалсны үндсэнд гэрээ байгуулах чадвар эзэмших болно.



Нэр томъёоны тайлбар

Бэлэглэгч - бусдын өмчлөлд эд хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлж байгаа эрх бүхий этгээд

Бэлэг хүлээн авагч - бусдаас хариу төлбөргүйгээр эд хөрөнгийг хүлээн авч байгаа этгээд

Хандив - тодорхой зориулалт, зорилгоор олгосон хөрөнгө, мөнгө

Амлалт - бусад этгээдийн өмнө тодорхой үндэслэлтэй, хүлээсэн үүрэг

Нэг талын гэрээ - нэг тал зөвхөн эрх эдлэж, нөгөө тал нь зөвхөн үүрэг хүлээх гэрээ

Нэг тал болох бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчийн зөвшөөрлөөр тодорхой хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэх, нөгөө тал болох бэлэг хүлээн авагч нь бэлгийг хүлээн авах эрх бүхий гэрээг бэлэглэлийн гэрээ гэнэ.





Бодит болон урьдчилан тохиролцсон, хариу төлбөргүй. Бэлэглэлийн гэрээ нь эртний уламжлалт гэрээний төрөл /*rustum donationis*/ болох ба бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэх гэрээний үүрэгт хамаарна

Гэрээний талууд нь бэлэглэгч, бэлэг хүлээн авагч буюу иргэн, хуулийн этгээд, төр байна

Хэлбэрийн хувьд амаар болон бичгээр байгуулж болно. Үл хөдлөх хөрөнгө бэлэглэж байгаа бол гэрээг бичгээр үйлдэж, бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ. Тодорхой хөрөнгө бэлэглэхээр амласан амлалтыг бичгээр байгуулж нотариатаар гэрчлүүлснээр бэлэг хүлээн авагчид шаардах эрх үүснэ

Гэрээний зүйл нь эд хөрөнгө, эрх байж болох ба бэлэглэгч ийнхүү бэлэглэх эрхтэй байх ёстой

Бэлэглэлийн гэрээний онцлог:

- Бэлэглэгч нь бэлэг хүлээн авагчийн зөвшөөрлөөр бэлгийг шилжүүлэх, өөрийн асрамжинд байгаа хүний амжиргааны нэн тэргүүний хэрэгцээт хөрөнгийг бусдад бэлэглэх эрхгүй байна. Түүнчлэн доорхи тохиолдолд бэлэглэлийн гэрээг биелүүлэхээс татгалзаж болно. Тухайлбал: бэлэг хүлээн авагч бэлэглэгчийг гомдоосон үйлдэл хийсэн, бэлэг хүлээн авагч нь бэлэглэгчийн болон түүний төрөл төрөгсөдийн эрүүл мэнд, амь насыг санаатай хохироосон буюу хохироохоор завдсан г.м. Эдгээрээс гадна бэлэглэгч бэлэглэлийн гэрээг болзол хангах, тодорхой зорилгод хүрсэн нөхцөлд хүчин төгөлдөр болохоор тусгайлан зааж болох ба болзол, шаардлагыг хангаагүй тохиолдолд гэрээнээс татгалзаж болно
- Иргэний эрх зүйн бусад төрлийн гэрээнээс ялгагдах онцлог нь хариу төлбөргүй байдаг
- Бэлэглэлийн гэрээгээр бэлэг хүлээн авагчийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх шинж чанартай
- Шилжүүлж байгаа бэлэг нь ихэнхдээ ямар нэгэн үүргээс чөлөөлөгдсөн байна
- Бэлэг хүлээн авагч зөвшөөрсөн тохиолдолд бэлэглэх зүйлийг түүний өмчлөлд шилжүүлдэг



Дасгал

1. Иргэн Туяа ОХУ-аас хөлдөөгч оруулж ирж борлуулдаг байна. Тэрээр өөрийн найз Батцэцэгт удахгүй оруулж ирэх хөлдөөгчөөс нэг ширхэгийг бэлэглэнэ гэж амласан боловч өөрөө бие нь муудаж дахин хөлдөөгч оруулж ирж чадсангүй. Иймээс Батцэцэгт хөлдөөгч өгөх боломжгүй болсон тухай хэлтэл, Батцэцэг: "би чамаас авах хөргөгчөө дүүдээ худалдана гэж хэлээд мөнгийг нь авчихсан тул өөрийнхөө хэрэглэж байгаа хөлдөөгчөө өгч болохгүй юу" гэсэн байна. Туяа, Батцэцэг нарын хооронд иргэний эрх зүйн гэрээ байгуулагдсан уу? Хууль зүйн үндэслэлийг тодорхойлно уу?
2. Баатар өөрийн хүү Ганаагийн хүмүүждэг цэцэрлэгт барилга барихад нь зориулж 500.000 төгрөг хандивласан байна. Гэтэл хандивын мөнгийг цэцэрлэгийн эрхлэгч нь барилга барихад бус өрөөндөө компьютер авахад зарцуулсан байна - Баатар хандивын мөнгийг зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавих эрхтэй юу?
Зориулалтын дагуу ашиглаагүй хандивын мөнгөөр компьютер худалдан авсан нь хүчин төгөлдөр бус болох үндэслэл болох уу?
3. Иргэний хуулийн 276-280-р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох бэлэглэгч, бэлэг хүлээн авагчийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон ярилцаарай



Сорил

1. Бэлэглэлийн гэрээ нь
 - a. гагцхүү бодит гэрээ
 - b. урьдчилан тохиролцсон гэрээ
 - c. хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол бодит гэрээ
2. Эд хөрөнгө бэлэглэхээр амласан тохиолдолд
 - a. бэлэглэлийн гэрээг амаар хийгдсэн гэж үзнэ
 - b. гэрээг бичгээр хийсэн тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ
 - c. амлалтыг нотариатаар гэрчлүүлсэнээр хүчин төгөлдөр болно
3. А өөрийн төрсөн нутагт хийд барихад хөрөнгө оруулах, тухайн ажилд гар бие оролцсон тохиолдолд орон сууцаа бэлэглэх болзолтойгоор бэлэглэлийн гэрээг дүү С-тэй байгуулсан байна. Энэ нь үндэслэлтэй юу?
 - a. бэлэглэлийн гэрээнд болзол заах нь үндэслэлгүй
 - b. болзол заах нь бэлэглэл бус хандивын гэрээ болно
 - c. болзлыг хангаж байж бэлэглэлийн гэрээ биелэгдэнэ
4. Бэлэглэгч балэглэлийн гэрээнээс татгалзах, хүчингүй болгох эрхтэй юу?
 - a. эрхгүй
 - b. эрхтэй



с. бэлэглэгчийг гомдоох ноцтой үйлдэл хийсэн бол

д. бэлгийг өөр зүйлд зарцуулсан бол

5. Иргэн М-ийн шинэ гэрийн найранд Л нь хурдан удмын хул үрээгээ бэлэглэж байгаагаа хэлжээ. Үүнээс хойш 5 сарын дараа уг морийг авахаар очиход адуугаа алдсан учраас одоо өгөх морь байхгүй гэв. Энэ нь бэлэглэлийн гэрээ мөн үү

а. мөн. Учир нь.....

б. биш. Учир нь.....



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судааарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг. 276-280-р зүйл
- Иргэний эрх зүй. Т.Мөнхжаргал Үүргийн тусгай төрөл. /1998 он/ 21-24-р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 122 тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 71-72 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 3-52 р тал, 159-168 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под. ред Платонова.Д.И. 33-34 р тал

3. Зээлийн гэрээ

Сэдвийн зорилго Зээлдүүлэгч мөнгө болон төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгийг зээлдэгчийн өмчлөлд шилжүүлэх, зээлдэгч тодорхой хугацааны дараа мөнгө болон ижил төрөл, тоо, чанарын эд хөрөнгийг зээлдүүлэгчид буцаан шилжүүлэх үүрэг хүлээдэг энэхүү харилцааны эрх зүйн зохицуулалтын онцлогын талаар онол- практикийн мэдлэгтэй болох, мөн зээлийн гэрээг ижил төстэй бусад гэрээнээс ялгах, зээлийн гэрээ байгуулах чадвар эзэмших, зээлийн гэрээтэй холбогдох маргааныг шийдвэрлэх дадалтай болж, хууль ёс, шударга ёсыг дээдлэх, хүний эрхийг хамгаалах хандлага төлөвшинө.




Нэр томъёоны тайлбар

Зээлдүүлэгч - зээлдэгчийн өмчлөлд мөнгө, бусад эд хөрөнгө шилжүүлэн, тодорхой хугацааны дараа ижил төрөл, тоо чанарын эд хөрөнгө шаардах эрх бүхий этгээд

Зээлдэгч - эд хөрөнгө өмчлөлдөө шилжүүлэн авч зохих хугацааны дараа ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө, мөнгийг буцаан өгөх үүрэг бүхий этгээд.

Мөнгөн зээлийн хүү - мөнгөн зээлийн гэрээгээр талууд тохиролцон тодорхой хувь, хэмжээгээр тогтоосон хариу төлбөр буюу мөнгөн дүн

Зээлдүүлэгч мөнгө эсхүл төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгө зээлдэгчийн өмчлөлд шилжүүлэх, зээлдэгч нь тогтоосон хугацаанд шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, чанар, тоо хэмжээний эд хөрөнгө, мөнгийг буцаан шилжүүлэх үүрэг бүхий гэрээг зээлийн гэрээ гэнэ.



Зээлийн гэрээний онцлог:

- Зээлийн гэрээнд талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болно
- Мөнгө, эд хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгснөөр эсхүл хуульд заасан хэлбэрээр хийсэн гэрээг байгуулагдсанд тооцно



- Гэрээг тодорхой хугацаатай байгуулсан бол зөвхөн зээлдэгчийн эд хөрөнгийн байдал доройтож, буцаан төлөх чадваргүй болсон тохиолдолд, мөн зээлдүүлэгч зөвшөөрсөн нөхцөлд зээлийн хүүгийн хамт хугацаанаас нь өмнө төлөх, эсвэл шаардах эрхтэй
- Зээлийн гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө зээл авах гэж байгаа этгээд буцаан төлөх чадваргүй болох нөхцөл байдал бий болохоор байвал зээл олгохоос татгалзах эрхтэй
- Зээлийн гэрээг ижил төсөөтэй гэрээнээс ялгах шаардлагатай. Тухайлбал, банк, эрх бүхий байгууллагаас олгох зээлийн гэрээнээс гэрээний субъект, гэрээний зүйл, гэрээний хариуцлагын онцлогуудаар ялгагдаж өгдөг. Хэдийгээр зээлж авсан мөнгө, эд хөрөнгийг буцааж байгаагаараа бусдын эзэмшил, ашиглалтад хөрөнгө шилжүүлэх гэрээтэй төсөөтэй хэдий ч гэрээний зүйл, агуулгаараа ялгагдана



Дасгал

1. "Таван" ББН-ийн ломбардад иргэн Ариун гар утсаа барьцаалан 60,000 төгрөг зээлжээ. Ломбардын журамд заасан 2 сарын хугацаа дуусахад Ариун гар утсаа ирж аваагүй бөгөөд зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй байна. Ломбард уг гэрээний дагуу гар утсыг худалдахаар болж, карт хийж үзвэл сүлжээний засвартай утас байсан бөгөөд зээлийн гэрээний үнэнд хүрэхгүй болох нь тогтоогджээ. Ломбардын эзэн Ариунд итгэсний үндсэн дээр 60000 төгрөг өгсөн бөгөөд итгэл алдсан, улмаар залилсан гэж үзэж цагдаад ханджээ. Иргэний гэрээнээс үүдэлтэй маргаан гэсэн үндэслэлээр цагдаагийн байгууллага хүлээж аваагүй бөгөөд ломбардын эзэн хуулийн зөвлөгөө авахаар танд хандсан гэж үзээд
 - Хуулийн зөвлөгөө өгч, бодлогын хууль зүйн үндэслэлийг тодорхойл.
2. Иргэний хуулийн 281-286-р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох зээлдэгч, зээлдүүлэгчийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

1. Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь гэрээний зүйлийг зээлдэгчийн
 - a. Буцааж зээлдүүлэгчид өгдөг учраас ашиглах эрхэд шилжүүлдэг
 - b. Буцааж зээлдүүлэгчид өгдөг учраас эзэмших, ашиглах эрхэд шилжүүлдэг

- с. өмчлөлдөө шилжүүлдэг учраас эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд шилжүүлдэг*
2. Зээлийн бодит гэрээний талуудын эрх үүрэг хэдий үеэс үүсдэг вэ?
- а. гэрээ байгуулсан үеэс*
б. талуудын тохиролцсоноор
с. гэрээний зүйлийг шилжүүлсэн үеэс
д. хуулинд зааснаар
3. Зээлийн гэрээний зүйл юу байж болох вэ?
- а. иргэний гүйлгээнээс хасагдаагүй бүх зүйлс*
б. үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, мөнгө
с. хөдлөх хөрөнгө, мөнгө
д. зөвхөн мөнгө байна.
4. Зээлийн гэрээ нь
- а. хариу төлбөртэй гэрээ*
б. хариу төлбөргүй гэрээ
с. хариу төлбөргүй болон хариу төлбөртэй байж болох гэрээ
5. Барьцаалан зээлдэх гэрээний зүйл нь зээлдэгчийн өөрийнх нь хөрөнгө биш болох нь тогтоогдож, маргаан үүссэн бол барьцаалан зээлдэх газар нь ямар субъект болох вэ?
- а. хууль ёсны эзэмшигч*
б. шударга эзэмшигч
с. хууль ёсны шууд эзэмшигч
д. шударга бус эзэмшигч



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг. 281-286 р зүйл
- Иргэний эрх зүй. Т.Мөнхжаргал Үүргийн тусгай төрөл. /1998 он/ 135-137-р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 126 тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 72-74 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации части второй. Москва 1998, 373-383 р тал
- Конспект лекций Гражданское право Часть 2. /обязательственное право/ под. ред. Платонова. Д.И. 82-86 р тал



II бүлэг. БУСДЫН ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТАД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Бүлгийн зорилго: Бусдын эзэмшил ашиглалтанд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүргийн талаар онолын мэдлэг олж, тус бүлэгт хамаарах гэрээний төсөл боловсруулах, гэрээ байгуулах чадвар эзэмшин, тэдгээр гэрээтэй холбоотой маргаан шийдвэрлэхэд хууль зүйн үүднээс хандах хандлага төлөвшинө.

1. Эд хөрөнгө хөлслөх болон орон сууц хөлслөх, эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах гэрээ

Сэдвийн зорилго: Эд хөрөнгө хөлслөх болон орон сууц хөлслөх, эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах, гэрээний ойлголт, үндсэн шинж, төрөл, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын талаар онолын мэдлэг олж, тэдгээр гэрээг байгуулах, маргаантай асуудлыг шийдвэрлэдэг болно.



Нэр томъёоны тайлбар

Хөлслөгч- бусдын өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийг гэрээний үндсэн дээр тодорхой хугацаагаар эзэмшиж, ашиглаж байгаа этгээд
Хөлслүүлэгч- өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийг гэрээний үндсэн дээр бусдын эзэмшил, ашиглалтад шилжүүлж байгаа этгээд
Гэр бүлийн гишүүд- гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүн
Түр суугч- хөлслөгчийн зөвшөөрлөөр түр хугацаагаар орон сууцанд оршин сууж буй этгээд
Албаны орон сууц- албан тушаалын байдал, түүнчлэн хөнгөлөлт эдлэх эрхтэй нь холбогдуулж, хуульд заасан журмын дагуу тодорхой этгээдэд түр хугацаагаар шилжүүлсэн орон сууц



ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 2

БУСДЫН ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТАД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН
ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Эд хөрөнгө хөлслөх гэрээ гэдэг нь хөлслүүлэгч нь хөлслөгчийн эзэмшил, ашиглалтанд тодорхой эд хөрөнгийг түр хугацаатайгаар шилжүүлэх, хөлслөгч нь хөрөнгө ашигласны хөлсийг төлөх үүргийг хүлээсэн гэрээг хэлнэ.

Эд
хөрөнгө
хөлслөх гэрээ
нь урьдчилан
тохиролцсон,
хариу төлбөртэй,
хоёр талын
гэрээ юм

Гэрээний талууд нь хөлслүүлэгч, хөлслөгч эд хөрөнгө хөлслөх гэрээний төрлөөс хамааран түр суугч зэрэг гуравдагч этгээд оролцоно

Гэрээний зүйл нь түр хугацаагаар хөлслүүлж байгаа нэг бүрийн шинжтэй хөрөнгө /хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөнөөс гадна эрх ч байж болно/

Гэрээний үнэ нь гэрээгээр тохиролцсон буюу хөлслөгчийн төлөх хөлсөөр тодорхойлогдоно

Гэрээг амаар болон бичгээр байгуулж болно. Гэрээний зүйлээс шалтгаалан бичгээр байгуулах, бүртгүүлэх шаардлагыг хуульд заасан байдаг

Эд хөрөнгө хөлслөх гэрээний онцлог:

- Эд хөрөнгө хөлслөх гэрээгээр хөлслүүлэгч эд хөрөнгөө бусдын захиран зарцуулах эрхэд шилжүүлэхгүй зөвхөн эзэмшэх, ашиглах эрхэд шилжүүлдэгээрээ худалдах, худалдан авах гэрээ, арилжааны гэрээнээс ялгагдана. Гэхдээ тухайн эд хөрөнгөнөөс бий болж байгаа үр шим нь хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бол хууль ёсны эзэмшигч буюу хөлслөгчийнх болж байдгаараа ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх гэрээнээс ялгагдана
- Гэрээний зүйл нь ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэгцээ хангаж чадах үл хэрэглэгдэх, нэг бүрийн шинжээр тодорхойлогдох хөрөнгө байна
- Эд хөрөнгө хөлслөх гэрээний хөлслөгч талын хувьд үүсэх нэг онцлог эрх нь гэрээний зүйлийг хөлслүүлэгч худалдах бол хөлслөгч тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй байдаг



- Эд хөрөнгийг эргэлтэнд оруулах нэг арга зам болохын хувьд олон төрөл болон хөгжих, гэхдээ үндсэн нийтлэг зохицуулалт нь эд хөрөнгө хөлслөх гэрээ болох бөгөөд тухайн төрлүүд нь өөр өөрийн онцлогийг агуулж байдаг. Тухайлбал: лизинг, франчайзын гэрээ нь орчин үеийн нийгэмд зайлшгүй хэрэгцээ шаардлагаар үүссэн өөрийн гэсэн онцлогтой хэдий ч эд хөрөнгө хөлслөх гэрээний ерөнхий зохицуулалттай адил төсөөтэй байдаг
- Эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах гэрээ нь ерөнхий шинжээрээ эд хөрөнгө хөлслөх гэрээтэй төстэй боловч онцлог нь хариу төлбөргүй байдаг бөгөөд үүгээрээ бэлэглэлийн гэрээтэй төстэй хэдий ч эд хөрөнгийг өмчлөлд шилжүүлдэггүйгээрээ ялгаатай
- Түрээсийн гэрээнээс ялгагдах онцлог нь; хөлслөгч ахуйн зориулалтаар гэрээний зүйлийг эзэмшиж, ашиглана



Дасгал

1. Иргэн Баяраа намрын тариа хураалтын үеэр "Ургац" ХХК-аас 2 ширхэг трактор 2 сарын хугацаагаар ашиглахаар авсан байна. Гантай байсны улмаас ургац аваагүй учраас тракторыг тариа хураалтын зориулалтаар бус чулуу тээвэрлэсэн байна. Энэ тухай мэдсэн "Ургац" ХХК гэрээгээ хугацаанаас нь өмнө цуцлах, 2 сарын хөлс 400.000 төгрөг болон тэвшийг шинээр солих 300.000 төгрөгийг өөрт учирсан хохирол гэж үзэж нэхэмжилжээ.
 - Хууль зүйн үндэслэлийг тайлбарлан дээрх тохиолдолд хөлслөх болон түрээсийн гэрээг хэрхэн ялгаж зүйлчилсэн тухай тайлбар бичих.
2. Иргэн Б өөртөө хувцас, хослол оёхоор А компаниас оёдлын машин хөлсөлж аваад С компанийн захиалгаар 1 сар ажлын хувцас оёж нэлээд ашигтай ажилласан байна. Үүнийг хөлслүүлэгч мэдээд хөлсөө нэмэхээр шаардлага гаргажээ. Хууль зүйн үндэслэлтэй юу?
3. Иргэний хуулийн 287-301-р зүйл, 339-342-р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох хөлслөгч, хөлслүүлэгчийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлох.



Сорил

1. Хөлсөлсөн хөрөнгийн талаар гуравдагч этгээд шаардлага гаргаж байгаа бол энэ нь ямар хөрөнгө болох вэ?
 - a. биет байдлын доголдолтой хөрөнгө
 - b. эрхийн доголдолтой хөрөнгө
 - c. гуравдагч этгээдийн шаардлагаас хамаарч эрхийн, эсвэл биет байдлын доголдолтой хөрөнгө гэж үзнэ

2. А нь Б-ийн өмчлөлд 10 т гурил шилжүүлж, 6 сарын дараа буцаан авахаар тохиролцоходоо эд хөрөнгө хөлслөх гэрээ байгуулжээ. Энэ тохиолдолд талууд гэрээ байгуулахдаа юуг анхаарах ёстой байсан бэ?
 - a. гэрээний зүйл
 - b. гэрээний хугацаа
 - c. гэрээний үнэ
3. А, Б нарын хооронд ямар гэрээ байгуулагдсан бэ?
 - a. худалдах, худалдан авах гэрээ
 - b. буцаан худалдах, худалдан авах гэрээ
 - c. эд хөрөнгө хөлслөх гэрээ
 - d. зээлийн гэрээ
 - e. үнэ төлбөргүй ашиглах гэрээ
4. А машин хөлслөн авсаны дараагаар огт ашиглаагүй, гэрээнд тохирсон хугацаа дуусахад машиныг буцаан өгөхдөө хөлс төлөхөөс татгалзсан байна. Учир нь машиныг огт ашиглаагүй, ямар нэгэн элэгдэл хорогдол гараагүй гэж тайлбарлажээ. Үүнийг хэрхэн шийдвэрлэх вэ?
 - a. нэгэнт ашиглаагүй тул хөлс төлөхгүй
 - b. хөлслөгч өөрийн буруугаас хөрөнгийг ашиглаж чадаагүй нь хөлс төлөхөөс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй
 - c. зөвхөн хадгалалтын хөлсийг тохиролцон төлнө.
5. Хүндэтгэн үзэх шалтгаанаар эд хөрөнгө хөлслөх гэрээг цуцлах гэдэгт аль нь хамаарахгүй вэ?
 - a. хөлслүүлсэн сууцны талбай хөлслүүлэгчид өөрт нь хэрэгцээтэй болсон
 - b. хөлслүүлэгчийн санал болгосон зах зээлийн үнэд тохирсон нэмэгдэл хөлс төлөхөөс татгалзсан
 - c. гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан бол гэрээ цуцлах тухай аль нэг тал нь мэдэгдсэнээс хойш гэрээнд заасан хугацаа өнгөрсөн
 - d. гэрээг зохих ёсоор гүйцэтгээгүй гэм буруутай бол нөгөө талын санаачилгаар
6. Эд хөрөнгө хөлслөгч хөрөнгийг бусдад алдсан бол ямар эрх эдлэх вэ?
 - a. шударга эзэмшигчийн
 - b. өмчлөгчийн
 - c. хууль ёсны эзэмшигчийн



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол Улсын Иргэний хуулийн /2002 он/ I-II дэд хэсэг, II хэсэг. 287-301 р зүйл, 339-342 р зүйл



- Иргэний эрх зүй. Т.Мөнхжаргал Үүргийн тусгай төрөл. /1998 он/ 24-27 р тал, 34-36 р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 127-130-р тал, 134 р тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 75-77 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он.
- ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 170-174 р тал, 263-270 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под. ред Платонова. Д.И 36-39 р тал, 53-54 р тал

2. Түрээсийн гэрээ

Сэдвийн зорилго: Түрээсийн гэрээний ойлголт, үндсэн шинж, төрөл, тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын талаар онолын мэдлэг олж, бие даан уг гэрээг боловсруулах, байгуулах чадвар эзэмшин, бизнесийн эрх зүйн харилцаанд гарч болох эрсдлээс хамгаалах, хуулийг зөв хэрэглэх чадвар эзэмшинэ.



Нэр томъёоны тайлбар

Ахуйн прокат - түрээслүүлэгч нь ахуйн хэрэглээ, үйл ажиллагаанд зориулагдсан хөдлөх хөрөнгийг шилжүүлэх, түрээслэгч нь уг хөрөнгийг эзэмшиж, ашигласны төлбөрийг төлөх үүрэг хүлээсэн гэрээ

Лизинг буюу санхүүгийн түрээс - түрээслүүлэгч гэрээнд заасан хугацаагаар түрээслэгчийн эзэмшил, ашиглалтанд эд хөрөнгө шилжүүлэх, нөгөө талаас түрээслэгч нь тогтоосон хугацаанд түрээсийн төлбөр төлөх үүргийг хүлээсэн гэрээ


Тээврийн хэрэгслийн түрээс - түрээслэгч нь тээврийн хэрэгслийг тодорхой хугацаагаар эзэмшиж, ашиглаж байгаагийн төлөө төлбөр төлөх, түрээслүүлэгч нь тухайн хугацаанд удирдлагын болон техник ашиглалтын тусалцааг үзүүлэх буюу үзүүлэхгүйгээр үүрэг хүлээх гэрээ

Дамжуулан түрээслэх - түрээслэгч түрээслэж байгаа хөрөнгийг түрээслүүлэгчийн зөвшөөрлөөр гуравдагч этгээдийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх гэрээ

Зайлшгүй зардал - түрээслэн авсан эд хөрөнгөтэй холбогдон зайлшгүй гарч байгаа зардал

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 2

БУСДЫН ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТАД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН
ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ



Түрээсийн гэрээний онцлог:

- Түрээслэгч нь аж ахуйн буюу ашиг орлого олох зориулалтаар түрээсийн зүйлийг эзэмшиж, ашигладгаараа эд хөрөнгө хөлслөх гэрээнээс ялгаатай
- Түрээслүүлэгч нь өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигч байна
- Түрээсийн гэрээг ихэнхдээ урт хугацаагаар байгуулдгаараа эдхөрөнгө хөлслөх гэрээнээс ялгагдана



- Гэрээний зүйл нь аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулагдсан үл хэрэглэгдэх, нэг бүрийн шинжээр тодорхойлогдох хөрөнгө байна
- Түрээсийн гэрээг заавал бичгээр байгуулна. Хэрэв дээрх шаардлагыг хангаагүй бол хүчин төгөлдөр бус гэрээ болно

Түрээсийн гэрээ нь орчин үед олон төрөл болон хэрэглэгдэж байна.



Түрээсийн гэрээний дээрх төрлүүд өөрийн зохих онцлогийг илэрхийлэх боловч түрээсийн болон эд хөрөнгө хөлслөх гэрээний нийтлэг зохицуулалтанд хамаарагдана.

- Түрээсийн гэрээний зүйлийг эрх залгамжлалын журмаар эрх бүхий этгээд үргэлжлүүлэн эзэмшиж, ашиглаж болдог.



Дасгал

1. Барилгын материалын лангуу түрээслэн ажиллуулахаар "Барилгачин" компанитай иргэн Амар түрээсийн гэрээ байгуулсан байна. Түрээсийн гэрээний хугацаа буюу 5 сарын хугацаа өнгөрөхөд түрээсийн төлбөрийг бөөнд нь авахаар талууд тохиролцжээ. Гэтэл уг хугацаа дуусахад компаниас төлбөрөө нэхэмжлэх үед иргэн Амар уг лангуу нь байршил муутай байсан учраас бусад лангуутай адил орлого олох боломж байгаагүй, иймээс түрээсийн төлбөрийг бууруулахыг шаардаж, төлбөр төлөхөөс татгалзсан байна. Хууль зүйн үндэслэл?

- Иргэний хуулийн 318-326-р, 312-317-р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж, гэрээний талууд болох түрээслэгч, түрээслүүлэгчийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон ярилцана уу.



Сорил

- Санхүүгийн түрээсийн гэрээ бусад түрээсийн гэрээнээс юугаараа ялгагдах вэ?
 - зохих төлбөр төлдөгөөрөө
 - түрээсийн үнэнд үндсэн үнэ багтдагаараа
 - удаан жилийн хугацаатай байгуулдагаараа
 - бүгд
- Түрээслэгч хугацаанаас өмнө хөрөнгийг буцаан өгсөн тохиолдолд үлдсэн хугацааны төлбөрөөс чөлөөлөгдөх ямар үндэслэл байх вэ /зөв гэж үзсэн хэд хэдэн хариултыг сонгож болно. Гэхдээ яагаад гэсэн хариултанд тайлбараа тэмдэглээрэй/
 - төлбөрөөс чөлөөлөгдөхгүй
 - хүндэтгэн үзэх шалтгаан байвал чөлөөлөгдөнө
 - хөрөнгөнд доголдол илэрсэн, цаагиур хэвийн байдлаар ашиглах боломжгүй бол чөлөөлөгдөнө
 - өөрийн оронд гэрээний нөхцлийг хүлээн зөвшөөрсөн, төлбөрийн чадвар бүхий өөр түрээслэгчийг санал болгосныг түрээслүүлэгч хүлээн зөвшөөрсөн бол чөлөөлөгдөнө
Яагаад
- Хөдөө аж ахуйн зориулалттай газрыг түрээслэж байгаа тохиолдолд гэрээний зүйлд юу хамаарах вэ?
 - зөвхөн ХАА-н зориулалттай газар
 - газар болон шаардлага хангасан дагалдах хөрөнгийн хамт
 - аль нь ч биш
- Прокатийн гэрээ гэрээний аль төрөлд хамаарах вэ?
 - нийтийн гэрээ
 - гуравдагч этгээдэд ашигтай гэрээ
 - бодит гэрээ
 - харилцан тохирч байгуулсан гэрээ
- Тээврийн хэрэгслийг түрээслэх гэрээнд аль шинж хамаарахгүй вэ?
 - түрээслүүлэгч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч байна.
 - түрээслэж байгаа тээврийн хэрэгсэл цогцолбор шинжтэй /экипаж/ байж болно
 - түрээслэж байгаа тээврийн хэрэгслийн үндсэн үнэ, төлбөртөө багтсан байна.
 - түрээслүүлэгч нь техник ашиглалтын үйлчилгээг үзүүлэх эсэхийг гэрээндээ заасан байна.



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыгхийж гүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг, 318-326-р, 312-317-р зүйл
- Иргэний эрх зүй. Т.Мөнхжаргал Үүргийн тусгай төрөл. /1998 он/ 29-34 р тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 77-79 р тал
- Иргэний хууль- шинэлэг зохицуулалт. /2003 он/ 155-159,159-165 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998,184-240 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под. ред. Платонова.Д.И 40-48 р тал

3. Франчайз

Сэдвийн зорилго: Франчайзийн гэрээний талаар онолын мэдлэгийг эзэмшиж, хууль зүйн дагуу уг гэрээг боловсруулах чадварыг эзэмшиж, франчайзийн гэрээний эдийн засгийн ач холбогдолыг зөв үнэлэн хууль зүйн үүднээс хандах хандлага төлөвшинө.



Нэр томъёоны тайлбар

Франчайз - franchise - давуу эрх, хөнгөлөлт гэсэн утгатай үг

Фирмийн нэр - бизнесийн тусгай концепци бүхий, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдөн зах зээлд амжилттай ажиллаж буйгаа нотолж чадахуйц франчайзийн системийг эзэмшигч бие даасан этгээдийн нэр

Барааны тэмдэг- үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд, иргэн өөрийн бараа үйлчилгээг бусдынхаас ялгах зорилгоор хэрэглэх тодорхой агуулга бүхий үсэг тоо, дүрс буюу эдгээрийг хосолсон дүрсэн илэрхийлэл

	Франчайзийн гэрээний талууд	Эрх шилжүүлэгч - эрх хүлээн авагч Гэрээний талууд нь хуулийн этгээд байна
	Гэрээний зүйл	Эрх шилжүүлэгчийн фирмийн нэр, бараа буюу ажил, үйлчилгээний тэмдэг, бүтээгдэхүүний загвар, баглаа, боодол, түүнчлэн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бус хөрөнгө

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 2

БУСДЫН ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТАД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН
ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

	Гэрээний үнэ	Эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан тогтолцоо, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулж, түүнд зохих шагнал, хураамж, эсхүл орлогын тодорхой хувийг төлнө
	Гэрээний хэлбэр	Бичгээр байгуулах
	Гэрээний хугацаа	Тухайн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний эрэлт хэрэгцээ, борлуулалтын зах зээлээс шалтгаалан талууд тохиролцон тогтооно. Франчайзийн гэрээг арван жилээс дээш хугацаагаар байгуулсан нөхцөлд Южил өнгөрсний дараа, хугацааг гэрээгээр тодорхойлоогүй бол талуудын аль нэг нь гэрээг цуцлах тухай нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш нэг жилийн дотор цуцалж болно.

Франчайзийн гэрээний онцлог:

- Эрхийн цогцолборыг эрх хүлээн авагчийн эзэмшил, ашиглалтанд шилжүүлнэ.
- Гэрээний зүйл нь оюуны өмч голлох ба ингэснээр бусдын эзэмшил, ашиглалтанд хөрөнгө шилжүүлэх гэрээнээс эрх шилжүүлдэгээрээ ялгагдах ба ойролцоо гэж үзэх лицензийн гэрээнээс дан ганц тодорхой нэг эрх өмчлөх эрхээ ашиглуулах бус бүхэлд нь, тухайлбал удирдлагын тогтолцоо, маркетинг техник технологийн бодлого зэрэг нь хамтдаа шилжиж, сая франчайзийн гэрээ гэсэн утга илэрхийлэгддэгээрээ ялгагдах онцлогтой
- Зах зээл дээр бий болгосон нэр хүндээ бусдад ашиглуулан ашиг олох арга нь франчайзийн гэрээ байх бөгөөд эрх хүлээн авагч нь нэгэнт нийтэд танил болсон нэр, барааны тэмдэг удирдлагын тогтолцоог ашиглан, нэмэлт хөрөнгө оруулалт шаардахгүй *ажиллах нь энэ гэрээний зарчим юм.*



Дасгал

1. **А тал:** Нарийн боов, талхны чиглэлээр үйл ажиллагаа явуулаад 10-д жил болж байгаа ХХК Зах зээлд шинэ гарц эрэлхийлдэг. Тухайлбал: түргэн хоолны газар нээх сонирхолтой боловч яаж ажиллуулах, ямар хоол хийх, тоног төхөөрөмж зэргээр мэдлэг муутай

Б тал: Хятад улсад үйл ажиллагаагаа явуулаад удсан /нэртэй/ түргэн хоолны газрын салбар байгууллагыг Монголд ажиллуулах сонирхолтой. Үүнийгээ хэрэгжүүлэх түншээ олоогүй байгаа. Монголд хөрөнгө оруулалт хийх нь эрсдэлтэй байж болох тул найдвартай түнш олох хэрэгтэй.



- Тухайн өгөгдөлд тулгуурлан гэрээ байгуулна уу. Ингэхдээ ямар төрлийн гэрээ байгуулах, ямар хэлбэртэй байх, агуулга нь ямар байх зэргийг өмнө үзсэн сэдвүүдтэйгээ холбон авч үзнэ үү
- 2. Иргэний хуулийн 333-338 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж, гэрээний талууд болон эрх шилжүүлэгч, эрх хүлээн авагчийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

1. Франчайзийн гэрээнд эрх хүлээн авагч нь
 - a. хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байж болно
 - b. гагцхүү бие даасан хуулийн этгээд байна.
 - c. хараат компани байж болно.
2. Эрх хүлээн авагч нь гэрээ дуусгавар болсны дараа эрхийг үргэлжлүүлэн ашиглаж болох уу?
 - a. болно
 - b. болохгүй
 - c. зөвшөөрлийн үндсэнд болно
 - d. зохих хураамж, үнийг төлж байсан тул болно
3. Франчайзийн гэрээний явцад бий болж байгаа орлого, ашиг нь
 - a. эд юмсын ур шим
 - b. үйлчилгээний үр шим
 - c. эрхийн үр шим
 - d. бүгд
4. Франчайзийн гэрээ нь
 - a. ажил гүйцэтгэх гэрээний үүрэгт хамаарна. Учир нь
 - b. туслалцаа үзүүлэх гэрээний үүрэгт хамаарна. Учир нь
 - c. бусдын эзэмшил, ашиглалтанд хөрөнгө шилжүүлэх гэрээний үүрэгт хамаарна. Учир нь
 - d. төлбөр тооцооны гэрээний үүрэгт хамаарна. Учир нь



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг. 333-338 р зүйл
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 79-80 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Иргэний хууль- шинэлэг зохицуулалт. /2003 он/ 147-155 р тал

III бүлэг. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Бүлгийн зорилго: Ажил гүйцэтгэх, тусалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээний үүргийн талаар онолын мэдлэгийг эзэмшиж, хууль зүйн дагуу эдгээр гэрээг боловсруулах төдийгүй эдийн засгийн ач холбогдлыг зөв үнэлэх чадварыг эзэмшиж, эдгээр гэрээний талаар өөрийн мэдлэгийг бүтээх, гэрээний талуудын эрх, ашиг сонирхлыг адил тэгш хангах хандлага төлөвшинө.

1. Ажил гүйцэтгэх гэрээ

Сэдвийн зорилго: Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах, хөдөлмөрийн гэрээний эрх зүйн зохицуулалтын талаар онолын мэдлэгийг эзэмшин, хууль зүйн дагуу эдгээр гэрээг боловсруулах, байгуулах, талуудын хооронд үүсэж болох маргааныг шийдвэрлэх чадвар эзэмшинэ.




Нэр томъёоны тайлбар

Ажил гүйцэтгэгч - гэрээгээр тохиролцсон ажил гүйцэтгэж, үр дүнг гэрээний нөгөө талд буюу захиалагчид шилжүүлэн, хөлс шаардах эрхтэй иргэн, хуулийн этгээд

Захиалагч - гэрээгээр тодорхой төрлийн ажил гүйцэтгүүлж, ажлын үр дүнг хүлээн авч, хөлс төлөх үүрэг хүлээж байгаа иргэн, хуулийн этгээд

Ажлын үр дүн - гэрээгээр тохиролцсон ажил, түүнийг гүйцэтгэснээр бий болсон биет үр дүн





ЖИШЭЭЛБЭЛ

Ажил гүйцэтгэх гэрээний хувьд олон төрөлтэй байх бөгөөд гадаадын зарим улс орны иргэний хуульд ажил гүйцэтгэх гэрээний объектын онцлогоос хамаарсан тусгай зохицуулалт байхгүй бөгөөд гэрээ эрх чөлөөтэй байх зарчмын дагуу талууд нөхцлөө өөрсдөө тогтоох өргөн боломжийг олгосон байдаг

гэрийн тавилга захиалгаар хийлгэх, хувцас захиалгаар хийлгэх, барилгын ажил гүйцэтгэх, төсөл зохиох ажил гүйцэтгэх, зохиол, бүтээл туурвих ажил гүйцэтгэх, судалгаа шинжилгээ хийх ажил гүйцэтгэх гэх мэт

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 2

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ
ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Гэрээний үндсэн шинж нь
хоёр талын үүрэг,
урьдчилан тохиролцсон,
хариу төлбөртэй, тодорхой
болон тодорхой бус
хугацаатай гэрээ юм.

Хэдийгээр ажил гүйцэтгэх,
хөлсөөр ажиллах, хөдөлмөрлөх
гэрээнүүдийн хувьд аль аль нь ажил
гүйцэтгэхтэй холбоотой гэрээний
үүрэгт хамааралтай ч өөр хоорондоо
ялгагдах тодорхой ялгаа бий. Үүнд:

- субъектээрээ ялгаатай
- агуулгын хувьд ялгаатай

Дасгал

1. Иргэн Шагдар барилгын компанитай бөгөөд гэрээний дагуу барилгын ажлыг 8 сарын 15-нд хүлээлгэж өгөх ёстой. Барилгын материал нийлүүлдэг "Буян" компанитай тохиролцон 100 кг шохой авахаар тохиролцсон байна. Гэтэл шохойг хугацаандаа нийлүүлээгүйгээс барилгын ажлыг хугацаанд нь хүлээлгэж өгсөнгүй учир 3 сая төгрөгийн төлбөр төлөхөөр болсон бөгөөд үүнийг өөрт учирсан хохирол гэж үзэж "Буян" компаниас нэхэмжилжээ.
 - Ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан уу?
 - Дээрх тохиолдолд гэрээний хариуцлагын асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?
2. Баяраа ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гэрээ ёсоор төмөр зуух хийн иргэн Батсайханд шилжүүлсэн байна. Гэтэл уг зуух нь захиалагчид түүнийг шилжүүлэх үед зориулалтын дагуу ашиглах боломжтой байсан боловч ашиглаад 6 сарын дараагаар утаа татахгүй болсон байна. Шалгаж үзтэл зуухыг ердийн төмрөөр хийснээс ихээхэн хэмжээний ан цав гарсан байна. 250.000 төгрөгөөр хийлгэсэн зуухыг буцааж, яг ийм төрлийн сайн чанарын зуухаар солиулахаар гомдол гаргасан байна.
 - Гэрээний зүйл нь юу вэ?
 - Гомдлын шаардлага гаргах хугацааны үр дагаврыг дээрх тохиолдолд тайлбарлана уу?
 - Хариуцлага хүлээлгэх хууль зүйн үндэслэлийг тодорхойлно уу?
3. Иргэний хуулийн 343-358 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох захиалагч, ажил гүйцэтгэгчийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон ярилцаарай



Сорил

1. Ажил гүйцэтгэх гэрээний зүйл нь,
a. ажил уйлчилгээ, c. туслалцаа,
b. ажлын биежсэн ур дун, d. аль аль нь мөн
2. Ажил гүйцэтгэх гэрээ нь,
a. урьдчилан тохиролцсон гэрээ, c. нэг талын гэрээ,
b. бодит гэрээ, d. хоёр ба олон талын гэрээ,
3. Булган ойролцоох үсчний газарт орж үсээ засуулсан байна. Үсний засалт түүний хүссэн үр дүнд хүрсэнгүй, маргалдсан байна. Энэ тохиолдолд,
a. ажил гүйцэтгэх гэрээний дагуу маргааныг шийдвэрлэнэ,
b. туслалцаа үйлчилгээ үзүүлэх гэрээний аль нэг төрлөөр зүйлчлэх нь зүйтэй.
c. нэрлэгдээгүй гэрээ гэж үзэн асуудлыг шийдвэрлэнэ,
d. гэрээний маргаан үүсээгүй учир гэрээний бус үүргээр маргааныг шийдвэрлэнэ
e. аль нь ч биш. Яагаад гэвэл
4. Ажил гүйцэтгэх гэрээг,
a. зөвхөн бичгээр байгуулна,
b. зөвхөн амаар байгуулна,
c. амаар болон бичгээр байгуулж болно,
d. нотариатаар гэрчлүүлэх ёстой



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I-III дэд хэсэг, II хэсэг 343-358 р зүйл
- Иргэний эрх зүй. Т.Мөнхжаргал Үүргийн тусгай төрөл. /1998 он/ 60-71-р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 135-140 р тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 80-82 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 271-295 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под. ред Платонова. Д.И 55-64 р тал

2. Хөлсөөр ажиллах гэрээ



Нэр томъёоны тайлбар

Ажиллагч - гэрээний дагуу тохиролцсон ажил үйлчилгээг гүйцэтгэх, гүйцэтгэсэн ажлын хөлсөө шаардах эрхтэй этгээд

Ажиллуулагч - ажил, үйлчилгээ гүйцэтгэсний хөлс төлөх үүрэг хүлээж байдаг бөгөөд ажлыг гүйцэтгүүлэхтэй холбоотой аливаа шаардлага тавих эрхтэй этгээд

	Гэрээний агуулга:	Гэрээний нэг тал болох <i>ажиллагч</i> нь гэрээгээр тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, нөгөө тал болох <i>ажиллуулагч</i> нь хөлс төлөх үүргийг харилцан хүлээж байдаг гэрээг <i>хөлсөөр ажиллах гэрээ</i> гэнэ.
	Гэрээний үндсэн шинж:	Энэ гэрээ нь хоёр талын, урьдчилан тохиролцсон, хариу төлбөртэй, тодорхой болон тодорхой бус хугацаатай гэрээ юм
	Гэрээний онцлог:	а. Ажиллагчийг ажлын байраар хангах, ажиллагчийн эрүүл мэнд, амь насанд аюулгүй, гүйцэтгэх ажлын онцлог шаардлагад нийцэхүйц байр, багаж, тоног төхөөрөмжөөр хангах үүргийг ажиллуулагч хүлээж байдаг нь энэ гэрээгээр ажил үүрэг гүйцэтгэгч дахин давтагдан хийж гүйцэтгэх, тодорхой орчин нөхцөл, хугацаа шаардсан ажил, үйлчилгээ үзүүлдэгтэй холбоотой б. Гэрээг цуцлах хугацаа нь уг гэрээгээр хөлс төлөх хугацаанаас хамаарч онцлог байдлаар тодорхойлогдох нь бий. Тухайлбал, хөлсийг өдрөөр төлөхөөр тохиролцсон бол хөлс төлсөн сүүлчийн өдрийн дараа өдөр гэрээг цуцалж болно г.м
	Бусад төсөөтэй гэрээнээс ялгах нь:	Ажил гүйцэтгэх гэрээний сэдэвт дурдсан ялгааг үзнэ үү

Хөдөлмөрлөх нас хэтэрсэн ахмад настан хөлсөөражиллахгэрээгээральнэгбайгууллагад ажиллах, үндсэн ажлын байр бүхий ажилтан өөр ажил мэргэжил давхар эрхлэхдээ хөлсөөр ажиллах гэрээ байгуулах нь бий

ЖИШЭЭЛБЭЛ



Дасгал

1. Нэгэн хувийн компани өөрийн боловсон хүчнийг бүрдүүлэхдээ тэтгэвэрт гарсан А-г ажилд авсан учраас хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан байна. Уг компаний үйл ажиллагаа нь алдаатай байснаас дампуурахад хүргэсэн бөгөөд ажиллагч нарын цалин, хөлсийг тавих боломжгүй болсон байна. Ийнхүү цалин тавьж чадахгүй байснаас ажиллагч нараас гомдол гаргасан учраас хөдөлмөрийн хөлсний оронд өөрийн үйлдвэрийн бүтээгдэхүүн болох савласан будааг тараахаар болжээ.

А хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд хөдөлмөрийн хөлсийг зөвхөн мөнгөн хэлбэрээр авах ёстой гэсэн байна. Харин компани А-тай хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй бөгөөд гэрээнд хөлсний хэлбэрийг тохиролцоогүй учраас будаа өгч болно гэсэн байна.

- Энэ тохиолдолтой төсөөтэй гэрээнүүдийн ялгааг тайлбарлана уу?
- Хөлсөөр ажиллах гэрээний онцлог шинжийг энэ тохиолдолтой холбон ярилцана уу?
- Хууль зүйн үндэслэлийг тодорхойлон, маргаан шийдвэрлэх боломжийг тодорхойлно уу?

2. Өмнө дурдсан жишээнээс гадна өөр терлийн жишээг сонгон түүнд тохирсон гэрээний загвар боловсруулж, энэ гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд анхаарах асуудлуудыг хэлэлцээрэй.
3. Иргэний хуулийн 359-368 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох ажиллагч, ажиллуулагчийн эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

1. Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллуулагч нь,
 - a. зөвхөн хөлс төлөх уурэг хүлээж байдаг,
 - b. ажиллагчийг ажлын байраар хангах уурэг хүлээнэ,
 - c. гэрээнд заасан тохиолдолд л ажлын байраар хангах уурэг хүлээнэ
 - d. багаж, тоног төхөөрөмжөөр хангах уургийг л зөвхөн хуульд зааснаар хүлээнэ
2. Хөлсөөр ажиллах гэрээ нь,
 - a. гэрээнд заасан бол хариу төлбөртэй,
 - b. хариу төлбөргүй гэрээ,
 - c. аль аль нь биш. Яагаад гэвэл
3. Хөлсийг өдрөөр өгөхөөр тохиролцсон бол,
 - a. хөлс өгсөн өдөр гэрээг цуцалж болно,
 - b. хөлс өгөхөөс өмнөх өдөрт гэрээг цуцалж болно,
 - c. хөлс өгсөн өдрийн дараа өдрөөс гэрээг цуцалж болно,
 - d. уг гэрээг цуцлах нь хөлс өгөхтэй ямар ч хамааралгүй

4. Хөлсөөр ажиллах гэрээтэй холбоотой маргааныг пшйдвэрлэхэд,
 - a. зөвхөн хөлсөөр ажиллах гэрээг зохицуулсан хуулийн зүйл заалтыг хэрэглэнэ,
 - b. ажил гүйцэтгэх гэрээний зохицуулалтыг хэрэглэнэ
 - c. бусад гэрээний зохицуулалтыг хэрэглэж болно
 - d. тухайн хэрэг таргаанд шаардлагатай аль ч зохицуулалтыг хэрэглэж болно
5. Хөлсөөр ажиллах гэрээний загвар боловсруулан, аль загвар хуулийн хүрээнд, хүчин төгөлдөр болсон эсэхийг солилцон дүгнэлт хийгээрэй



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I-III дэд хэсэг, II хэсэг 359-368 р зүйл
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 137-140 р тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 80-82 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ПХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 343-347 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под. ред. Платонова.Д. И 68 р тал

3. Аялал жуулчлалын гэрээ

Сэдвийн зорилго: Аялал жуулчлалын гэрээний ойлголт, үндсэн шинж, төрөл, онцлогийн талаар мэдлэгийг эзэмшиж, хууль зүйн дагуу тус гэрээг боловсруулах чадварыг эзэмшинэ.



Нэр томъёоны тайлбар

Аялал жуулчлалын байгууллага - аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүрдүүлэх, сурталчлах, худалдах, худалдан авах, аялал жуулчлалын багц буюу тухайлсан үйлчилгээг зохион байгуулж байгаа ашгийн төлөө хуулийн этгээд,

Жуулчин - аялал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн



Гэрээний нэг тал болох аялал жуулчлал зохион байгуулагч нь жуулчинд хэлэлцэн тохиролцсон үйлчилгээ үзүүлэх, нөгөө тал болох жуулчин нь ийнхүү үйлчилгээ үзүүлсэний төлөө хэлэлцэн тохиролцсон хөлс төлөх үүргийг харилцан хүлээж байдаг гэрээг аялал жуулчлалын гэрээ гэнэ

Гэрээний онцлог

Энэ гэрээ нь хоёр талын, урьдчилан тохиролцсон, хариу төлбөртэй, тодорхой болон тодорхой бус хугацаатай гэрээ юм

а. Аялал жуулчлалын гэрээний зүйл нь онцлог бөгөөд аялал жуулчлалтай холбоотой цогц үйлчилгээ байдаг

б. Гэрээний хэлбэрийн хувьд амаар болон бичгээр хийгдэх бөгөөд гэрээ байгуулах аргын хувьд нийтлэг журмаар буюу электрон хэлбэрээр байгуулагдаж болно

в. Энэ гэрээг зөвхөн иргэний хуулиар бус аялал жуулчлалын тухай бие даасан хуулиар зохицуулж байна. Уг хуульд зааснаар аялал жуулчлалын үйлчилгээг аялал жуулчлалын байгууллага эрхлэн явуулахаар зохицуулсан байна. Аялал жуулчлалын байгууллагыг туроператор, турагент гэж ангилдаг

г. аялал жуулчлал зохион байгуулагч нь жуулчинтай зөвшилцсон тодорхой үндэслэлээр жуулчинд хохирол учирсан тохиолдолд үйлчилгээний хөлсийг 3 дахин өсгөсөнтэй тэнцэх хэмжээгээр өөрийн хүлээх хариуцлагаа хязгаарлаж болно

д. гомдлын шаардлага гаргах, хөөн хэлэлцэх тусгайлсан хугацаатай

**Аялал
жуулчлалын
гэрээг субъектээс
нь хамааран бусад
гэрээнээс ялгах
шаардлагатай**

Жишээ нь, иргэн Наран өөрийн эзэмшсэн хэлний мэдлэгээ ашиглан зуны саруудад хувиараа жуулчидад үйлчилгээ үзүүлэн хөтөч-орчуулагч хийдэг. Энэ нь аялал жуулчлалын гэрээ биш. Учир нь дээр дурдсанчлан аялал жуулчлалын гэрээнд субъектийн тусгайлсан шаардлага тавигддаг



Дасгал

1. АНУ-ын иргэн Жорж Монголын нэгэн жуулчны компанитай гэрээ байгуулан Монголын үзэсгэлэнт газруудаар аялахаар тохиролцжээ. Үнийг нь дараа төлөхөөр болсон байна. Жуулчлах явцад Жорж гэрээгээ цуцалж, хөлс төлөхөөс татгалзсан байна. Учир нь, Жоржид үзүүлсэн байгалийн үзэсгэлэнт газрууд түүнд огтхон ч таалагдаагүй гэжээ.
 - Аялал жуулчлалын гэрээний зүйл юу вэ? Сэтгэл ханамжийг хэрхэн үнэлж үзэх вэ?
 - Дээр дурдсан үндэслэл нь гэрээ цуцлах, хөлс төлөхөөс татгалзах үндэслэл болж чадах уу?
 - Хуулийн үндэслэлийг тодорхойлно уу?
2. Герман улсын иргэн болох Клаус, Тина нар "Өргөө" ХХК-тай гэрээ байгуулан хангайн нутгуудаар жуулчлахаар тохиролцон хөлс төлжээ. Мориор аялахаар талууд хүлээн зөвшөөрсөн байна. "Өргөө" ХХК хоёр морь хөлслөн авсан ба жуулчин Клаусын унасан морь нь булгиж тэрээр мориноос унан хүнд гэмтэл авчээ. Клаус гэрээг цуцлахаар болж, эрүүл мэндийн зардал, буцах зардлаа төлүүлэхээс гадна, урьдчилж өгсөн аялалын зардлын үнийг бууруулахыг тус тус шаарджээ.
 - Аялал доголдолгүй байх гэдэг ойлголтыг тайлбарлана уу?
 - Клаусын шаардлагыг хангах хуулийн үндэслэл бий эсэхийг тодорхойлно уу?
 - "Өргөө" ХХК хариуцлага хүлээх үү?
3. Туроператор, турагент гэж юу вэ? Тайлбарлана уу?
4. Иргэний хуулийн 370-379 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний



талууд болох аялал жуулчлал зохион байгуулагч, жуулчний эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай

5. Аялал жуулчлалын гэрээний загвар боловсруулан хариуцлагаа хязгаарлах асуудлыг хэрхэн тусгах талаар ярилцан, үр дүнг нь хэлэлцээрэй



Сорил

1. Аялал жуулчлалыг зохион байгуулагч нь,
 - a. иргэн, хуулийн этгээд аль нь ч байж болно,
 - b. зөвхөн хуулийн этгээд байна,
 - c. зөвхөн аялал жуулчлалын байгууллага байна,
 - d. аль аль нь биш. Яагаад гэвэл.....
2. Аялал жуулчлалын гэрээний дагуу,
 - a. байгалийн үзэсгэлэнт газруудыг узуулнэ,
 - b. музей узуулнэ,
 - c. жуулчдыг тээвэрлэнэ,
 - d. аль аль нь хамааралтай. Яагаад гэвэл.....
3. Аялал жуулчлалын гэрээнд гомдлын шаардлага гаргах хугацаа нь,
 - a. 6 сар, b. 3 сар,
 - c. 1 сар, d. 1 жил



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 370-379 р зүйл
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 80-82 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998 368-372 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под. ред Платонова.Д.И, 81 р тал

4. Тээвэрлэлтийн гэрээ

Сэдвийн зорилго: Тээвэрлэлтийн гэрээний ойлголт, үндсэн шинж, төрөл, онцлогийн талаар онолын мэдлэгийг эзэмшиж, хууль зүйн дагуу тус гэрээг боловсруулах, үйлчлүүлэгчид хууль зүйн тусалцаа үзүүлэх чадварыг эзэмшинэ.



Нэр томъёоны тайлбар

Тээвэрлэлт - тээврийн хэрэгслээр зорчигч болон ачаа, тээшийг нэг газраас нөгөө газарт хүргэхтэй холбогдсон ажил, үйлчилгээ,
Ачаа тээвэрлэлт - тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй эд зүйлсийг нэг газраас нөгөө газарт хүргэхтэй холбогдсон ажил, үйлчилгээ;
Зорчигч тээвэрлэлт - тээврийн хэрэгслээр зорчиж байгаа хүнийг нэг газраас нөгөө газарт хүргэхтэй холбогдсон ажил, үйлчилгээ
Тээвэрлэгч - тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээд,

Гэрээний нэг тал болох тээвэрлэгч нь зорчигч буюу ачаа, тээшийг тогтоосон газарт хүргэх, нөгөө талаас ачаа, тээш эзэмшигч, зорчигч буюу гуравдагч этгээд тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлсний төлөө халэлцэн тохиролцсон хөлс төлөхөөр үүрэг хүлээсэн гэрээг *тээвэрлэлтийн гэрээ* гэнэ



Энэ гэрээ нь хоёр талын, бодит болон урьдчилан тохиролцсон, хариу төлбөртэй, тодорхой болон тодорхой бус хугацаагаар байгуулж болно



Гэрээний онцлог

- а. Гэрээний тусгай төрлүүдийн хувьд онцлог. Үүнд,
- Тээврийн хэрэгслийн нөхцлөөр нь төмөр зам, усан зам, автозам, агаарын, дамжуулах хоолойн гэх мэт
 - Тээвэрлэлтийн гэрээний өвөрмөц төрлүүдэд, буксирын буюу тодорхой төхөөрөмжийг түлхэх, чирэх механизмаар нэг газраас нөгөөд хүргэх /ихэвчлэн далайн тээврийн үед онцлог байдлаар хийгддэг/ гэрээ, *ачаа тээвэрлэх гэрээ, зорчигч тээвэрлэх гэрээ* гэсэн төрлүүд хамаарна.
 - Тээвэрлэх хэлбэрийн хувьд, шууд тээвэр, шууд дамжих тээвэр, шууд холимог тээвэр гэж ангилсан нь бий

- б. Гэрээ байгуулах аргын хувьд онцлог. Тээвэрлэлтийн гэрээ нь ихэнх тохиолдолд нийтлэг журмаар байгуулагддаг ч ийнхүү ачаа болон зорчигч тээвэрлэхээр нийтэд санал болгож байгаа этгээд хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй бол уг гэрээг заавал байгуулах үүрэгтэй юм


- в. Тээвэрлэгч тээвэрлэлтийн гэрээний хугацаанд тээвэрлүүлэгчид учирсан гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй ч энэ үүрэг хэрэгжихэд түүний гэм буруу буюу санаатай эсвэл илтэд болгоомжгүй үйлдэл, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал зэрэг нь нөлөөлөх бөгөөд ийнхүү хариуцлага хүлээх асуудлыг тээвэрлэлтийн гэрээнээс гадна тээвэрлэлтийн холбогдох дүрмээр зохицуулах онцлогтой

Ачаа тээвэрлэлтийн гэрээ

- Ачаа тээвэрлэлтийн гэрээ нь тээвэрлэлтийн гэрээний голлох төрөл юм. Энэ нь хэлбэрийн хувьд дагалдах бичгийн буюу ачааны талаар хангалттай мэдээлэл бүхий бичгэн хэлбэрээр хийгдэнэ. Гэхдээ энэ нь гэрээ хүчинтэй байхад нөлөөлдөг шаардлага биш бөгөөд дагалдах бичиггүйгээр хийгдсэн ачаа тээвэрлэлтийн гэрээний хувьд тээвэрлэгчид хариуцлага оногдуулах, гэрээний маргааныг бодитойгоор шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлөх талтай ч гэрээ хүчин төгөлдөр байна
- Энэ гэрээний хувьд тээвэрлэгчид хариуцлага хүлээлгэхэд тээвэрлэлтийн гэрээний өмнөх бүлэгт дурдсан нийтлэг журам хамааралтай ч тээвэрлэгч эсвэл ачаа илгээгчид хариуцлага хуваарилахдаа тэдгээрийн гэм буруугийн хэлбэр, ачааны онцлог байдлыг харгалзан үзнэ

- Энэ гэрээ нь зорчигч тээвэрлэлтийн гэрээнээс ялгагдах гол ялгаа нь тээвэрлэж буй зүйлээс гадна, гэрээний талуудаар ялгагдана. Өөрөөр хэлбэл ачаа тээвэрлэлтийн гэрээнд доорх субъектүүд оролцоно

Ачаа
тээвэрлэлтийн гэрээ



Ачаа илгээгч ↔ Тээвэрлэгч ↔ Ачаа хүлээн
авагч

Дээр дурдсан субъектүүдийн хувьд аль аль нь гэрээнд зохих үүрэгтэй, эдлэх эрхтэй оролцож байгаа хэдий ч гэрээний аливаа сөрөг үр дагаврыг хэн нь хариуцах талаар буюу эрх, үүргийн хуваарилалтын талаар маргаан гарах нь цөөнгүй байдаг.

Зорчигч тээвэрлэлт

Зорчигч тээвэрлэлтийн гэрээг зорчих пайз, тасалбарыг зорчигчид гардуулснаар байгуулагдсан гэж үздэг. Тус пайз, тасалбарыг бусдад дамжуулахаар болон үл дамжуулахаар үйлдэж болдог бөгөөд бусдад дамжуулах боломж тээвэрлэлт эхлэхэд дуусна. Уг гэрээний онцлог нь тээвэрлэлтийн зүйл нь зорчигч оюу бодгаль этгээд байдаг бөгөөд энэ утгаараар тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаарддаг. Тухайлбал: ачааны машинаар хүн тээвэрлэж байгаа бол уг машин зориулалтын суудалтай байх, нийтийн тээврийн хэрэгсэлд болон түүний жолоочид тусгайлсан шаардлага тавих гэх мэт

Тээвэрлэлтийн гэрээний хувьд зүйлчлэлийн ялгааг тодотгох хэд хэдэн шинж бий. Юуны өмнө тээвэрлэлтийн гэрээ зөвхөн хариу төлбөртэй байх асуудал юм. Тэгвэл хариу төлбөргүйгээр тээвэрлүүлэхэд энэ нь тээвэрлэлтийн гэрээ биш туслалцаа үзүүлэх өөр төрлийн гэрээ болох магаддалтай. Илгээмжийн гэрээгээр мөн л ачаа, илгээмжийг нэгээс нөгөөд хүргэх агуулгатай ч гол ялгаа нь илгээмжийн гэрээ нь тээвэрлэлтийн гэрээний нөхцөлийг хамтад нь багтаасан өргөн хүрээний цогц үйлчилгээ үзүүлэх байдаг гэх мэтчилэн тааагийн мэдлэг, чадварыг төсөөтэй гэрээнүүдээс ялган сорьж үзээрэй



Дасгал

- Авто тээврийн А компани хот хооронд зорчигч тээвэрлэдэг. Иргэн Лувсан тээврийн хөлс төлөхгүйгээр хулгайгаар тээврийн хэрэгсэлд сууж явсан байна. Бүрэн бус техниктэй замд гарсан жолоочийн буруутай үйл ажиллагаанаас хамааран машины мотор цохиж зайлшгүй зогсолт хийсэн ба улмаар энэ үеэр зорчигчдын тээш алдагдсан байна. Лувсан тээш алдсанаас учирсан хохирлоо жолооч Дандараас нэхэмжлэхэд, Дандар зөвхөн тасалбар авсан зорчигчдын эд зүйлсийг л хариуцах ёстой учраас хохирлыг барагдуулахгүй гэжээ.
 - Зорчигчдод учирсан хохирлыг хэн хариуцах вэ?
 - Тээвэрлэгчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл байна уу?
 - Хуулийн үндэслэлийг тодорхойлон хохирлыг барагдуулахгүй болон хөлс шаардах боломжтой эсэхэд дүгнэлт хийнэ үү?
- Дараах сэдвүүдээс сонгон реферат бичнэ үү.
 - Нийтийн тээврийн эрх зүйн зохицуулалтын онцлог
 - Тээвэрлэлтийн гэрээний онцлог, ач холбогдол
 - Тээврийн хэрэгслийн онцлог төрөл тээвэрлэлтийн гэрээнд нөлөөлөх нь
- Иргэний хуулийн 380-398 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох тээвэрлэгч, зорчигч, ачаа илгээгч, ачаа хүлээн авагчийн эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

- Тээвэрлэлтийн гэрээний субъект нь,
 - тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч
 - тээвэрлэгч буюу тээврийн хэрэгслийн эзэмшигч, зорчигч,
 - тээвэрлэгч буюу тээврийн хэрэгслийн эзэмшигч, зорчигч, ачаа илгээгч, ачаа хүлээн авагч
- Тээвэрлэлтийн гэрээ нь,
 - зөвхөн хариу төлбөртэй байна,
 - гэрээнд тохиролцсон эсэхээс хамаарна,
 - хариу төлбөргүй байна,
 - хариу төлбөртэй болон төлбөргүй байж болно,.
- Ачаа тээвэрлэлтийн гэрээний онцлог

Зорчигч тээвэрлэх гэрээний онцлог	Зорчигч тээвэрлэх гэрээний онцлог
.....	
.....	
- Ачааны дагалдах баримт бичиг нь,
 - гэрээний хавсралт,

- b. гэрээ хийсний нотолгоо,
c. аль нь ч биш. Яагаад гэвэл.....

5. Тээвэрлэгчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэлүүдийг нэрлэнэ үү?

.....



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 380-398 р зүйл
- Иргэний эрх зүй. Үүргийн тусгай төрөл. Т.Мөнхжаргал 76-86 р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 141-142 р тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 80-82 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 349-372 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под.ред Платонова. Д.И 69-81 р тал

5. Хөрөнгө итгэмжлэх гэрээ

Сэдвийн зорилго: Хөрөнгө итгэмжлэх гэрээний эрх зүйн зохицуулалтын талаар онолын мэдлэг олж, бие даан уг гэрээг боловсруулах, үйлчлүүлэгчид хууль зүйн туслалцаа үзүүлэх чадвар эзэмшинэ.



Нэр томъёоны тайлбар

Хөрөнгө итгэмжлэх- өмчлөгч этгээд өөрийн өмчлөлийн хөдлөх хөрөнгө болон эрхийг түүний ашиг сонирхолд нийцүүлэн захиран зарцуулах эрх, үүргийг өөр этгээдэд хүлээлгэж буй ажиллагаа

Итгэмжлэгдсэн өмчлөгч - итгэмжилсэн хөрөнгийг захиран зарцуулах үүргийг гэрээний үндсэн дээр харилцан тохиролцож, хүлээсэн этгээд



Нэг тал болох итгэмжлэгч нь хөдлөх эд хөрөнгө бөгөөд эрхийг гэрээний нөгөө тал болох итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлэх, итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг хүлээн авч, итгэмжлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн, захиран зарцуулах үүрэг хүлээн харилцан тохиролцож байгуулсан гэрээг хөрөнгө итгэмжлэх гэрээ гэнэ

Энэ гэрээ
нь хоёр талын
үүрэг, бодит
гэрээ юм

а. хөрөнгө итгэмжлэх гэрээг бичгээр байгуулна гэж зохицуулсан нь түүнийг энгийн хэлбэртэй бичгэн гэрээ болгож байгаа бөгөөд үр дагаврын хувьд уг гэрээг бичгээр байгуулаагүй тохиолдолд хүчин төгөлдөр байх ба маргаан гарсан тохиолдолд шүүхэд гэрчээр нотлуулах эрхээ алдана

б. итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг өөрийн нэрийн өмнөөс, итгэмжлэгчийн зардлаар, итгэмжлэгчийн эрсдлээр захиран зарцуулах үүрэгтэй

в. Энэ гэрээгээр итгэмжлэн шилжүүлэх хөрөнгө нь зөвхөн хөдлөх хөрөнгө, эд хөрөнгийн эрх байна. Тодорхой хөрөнгийг өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн захиран зарцуулуулахаар итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлдэг учир үл хөдлөх хөрөнгийн хувьд ийнхүү шилжүүлэх нь улсын бүртгэлд бүртгүүлэх зэргээр нэг талаас хүндрэлтэй, нөгөө талаас бүртгэлээр тодорхойлогдсон "туйлын" эрх эдлэх эрхийг олгох нь эрсдэлтэй байдагтай холбоотой


г. Талууд гэрээгээр тохиролцсон эсэхээс хамааран уг гэрээ хариу төлбөртэй эсвэл хариу төлбөргүй байх ойлголт яригдана. Өөрөөр хэлбэл, энэ нь гэрээнд өөрөөр заагаагүй бол гэсэн тодотголтой зохицуулагдсан байна

д. Энэ гэрээний шаардлага буюу ач холбогдол нь итгэмжлэгч өөрөө хөрөнгөө захиран зарцуулах бодит боломжгүй нөхцөлд, түүнчлэн итгэмжлэгдсэн өмчлөгч уг үйлддийг өөрөөс нь илүү гүйцэтгэх боломж, ашиг сонирхлыг нь хангана гэсэн итгэлд тулгуурлан хийгддэг


ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 2

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ
ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Бусад төсөөтэй ойлголт гэрээнээс ялгах нь:



ЖИШЭЭЛБЭЛ



Иргэн Жаргалсайхан өвчний улмаас хэвтэрт орсон бөгөөд өөрийн өмчлөлийн автомашинийг дүү Жавхланд шилжүүлэн өөрийн хүссэн үнээр худалдуулахаар тохиролцох үйлдэл, банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны нэг төрөл болох итгэлцлийн үйлчилгээ буюу байршуулсан активыг өөрийн нэрийн өмнөөс итгэмжлэгчид ашигтай хувилбараар захиран зарцуулах үйлдэл



Дасгал

- Хөрөнгө итгэмжлэх гэрээний ач холбогдол, давуу талуудыг тодорхойлно уу?
 - Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах итгэлцлийн гэрээнд дүгнэлт хийн ярилцаарай
 - Хөрөнгө итгэмжлэх гэрээний загвар боловсруулан, харилцан солилцож, талуудад ашигтай хувилбарыг санал болгох байдлаар харилцан ярилцаарай
2. Гадаадад удаан хугацаагаар томилолтоор явах болсон Туяа өөрийн өмчлөлийн 2 өрөө байр, автомашин, гэрийн тавилга зэргийг наймаа хийдэг найз Төгөлдөрт шилжүүлэн тогтоосон үнээр худалдаж өгөхийг хүссэн байна. Туяа худалдсан үнийг дансаар шилжүүлэн автал хэлсэн үнээс хэт доогуур худалдсан болох нь тогтоогдон маргаан үүссэн байна



- Өгөгдсөн тохиолдол нь хөрөнгө итгэмжлэх гэрээний маргаан мөн эсэх, гэрээний үндсэн шинжийг агуулсан эсэхэд үнэлэлт хийнэүү?
- Дээрх тохиолдолд хуулийн үндэслэлийг тодорхойлон маргааныг хэрхэн шийдвэрлэж болохыг ярилцана уу?

3. Иргэний хуулийн 406-р зүйлийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох итгэмжлэгч, итгэмжлэгдсэн өмчлөгчийн эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай



Сорил

1. Хөрөнгө итгэмжлэх гэрээгээр шилжүүлж болох зүйл нь,
 - a. зөвхөн хөдлөх хөрөнгө байна,
 - b. үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, хөрөнгийн эрх байна,
 - c. үл хөдлөх хөрөнгөөс бусад ямар ч хөрөнгө, эрх байж болно,
 - d. ямар хөрөнгө байхыг гэрээгээр л шийдвэрлэнэ,
2. Хөрөнгө итгэмжлэх гэрээ нь,
 - a. хариу төлбөртэй гэрээ,
 - b. хариу төлбөргүй гэрээ,
 - c. тодорхой хугацаатай гэрээ,
 - d. Тодорхой бус хугацаатай гэрээ,
 - e. аль аль нь мөн Яагаад гэвэл



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 406 р зүйл
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 80-82 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998,597-615 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под.ред Платонова.Д.И 124-128 р тал

6. Зуучлалын гэрээ, худалдааны зуучлал, комисс

Сэдвийн зорилго: Гэрээний үүргийн тусгай төрлүүд болох зуучлалын гэрээ, худалдааны төлөөлөгч, комиссийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг танин мэдэж, уг гэрээнүүдийг гэрээний үүргийн бусад төрөл, төсөөтэй гэрээнээс ялгаж зүйлчлэх чадвар эзэмшин, энэ төрлийн гэрээг байгуулах, гэрээний маргааныг шийдвэрлэх, хууль зүйн тусалцаа үзүүлэх чадвартай болно.



Нэр томъёоны тайлбар

Зуучлалын үйл ажиллагаа - зуучлуулж буй этгээдээс олгосон эрхийн дагуу, түүний ашиг сонирхолын төлөө хариу төлбөртэй болон хариу төлбөргүйгээр хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх үйлдэл,

Худалдааны зуучлал - худалдааны буюу аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах этгээдтэй холбож өгөх үйлдэл,

Комисс - өөрийн нэрийн өмнөөс, гэхдээ бусдын зардлаар барааг борлуулж, эрх хэрэгжүүлэх этгээдийг

Худалдааны төлөөлөгч - Үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар гэрээ байгуулах буюу бараа, эрх үйлчилгээг борлуулах хэлцэл хийгч этгээдийг

Дистрибьютер - бараа борлуулах эрх олж авсан этгээд, борлуулагч

Нэг тал болох зуучлагч нь зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхолын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, зуучлуулагч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлс, шагнал төлөх үүрэг бүхий гэрээг зуучлалын гэрээ гэнэ.



Хоёр талын, урьдчилан тохиролцсон, хариу төлбөртэй болон хариу төлбөргүй, тодорхой болон тодорхой бус хугацаатай гэрээ



Гэрээний онцлог

- Практикт зуучлал гэсэн үгээр илэрхийлэгдэх олон төрлийн үйлчилгээ байдаг. Хөдөлмөрийн зууч, гэр бүлийн зууч, худалдааны зууч, үл хөдлөх хөрөнгийн зууч г.м. Эдгээрээс чухам аль нь гэрээний үүргийн тусгай төрөлд хамаарах зуучлалын гэрээний үүргийг үүсгэх вэ гэдэг асуудал гарч ирж байна. Өмнө өгүүлсэн гэрээний агуулгаас анхааран үзвэл зуучлалын бүх төрлийн үйлчилгээг зуучлалын гэрээний үүрэг гэж ойлгож болохгүй бөгөөд гэрээний эрх зүйд зөвхөн тодорхой төрлийн гэрээ байгуулахад зуучлах үүрэг хүлээсэн гэрээг зуучлалын гэрээ гэж ойлгох нь зүйтэй. /гэр бүлийн танилцах албаны зуучлал бус/
- Дээрх онцлог шинж болон гэрээний хугацаа, зуучлуулагчийн эрхийг хязгаарласан агуулга бүхий гэрээ байдаг нь зуучлах онцгой эрхийн гэрээ юм. Энэ нь гэрээний хугацаанд зуучлуулагч өөр зуучлагчийн үйлчилгээнээс татгалзах агуулга бүхий зуучлалын гэрээ байдаг
- Ямар төрлийн гэрээ байгуулахад зуучилж байгаагаас хамааран гэрээнд тавигдах шаардлага, хэлбэр тодорхойлогддог

Худалдааны зуучлал. Комисс

Худалдааны зуучлал нь тодорхой хэд хэдэн төрлийн гэрээ байгуулахад /аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой буюу аж ахуйн гэрээ/ зуучлах ойлголт бөгөөд нэг талаас ийнхүү хязгаарлагдмал хүрээгээр, нөгөө талаас олон ойлголтыг багтаасан өргөн хүрээгээр /комисс, худалдааны төлөөлөгч, биржийн худалдаа, дистрибьютер г.м / тайлбарлагдана.

Худалдааны зуучлагч нь худалдааны бусад үйл ажиллагаа явуулах гэдэгт дээрх гэрээтэй холбоотойгоор бий болсон худалдааны харилцаа хамаарах бөгөөд харин үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой зуучлал явуулах, бусад гэрээнд зуучлах нь энэ ойлголтын хүрээнд хамааралгүй байдаг.

Практикт худалдааны зуучлалыг худалдааны төлөөлөгч мэтээр ойлгох, дистрибьютер гэж үзэх байдал олонтаа бий. Хамгийн гол нь худалдааны зуучлалын ойлголт нь худалдаа эрхлэхтэй холбоотойгоор бий болсон дээрх олон талт зуучлалын харилцааг өөртөө багтааж байдгийг ойлгох нь зүйтэй. Олон улсын харилцаанд худалдааны зуучлалын хэд хэдэн хэлбэр байдаг. Үүнд:

1. барааг дамжуулан худалдаалах
2. комиссын
3. агентын
4. брокерын

Үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар гэрээ байгуулах буюу бараа, эрх үйлчилгээг борлуулахад зуучилж байгаа этгээдийг худалдааны төлөөлөгч гэж иргэний хуулиар тодорхойлсон бол өөрийн нэрийн өмнөөс, гэхдээ бусдын зардлаар барааг борлуулж, эрх хэрэгжүүлэх этгээдийг комисс гэж тодорхойлсон байна. / Иргэний хуулийн 415.1, 415.2/

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 2

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ
ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Жишээ нь "Сүү" ХК-ний гэрээт борлуулагч болох Туяа өдөрт 500 литр сүү борлуулан орлогоо тушаан, орлогын тодорхой хувийг авч байгаа нь...

ХУДАЛДААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ

КОМИСС

Жишээ нь сүлжээний дэлгүүрүүд барааг бэлэн мөнгөөр авахгүйгээр үйлчлүүлэгчийн хэлсэн үнээр борлуулах ажиллагааг өөрөө явуулан, эцэст нь борлуулалтын орлогыг тушаан, хураамж, ашгийн тодорхой хувийг авч байгаа нь...

Бусад төсөөтэй гэрээнээс ялгах нь	Зуучлалын гэрээ болон худалдааны зуучлал, комисс, худалдааны төлөөлөгчийн хэлбэрийн зуучлал нь өөр хоорондоо ихээхэн төсөөтэй ч хэний зардлаар, хэний нэрийн өмнөөс уг гэрээг байгуулан, үр дагаврыг бий болгож байгаагаараа харилцан ялгагдана. Жишээ нь, комисс нь өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй гэрээ байгуулж хууль зүйн үр дагавар бий болгодгоороо зуучаас ялгаатай.
Гэрээний жишээ	Дэлгүүр, лангуунд эд зүйл тавьж заруулах, гэрээт борлуулагчийн үйл ажиллагаа явуулах /мобикомын гэрээт борлуулагч, АПУ-ын гэрээт борлуулагч г.м/, SWATCH цагны үйлдвэрийн дистрибьютер буюу монголд борлуулах эрхийг авч борлуулалт хийх үйл ажиллагаа, зээлийн гэрээ байгуулахад зуучлах г.м



Дасгал

1. Азаа вакум цонх үйлдвэрлэдэг байна. Үйлдвэрлэлтээс борлогдоогүй үлдсэн 150 цонхоо худалдахаар хүн олж өгөхийг борлуулалтын менежерийн ажилтай Батнаагаас хүсчээ. Тэрээр худалдан авагч Вангантай уулзуулж өгсөн бөгөөд тээвэрлэлтийн асуудлыг давхар шийдвэрлэх үүднээс жолооч Самдантай бас давхар уулзуулсан байна. Үүнийхээ хөлсөнд аль аль талуудаас 100.000 төгрөг авахаар тохиролцжээ



Тээвэрлэлтийн явцад 100 цонх хагарсан учраас худалдагч, худалдан авагч аль аль талууд гэрээнээс татгалзаж, хөлс төлөхөөс татгалзжээ.

- Дээрх тохиолдолд гэрээний зүйлчлэлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?
 - Маргааныг шийдвэрлэх хуулийн үндэслэл?
 - Өгөгдсөн тохиолдол дээр ажиллан ямар асуудлаар шийдвэр гаргахад хүндрэлтэй байсныг хэлэлцэх
2. - Зуучлал, худалдааны зуучлал, комиссийн гэрээнүүд яагаад туслалцаа үзүүлэх гэрээний үүрэгт хамаарч байгааг ярилцаарай
- Зуучлалын гэрээ, худалдааны зуучлалын гэрээ, комиссийн гэрээ байгуулан, гэрээний агуулга, хариуцлага болон бусад асуудлыг хэрхэн тусгах талаар харилцан бие биедээ хууль зүйн туслалцаа үзүүлээрэй
 - Худалдааны дистрибьютер, худалдааны төлөөлөгч, агентийн болон биржийн худалдааны гэрээнүүдийг ялган тайлбарлаарай
3. Иргэний хуулийн 410-419 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох зуучлагч, зуучлуулагчийн эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

1. Баяраа нарийн боовны цехэд борлуулагчаар ажилладаг. Тэрээр өдөрт 100 кг нарийн боов борлуулах үүрэгтэй. Борлуулалтаас олсон орлогын 0.5 хувиар цалинждаг байна. Энэ нь,
- a. дистрибьютерийн гэрээ,
 - b. гэрээт борлуулагч,
 - c. агентын гэрээ,
 - d. комиссийн гэрээ,
 - e. бусад
2. Түрээсийн гэрээ байгуулахад зуучлах нь,
- a. худалдааны зуучлалын гэрээ,
 - b. ердийн зуучлалын гэрээ,
 - c. даалгаврын гэрээ,
 - d. бусад
3. Зуучлалын гэрээгээр,
- a. гэр бүл болоход зуучилна,
 - b. үл хөдлөх хөрөнгийн зуучлал явуулна,
 - c. зээлийн гэрээ байгуулахад зуучилна,
 - d. аль алинд нь хамааралгүй.
- Яагаад гэвэл

4. Гэрээний хугацаа, зуучлуулагчийн эрхийг хязгаарласан агуулга бүхий гэрээ нь,
- a. зуучлах онцгой эрхийн гэрээ,
 - b. энгийн зуучлалын гэрээ,
 - c. худалдааны зуучлалын гэрээ,
 - d. аль аль нь төн. Яагаад гэвэл
5. Зуучлалын гэрээ нь,
- a. хариу төлбөртэй болон төлбөргүй гэрээ,
 - b. тодорхой болон тодорхой бус хугацаатай,
 - c. урьдчилан тохиролцсон гэрээ,
 - d. аль аль нь төн



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 410-19 р зүйл
- Иргэний эрх зүй. Үүргийн тусгай төрөл. Т.Мөнхжаргал. 129-132 р тал, 89-96 р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 145-146 р тал, 147-148 р тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 80-82 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 575-595 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под.ред Платонова.Д.И 120 р тал, 118 р тал

7. Даалгаврын гэрээ

Сэдвийн зорилго: Гэрээний үүргийн тусгай төрлүүд болох даалгаврын гэрээний эрх зүйн зохицуулалтыг танин мэдэж, туслалцаа үзүүлэхтэй холбоотой бусад гэрээний үүрэг болон төсөөтэй гэрээнээс ялгаж зүйлчлэх, тухайн төрлийн гэрээг байгуулах, тэдгээртэй холбоотой маргаан шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх чадвар эзэмшиж, асуудалд хууль зүйн үүднээс хандах хандлага төлөвшинө.



Нэр томъёоны тайлбар

Даалгавар - даалгавар өгөгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар зохих хөлс, шагналтайгаар болон хөлсгүйгээр хийж гүйцэтгэх хуулийн дагуу үйлдэл,



Энэ гэрээнд нэг талаас даалгавар өгөгч, нөгөө талаас даалгавар гүйцэтгэгч талууд оролцоно. Даалгавар гүйцэтгэгч нь нөгөө тал болох даалгавар өгөгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар тодорхой үйлдэл хийх, хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол даалгавар өгөгч нь хөлс төлөх үүрэг хүлээхээр харилцан тохиролцсон гэрээг даалгаврын гэрээ гэнэ

а. Даалгаврын гэрээний зүйл нь туслахаа үзүүлж буй үйлдэл, үйл ажиллагаа байна. Өөрөөр хэлбэл, даалгавар гэдэгт даалгавар өгөгчийн ашиг сонирхолын дагуу хийгдэж болох хууль зүйн бүхий л үйлдлийг ойлгож болно.

б. Дээрх үйлдлийн гол онцлог нь даалгавар гүйцэтгэгч даалгавар агагчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар хариу төлбөртэй болон төлбөргүйгээр хийдэгт оршино

в. Энэ гэрээ нь амьдралд харьцангуй өргөн хэрэглэгддэг гэрээ юм. Тухайлбал ажил хэргийн хүрээнд даалгавар өгөх, хариу төлбөргүйгээр хийгдэх боломжтой буюу итгэлцлийн үндсэн дээр тодорхой үйлдэл хийхийг хүсэх\гэр бүл,ойр дотны хүрээ,найз нөхдийн хооронд гэх мэт\,хариу төлбөртэйгээр хэн нэгэнд тодорхой үйлдэл хийхийг хүсэх байдлаар өргөн хүрээгээр хийгдэнэ

г. Даалгавар гүйцэтгэгч нь хууль буюу гэрээний өөрөөр заагаагүй бол даалгаврыг биечлэн гүйцэтгэх,даалгавар өгөгч даалгавраа цуцлах,даалгавар гүйцэтгэгч даалгавраас татгалзах эрхтэй бөгөөд энэ эрхийг хязгаарласан гэрээ хүчин төгөлдөр бус бхйна

д. Даалгавар өгөгчийн хувьд ямар ч үед даалгавраа цуцлах эрхтэй

Гэрээний төрөл	Хоёр талын үүрэг, хариу төлбөртэй ба хариу төлбөргүй, урьдчилан тохиролцсон гэрээ юм. Даалгаврын гэрээг төлөөлөлтийн сонгодог хэлбэр ч гэж үзэх нь бий
Бусад төсөөтэй гэрээнээс ялгах нь	Даалгаврын гэрээг бусад төсөөтэй гэрээнээс ялгах шаардлагатай. Тухайлбал: комиссийн гэрээний хувьд комисс өөрийн нэрийн өмнөөс, агент нь үйлчлүүлэгч буюу өөрийн нэрээр, зуучлалын гэрээний зуучлагч нь зуучлуулагчийг хэлцэл хийх этгээдтэй л холбож өгөх үйлдлүүдийг тус тус хийдэг бол энэ гэрээгээр даалгавар гүйцэтгэгч нь даалгавар өгөгчийн нэрийн өмнөөс хууль зүйн тодорхой үйлдэл хийж байдаг онцлогтой

ЖИШЭЭ НЬ

Эгчийнхээ захисны дагуу дэлгүүрээс түүний мөнгөөр цамц худалдан авах, 30.000 төгрөг өгсөн найздаа хүссэнийх нь дагуу хамгийн сайн гэсэн жолооны автосургууль олж өгөх, хөдөөнөөс өвлийн идэш хүргүүлэхээр танил жолоочдоо дайн явуулах г.м



Дасгал

1. Өмгөөллийн үйл ажиллагаа явуулдаг иргэн Цэнгэл иргэн Цэцгээтэй гэрээ байгуулан гэр бүлийн маргаанд өмгөөлөхөөр тохиролцсон байна. Ийнхүү тохиролцоод тухайн хэрэг маргаантай холбоотой бүхий л нотлох баримт, мэдээллийг бүрдүүлж байтал нэхэмжлэгч болох Цэцгээ өөрийн нөхөр Баясаатай эвлэрлийн гэрээ байгуулсаны үндсэн дээр шүүхэд гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан байна. Өмгөөлөгч Цэнгэл гэрээгээр тохиролцсон хөлс төлөхийг шаардахад, даалгаврыг гүйцэтгээгүй гэсэн шалтгаанаар ийнхүү хөлс төлөхөөс Цэцгээ татгалзсан байна.
 - Энэ гэрээ даалгаврын гэрээ мөн үү?
 - Маргааныг шийдвэрлэх хуулийн үндэслэл?
2. Дараах гэрээ нь хуулийн хувьд хүчин төгөлдөр даалгаврын гэрээ мөн эсэхэд дүн шинжилгээ хийнэ үү?

ДААЛГАВРЫН ГЭРЭЭ (Хууль зүйн туслалцаа үзүүлэх)

200... оны ...-р сарын ...ны өдөр

Нэг талаас.....
..... (цаашид (хуулийн этгээдийн нэр, иргэний эцэг/эх/-ийн нэр, нэр)
"Итгэмжлэгч" гэнэ)-ийгбаримт бичгийн үндсэн дээр ажилтай
-ийнтөлөөлөн, нөгөө талаас.....
.....(цаашид (хуулийн этгээдийн нэр, иргэний эцэг/эх/-ийн нэр, нэр)
"Итгэмжлэгдэгч" гэнэ) -ийг баримт бичгийн үндсэн



дээр ажилтай -ийн нар төлөөлөн энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 399-405 дугаар зүйлийг үндэслэн дараахь нөхцөлтэйгээр харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг заалт

Энэхүү гэрээгээр Итгэмжлэгдэгч нь Итгэмжлэгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар хууль зүйн дараахь үйлдлийг гүйцэтгэнэ. Үүнд:

.....
.....

(гүйцэтгэх хууль зүйн үйлдлийг жагсааж бичнэ үү)

Гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлдлийг хийсний төлбөрт төгрөгийн хөлс олгоно.

Хөлсний хувийг энэ гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш хоногийн дотор, үлдэх. хувийг энэ гэрээ дуусгавар болоход гэрээний үүргийн биелэлтийг талууд дүгнэснээс хойш хоногийн дотор олгоно. Энэ хугацаанд олгоогүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөөгүй үлдсэн хөлсний үнийн дүнгийн хувиар алданги төлнө.

2. Итгэмжлэгдэгчийн эрх, үүрэг

Итгэмжлэгдэгч нь Итгэмжлэгчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

Итгэмжлэгдэгч нь даалгаврыг гүйцэтгэхдээ Итгэмжлэгчийн өгсөн зааврын дагуу гүйцэтгэх үүрэгтэй.

Итгэмжлэгчийн ашиг сонирхлын үүднээс түүний өгсөн зааврыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ талаар урьдчилан мэдэгдэх боломжгүй байсан, эсхүл мэдэгдсэн боловч хугацаанд хариу аваагүй бол Итгэмжлэгдэгч уг зааврыг өөрчлөх эрхтэй.

Итгэмжлэгдэгч нь Итгэмжлэгчийн шаардлагаар гүйцэтгэж байгаа ажлын явцын талаар мэдээлэх, үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан түүнээс хүлээж авсан бүх зүйлийг нэн даруй буцааж өгөх үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд даалгавар гүйцэтгэх ажиллагаанд Итгэмжлэгчийг оролцуулна.

Гэрээгээр тохирсон хөлс, даалгавар гүйцэтгэхэд гарах зайлшгүй зардал, гэрээний үүргийг гүйцэтгэхтэй холбоотой мэдээ, материал, бусад баримтыг Итгэмжлэгчээс шаардах эрхтэй.

3. Итгэмжлэгчийн эрх үүрэг

Итгэмжлэгч нь өгсөн даалгаврынхаа гүйцэтгэлийг хугацаанд нь хүлээн авах, даалгавар гүйцэтгэхтэй холбогдох өөрөөс хамааралтай мэдээ, материал, бусад баримт, зардныг Итгэмжлэгдэгчид хугацаанд нь өгөх үүрэгтэй.

Гэрээнд заасан хөлсийг Итгэмжлэгдэгчид төлнө.

Итгэмжлэгдэгчийн явуулж байгаа үйл ажиллагаатай танилцах, зааварчилгаа өгөх, өөрчлөх эрхтэй.

Итгэмжлэгдэгчийн явуулж байгаа үйл ажиллагаанд даалгавар өгөгч биечлэн оролцох шаардлагатай тохиолдолд өөрөө биечлэн эсвэл боломжгүй үед өөрийн төлөөлөгчийг оролцуулах үүрэгтэй.

4. Бусад заалт

Энэ гэрээ талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээг дүгнэх хүртэл (даалгавар гүйцэтгэх, талуудын тооцоо хийх) бүх хугацааны турш үйлчилнэ.

Гэрээг 2 хувь үйлдэж талууд нэг нэг хувийг хадгална. Итгэмжлэгч өгсөн даалгавраа цуцалсан, Итгэмжлэгдэгч нь даалгавар гүйцэтгэхээс татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд Иргэний хуулийн 402-р зүйлд зааснаар нэг тал нөгөө талдаа учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарвал талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

Талуудын хаяг

3. *Иргэний хуулийн* 399-405 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох даалгавар өгөгч, даалгавар гүйцэтгэгийн эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

- Нараа өөрийн дүү Насанд 50.000 төгрөг өгч замаараа танилындаа оруулж өгөхийг хүссэн байна. Насан замдаа мөнгийг гэсэн байна. Энэ нь
 - даалгаврын гэрээ мөн.
яагаад гэвэл.....
 - даалгаврын гэрээ биш.
яагаад гэвэл.....
- Даалгаврын гэрээ ажил гүйцэтгэх гэрээ, зуучлалын гэрээнээс хэрхэн, ямар шинжээр ялгагдах вэ?
- Даалгавар өгөгчийн зааварчилгаар аюултай нөхцөл байдалд даалгавар гүйцэтгэснээс үүссэн хохирлыг,
 - даалгавар гүйцэтгэгч буруугүй бол даалгавар өгөгч уг хохирлыг хариуцна,
 - гэм бурууг харгалзахгүйгээр даалгавар гүйцэтгэгч хохирлыг хариуцна,
 - аль аль нь тохиролцон хариуцна.
- Даалгавар гүйцэтгэгч даалгавраас татгалзах эрхтэй бөгөөд уг эрхийг хязгаарласан гэрээ хүчин төгөлдөр бус байна.
 - тийм
 - үгүй



с. гэрээнд өөрөөр заагаагүй бол дээрх гэрээ хүчин төгөлдөр бус байна.

5. Даалгаврын гэрээ нь,

- а. бичгээр байгуулна, энэ шаардлагыг хангаагүй бол хүчин төгөлдөр бус болно,*
- б. энгийн бичгийн хэлбэртэй гэрээ,*
- с. наториатаар гэрчлүүлбэл зохих гэрээ,*
- д. бусад. Яагаад гэвэл.....*



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 399-405 р тал
- Иргэний эрх зүй. Үүргийн тусгай төрөл. Т.Мөнхжаргал. 97-102 р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 143-144 р тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 80-82 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 568-574 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под.ред Платонова.Д.И 116-117 р тал

8. Илгээмжийн гэрээ

Сэдвийн зорилго: Гэрээний үүргийн тусгай төрлүүд болох илгээмжийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг танин мэдэж, туслалцаа үзүүлэхтэй холбоотой бусад гэрээний үүрэг болон төсөөтэй гэрээнээс ялгаж зүйлчлэх, тухайн төрлийн гэрээг байгуулах, тэдгээртэй холбоотой маргаан шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх чадвар эзэмшиж, асуудалд хууль зүйн үүднээс хандах хандлага төлөвшинө.



Нэр томъёоны тайлбар


Илгээмжийн үйл ажиллагаа - ачаа болон илгээмжийг захиалагчийн зардлаар тээвэрлэхтэй холбоотой цогц үйл ажиллагаа

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 2

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Энэ гэрээнд нэг талаас илгээгч, нөгөө талаас захиалагч тал оролцоно. Илгээгч өөрийн нэрийн өмнөөс, гэхдээ захиалагчийн зардлаар ачаа, илгээмжийг тээвэрлэхтэй холбоотой үйлдэл хийж, захиалагч гэрээнд заасан хөлсийг төлөх үүргийг харилцан тохиролцсон гэрээг илгээмжийн гэрээ гэнэ.



Гэрээний онцлог

- Гэрээ хэлбэрийн хувьд энгийн бичгийн хэлбэртэй гэрээ
- Илгээмжийн гэрээнд даалгаврын гэрээний журам үйлчилдэг ч илгээгч нь даалгаврын гэрээнээс онцлог дараах эрх, үүрэгтэй байдаг. Үүнд: илгээгч нь, илгээмжийн гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангахуйд байдлаар ачаа, илгээмжийг тээвэрлэх, тээвэрлэлтэд оролцох этгээдийг сонгох, захиалага ашиг сонирхлын дагуу түүний өгсөн даалгаврыг гүйцэтгэх, захиалагч хүсвэл илгээгч илгээмжийг даатгуулах үүрэгтэй байна
- Гэрээнд илгээмж хүлээн авагч тал тодорхой эрх, үүрэгтэй оролцдог. Тухайлбал, талуудын оролцоотойгоор илгээмжийг шалгах боломжгүй бол илгээмжийг хүлээн авагч нь ачаанд учирсан гэм хорыг олж тогтоон илгээмжийг хүлээлгэн өгөгчид мэдэгдсэнээс бусад тохиолдолд илгээмжийг бүрэн бүтэн, аливаа гэмтэлгүй болохыг хүлээн зөвшөөрч, хүлээж авсанд тооцно. Хэрэв илгээмж илт дутагдсан, эсхүл гэмтсэн байвал илгээмж хүлээн авагч энэ тухай илгээмжийг хүлээн авсан өдөрт нь багтааж илгээгчид мэдээлнэ
- Захиалагчийн хувьд, илгээмжийн талаархи болон бусад шаардлагатай мэдээлэл, түүний тээвэрлэлттэй холбоотой баримт бичгийг бүрдүүлж илгээгчид өгөх дээрх мэдээллийн үнэн зөвийг нотлох баримтыг илгээгчид шилжүүлж өгөх үүрэгтэй. Түүнчлэн захиалагч тээвэрлүүлэхээр шилжүүлсэн илгээмжийн онцлог шинж чанар, учруулж болзошгүй аюул, аюулгүй ажиллагааны талаар илгээгчид мэдээлэх, илгээмжийг тээвэрлэлтийн шаардлагад нийцүүлэн баглах үүрэгтэй



ЖИШЭЭ НЬ

Солонгосоос "Хөх Монгол" илгээмжийн төвөөр дамжуулан явуулсан илгээмжийг хүлээн авах, Монгол шуудан компаниар дамжуулан хөдөө орон нутагт захидал, илгээмж илгээх г.м. Анхаарах зүйл нь нэг удаагийн шинжтэй, хуулийн этгээд бус хувь этгээдээр дамжуулан явуулсан мөнгө, эд хөрөнгийн хувьд энэ нь илгээмжийн гэрээ биш бөгөөд даалгаврын гэрээ болно



Дасгал

1. Урнаа АНУ-аас 1500\$, бэлэг сэлтийг гэр бүлийнхэндээ нутгийн танил Сайхнаагаар дамжуулан явуулсан байна. Ингэхдээ 20\$-ыг хөлсөнд нь өгсөн бөгөөд ачааны мөнгө гэж 10\$ нэмж авсан байна. Гэтэл хүргэж өгөх явцдаа бэлэг сэлтээс нэлээдийг дутаасан болохыг хожим мэдсэн байна. Урнаагийн ээж нь хохирол гэж үзэн 200\$ нэхэмжилсэн байна.
 - Маргааныг зүйлчилнэ үү?
 - Маргааныг шийдвэрлэх хуулийн үндэслэлийг тодорхойлно уу?
2. Илгээмжийн гэрээгтээвэрлэлтийн болондаалгаврын гэрээнээс ялгахын учир холбогдол сэдвээр эсээ бичнэ үү?
3. Иргэний хуулийн 407-409 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох илгээгч, захиалагчийн эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

1. Илгээмжийн гэрээ нь,
 - a. бодит гэрээ
учир нь
 - b. урьдчилан тохиролцсон гэрээ
учир нь
2. Илгээмжийн гэрээний талууд нь,
 - a. илгээгч, илгээмж хүлээн авагч тал,
 - b. илгээгч, захиалагч тал,
 - c. илгээгч, захиалагч, илгээмж хүлээн авагч,
 - d. илгээгч, захиалагч, илгээмж хүлээн авагч, тээвэрлэгч, тээвэрлүүлэгч талууд

3. Илгээмжийн үйлчилгээ гэдэг нь,

- a. илгээтэжийг тээвэрлэх үйлчилгээ,
- b. илгээмжийг хүргэхээр тээвэрлэгчтэй тохиролцох үйлчилгээ,
- c. илгээмжийг хүргэхтэй холбоотой цогц үйлчилгээ /тээвэрлэлт, даатгал г.м/
- d. аль нь ч биш. Яагаад гэвэл



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг. 407-409 р зүйл
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 72-74 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу

9. Хадгалалтын гэрээ, барааны агуулахад эд хөрөнгө хадгалах гэрээ

Сэдвийн зорилго: Гэрээний үүргийн тусгай төрлүүд болох хадгалалтын гэрээ, барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээний эрх зүйн зохицуулалтыг танин мэдэж, уг гэрээнүүдийг гэрээний үүргийн бусад төрөл, төсөөтэй гэрээнээс ялгаж зүйлчлэх, тухайн төрлийн гэрээг байгуулах, тэдгээртэй холбоотой маргааныг шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх чадвар эзэмшиж, хууль зүйн үнэлэлт өгөх хандлага төлөвшинө.



Нэр томъёоны тайлбар

Хадгалалт - хөдлөх хөрөнгийг эзэмшлдээ байлган, бүрэн бүтэн байдлыг ханган хадгалах үйлдэл

Агуулахад хадгалах - хөрөнгө хадгалах зориулалт бүхий, тусгайлан тоноглогсон байранд хадгалах үйлдэл /зоорь, агуулах г.м/

Агуулахын баримт- Агуулахад хадгалуулсан хөрөнгийг эзэмших эрх бүхий, эзэмших эрхийг шилжүүлсэнийг нотлох, тодорхой агуулга бүхий бичиг

Хадгалалтын онцгой гэрээ - төрлийн шинжээр тодорхойлогдох хөрөнгийг чанар, тоо ёсоор нь буцаан авах нөхцөлтэйгээр хадгалагчийн өмчлөлд шилжүүлэн хадгалуулж буй гэрээ



Гэрээнд нэг талаас хадгалагч, нөгөө талаас хадгалуулагч талууд оролцоно. Хадгалагч нь хадгалуулагчаас шилжүүлэн өгсөн хөдлөх эд хөрөнгийг хадгалах, хадгалуулагч нь гэрээнд заасан бол хөлс, хадгалалтын зардал төлөх үүргийг хүлээхээр харилцан тохиролцсон гэрээг хадгалалтын гэрээ гэнэ.

хоёр талын үүрэг, бодит болон урьдчилан тохиролцсон, хариу төлбөртэй болон төлбөргүй гэрээ

Гэрээний онцлог

- Хадгалалтын гэрээ нь онцлог төрлүүдтэй. Тухайлбал, барааны агуулахад эд хөрөнгө хадгалах гэрээ, зочид буудал, түүнтэй адилтгах үйлчилгээ эрхлэх байгууллагад /амралт, сувиллын газар, эмнэлэгт г.м/ эд хөрөнгө хадгалах гэрээ, хадгалалтын онцгой гэрээ /төрлийн шинжтэй эд хөрөнгө хадгалуулж байгаа бол зээлийн гэрээний журам үйлчилнэ/. Мөн гэрээний зүйлээс хамааран нэрлэсэн хадгалалт, орлосон хадгалалт гэж ангилах нь бий
- Хадгалагчийн хувьд, төлбөргүйгээр хадгалж буй эд хөрөнгийг өөрийн эд хөрөнгийн адил нөхцөлөөр хадгалах, хадгалж байгаа эд хөрөнгийг хадгалуулагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх зэрэг онцлог үүрэг хүлээдэг. Эдгээр үүргийг цаашид дэлгэрүүлэн судлаж тохиолдол дээр ажиллаарай /Иргэний хуулийн 422.3/
- Хадгалуулагчийн хувьд, гэрээг тодорхой хугацаатай байгуулсан эсэхээс үл хамааран хадгалуулагч хадгалуулсан эд хөрөнгөө хэдийд ч буцаан авахаар шаардах эрхтэй байхаас гадна хадгалагчид эд хөрөнгө хадгалсны зайлшгүй зардлыг төлөх, хадгалалт төлбөртэй бол хадгалалтын гэрээ дуусгавар болсон тохиолдолд хадгалагчид хөлсийг төлөх, тухайн эд хөрөнгийн аюултай шинж чанарыг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байснаас бусад тохиолдолд хадгалуулж байгаа эд хөрөнгөөс үүссэн хохирлыг хадгалагчид нөхөн төлөх, талууд өөрөөр тохиролцоогүй бол хадгалж байгаа эд хөрөнгийг гэрээнд заасан газар буцаан шилжүүлэх бөгөөд тээвэрлэлтээс гарах зардлыг хадгалуулагч хариуцах, эд хөрөнгийг хадгалалтад шилжүүлэх үед мэдэж байсан буюу мэдэх боломжтой байсан чанарын дутагдлын талаар хадгалуулагч нь хадгалагчид мэдэгдээгүй, эсхүл энэхүү дутагдлын талаар хадгалагч, хадгалуулагчийн хэн аль нь мэдээгүй буюу мэдэх боломжгүй байснаас шалтгаалан хадгалагчид учирсан хохирлыг хадгалуулагч төлөх үүрэгтэй байхаар заасан байна. / Иргэний хуулийн 422,4/

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 2

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

- Хадгалалтын зүйлээрээ онцлог. Учир нь зөвхөн хөдлөх хөрөнгө хадгалуулахаар шилжүүлдэг
- Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулж байгаа тохиолдолд гол онцлог нь хадгалалтын нийтлэг журмыг баримтлах хэдий ч агуулахын баримт олгон, түүгээр хадгалуулагчийн эрхийн байдлыг тодорхойлдог явдал юм
- Зочид буудал, амралт, сувиллын газар, түүнтэй адилтгах үйлчилгээ эрхэлж буй этгээдүүдийн хувьд гэрээнд заасан нөхцлийн дагуу буюу тусгай журмаар хүлээлгэн өгөх зүйлийг нарийн тодорхойлж, өөрсдийн хүлээх эрсдлийг хязгаарлах боломжтой юм /Иргэний хуулийн 427 зүйл/
- Зарим төрлийн гэрээний хувьд хадгалалтын гэрээний журам давхар үйлчлэн, гэрээний харилцааг зохицуулах нь бий. Тухайлбал, эзэмшл, ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой гэрээний хувьд хадгалалтын үүрэг гэрээний хугацаанд үргэлжилсээр байдаг бол худалдах, худалдан авах гэрээгээр худалдан авагч бараагаа аваагүй тохиолдолд хадгалах үүрэг үүсэх гэх мэт нөхцлийг гэрээний маргаан шийдвэрлэх үед анхаарч байх нь чухал

ЖИШЭЭ НЬ

Эрх бүхий байгууллагад бус иргэнд мөнгө хадгалуулсан бол хадгалалтын онцгой гэрээ гэж үзэн зээлийн гэрээний журам баримтална, гражид автомашин хадгалуулах, агуулах, зориулалтын зооринд төмс, ногоо, мах хадгалуулах, өлгүүрт хувцсаа өлгүүлэх г.м



Дасгал

1. Иргэн Туяа "Өргөө" сувиллын газарт сувилуулахдаа өрөөгөө түгжээгүйн улмаас цүнхээ алдсан байна. Сувиллын газрын жижүүрт мэдэгдэхэд бид хариуцахгүй гэсэн байна. Хоёр хоногийн дараа өөрийнх нь цүнхтэй яг ижил цүнхийг нэгэн амрагч барьж явсан байна. Туяа тэр даруй цүнхийг очиж үзтэл өөрийнх нь мөн байсан учраас булаан авч, цагдаад мэдэгдсэн байна. Гэтэл уг цүнхийг хоёр хоногийн өмнө үл таних хүнээс 20.000 төгрөгөөр худалдаж авсан тухай хэлжээ.
 - Сувиллын газрын хариуцлагыг тодорхойлно уу?
 - Хохирлыг барагдуулах хуулийн үндэслэл?
2. "Молор" ХХК-ийн агуулахад иргэн Далай болон "Тайван" компаниуд үрийн төмс хадгалуулахаар гэрээ байгуулжээ. Хадгалах хугацаанд Далайн хадгалуулсан үрийн төмс гэмтэлтэй байснаас "Тайван"



компанийн хадгалуулсан үрийн төмсөнд гэмтэл учруулжээ. "Тайван" ХХК уг төмсийг хадгалж байгаа агуулахын баримтаа барьцаалан 5 сая төгрөг зээлсэн байна. Хугацаанд нь төлөөгүйн улмаас зээлдэгч барьцааны зүйл болох төмсийг борлуулж шаардлагаа хангуулах гэтэл уг төмс нь муудсан байжээ. Шаардлага гаргатай "Тайван" ХХК манайх буруугүй бөгөөд "Молор" ХХК хариуцах ёстой гэжээ.

- Барааны агуулахад хөрөнгө хадгалах гэрээ мөн үү? Яагаад
- Маргааныг шийдвэрлэх хууль зүйн үндэслэл?

3. Иргэний хуулийн 422-427 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох хадгалагч, хадгалуулагчийн эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

1. Үзвэрийн газарт хувцсаа өлгүүлсэн иргэн Болд өлгүүрийн пайзаа гээсэн бөгөөд энэ тухайгаа өлгүүрчинд хэлжээ. Гэтэл өлгүүрчин таны хувцасны пайзыг хэн нэгэн авчирч өгөн хувцсыг авсан болохыг хэлж, пайзыг үзүүлжээ. Болд би хувцсаа аваагүй, миний хувцас 250.000 төгрөгийн үнэтэй, тэгээд ч танай дотоод журамд зааснаар өлгүүрчин хувцас алдвал 2 нугалж төлүүлнэ гэснийг нь хэлсэн байна. Өлгүүрчин, бид заавал өөрт нь хүлээлгэж өгөх үүрэг хүлээдэггүй, нэгэнт авсан л бол авсан, би хариуцлага хүлээхгүй гэжээ.
 - a. өлгүүрчин хариуцлага хүлээн төлбөрийг бүрэн төлнө,
 - b. эрсдлийг Болд өөрөө хүлээнэ,
 - c. харилцан тохиролцож хамтран хариуцаж болно,
 - d. ямар нэгэн гэрээний харилцаа үүсээгүй...

яагаад гэвэл
2. Томилолтоор гадагшаа явахдаа Наран найз Өнөрөөдөө орон сууцаа үлдээн харж хандаж байхыг хүссэн байна. Энэ тохиолдолд,
 - a. хадгалалтын гэрээний журмаар үүрэг хүлээнэ,
 - b. орон сууц хөлслөгчийн журмаар үүрэг хүлээнэ,
 - c. эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглагчийн үүргийг хүлээнэ,
 - d. даалгаврын гэрээний журмаар үүрэг үүснэ,
 - e. ямар нэгэн гэрээний үүрэг үүсэхгүй,

яагаад гэвэл
3. Төрлийн шинжээр тодорхойлогдох хөрөнгийг хадгалагчийн өмчлөлд шилжүүлэн хадгалуулж буй гэрээг,
 - a. хадгалалтын гэрээ гэнэ,
 - b. хадгалалтын онцгой гэрээ гэнэ,
 - c. зээлийн гэрээ гэнэ,
 - d. бусад буюу
4. Агуулахад хадгалуулсан хөрөнгийг эзэмших эрхийн болон эзэмших эрхийг шилжүүлсэнийг нотлох баримтыг,

- a. агуулахын баримт,
- b. хадгалалтын гэрээ,
- c. эзэмших эрхийн гэрчилгээ,

5. Хадгалалтын гэрээнд хамаарахгүй нөхцөл,
- a. амралтын газарт тээш үлдээх,
 - b. эмнэлэгт гар утсаа үлдээх,
 - c. банкинд мөнгө, үнэт зүйлс хадгалуулах,
 - d. гражид машинаа тавих,



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 422-427 р зүйл
- Иргэний эрх зүй. Үүргийн тусгай төрөл. Т.Мөнхжаргал. 105-109 р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 149-150 р тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, ДЦолмон. /2002 он/ 80-82 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 480495 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под.ред Платонова. Д.И 100-107 р тал

10. Даатгалын гэрээ

Сэдвийн зорилго: Даатгалын гэрээний эрх зүйн зохицуулалтыг танин мэдэж, энэ үндсэн дээр бусад төсөөтэй гэрээнээс ялгаж зүйлчлэх, даатгалын гэрээг байгуулах, уг гэрээний маргааныг шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх чадвар эзэмшин, даатгалын гэрээний ач холбогдлыг үнэлж, хууль зүйн үүднээс хандах хандаага төлөвшинө.



Нэр томъёоны тайлбар

Даатгалын нөхөн төлбөр - даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн дүн

Даатгалын хураамж - даатгуулагчаас өөрийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн бус ашиг сонирхлоо даатгуулсны төлөө даатгагчид төлөх мөнгөн дүн



Даатгалын хугацаа - даатгалын гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа бөгөөд энэ хугацааг сайн дурын даатгалын гэрээнд харилцан тохиролцож, заавал даатгах даатгалын хувьд хуулиар тогтоосон хугацаа

Даатгалын үнэлгээ - даатгуулж байгаа эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашиг сонирхлын мөнгөн илэрхийллийн хэмжээ. Даатгалын үнэлгээг ийнхүү тогтоож байгаа нь даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг зөв, бодитой тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Уг хэмжээ нь сайн дурын даатгалын гэрээнд даатгагч, даатгуулагчийн тохиролцож тогтоосон мөнгөн илэрхийлэл бөгөөд заавал даатгах даатгалын гэрээнд хууль болон тусгай журам, нөхцлөөр тогтоосон үнэлгээ юм

Даатгалын тохиолдол - даатгуулсан зүйлд учирсан эрсдэл, тохиролцсон болзол бүрдэхийг ойлгоно. Энэ нь хуульд заасан болон гэрээгээр тохиролцсон нөхцөл байдал бөгөөд даатгалын тохиолдол нь даатгагчаас хүлээсэн үүргээ гүйцэтгэх үндэслэл болж өгдөг

Даатгалын эрсдэл - даатгалд хамрагдсан зүйлсэд хохирол учруулж болох нөхцал, орчин. Энэ нөхцэл, орчин гэдэгт даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд, даатгуулсан эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгөнд хохирол учруулахуйц аюултай нөхцөл байдал хамаарах бөгөөд энэ нь үйлдэл /хууль зүйн дагуух бус гуравдагч этгээдээс хамааралтай/, үйл явдлаар /аадар бороо, мөндөр, шуурга, газар хөдлөлт, нуралт гэх мэт/ илэрч болно

Нэг тал болох даатгагч нь даатгалын тохиолдол бий болоход нөгөө тал болох даатгуулагчид учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгачын хураамж төлөх үүргийг харилцан хүлээж байгаа гэрээг даатгалын гэрээ гэнэ.

Анх дундад зууны үед газрын дундад тэнгис орчмын далайчид гэнэтийн осол, сүйрлээс өөрсдийгөө болон эд хөрөнгөө хамгаалах, тодорхой нөхцөлд учирсан хохирлоо нөхөх зорилгоор дундын сан байгуулж хэрэгжүүлэх болсноор анх үүссэн гэж үздэг. Юутай ч даатгал нь эртний Ромд хэрэглэгдэж байсан бөгөөд эртний Грект, Александр Македонскийн үед "... хувь нийлүүлсэн даатгалын нийгэмлэг"-ийг байгуулж байсан байна.

ГЭРЭЭНИЙ ШИНЖ:



Хоёр талын, хариу төлбөртэй, гэрээний талуудад ашигтай болон гуравдагч этгээдэд ашигтай /зарим төрөл нь/, урьдчилан тохиролцсон, хугацаатай гэрээ

Гэрээний агуулга, онцлогоос харахад энэ гэрээ нь өөр аль нэг төрлийн гэрээтэй төсөөлөн харьцуулах боломж харьцангуй бага, өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой



ЗҮЙЛЧЛЭЛИЙН ХУВЬД

Гэрээний онцлог

- Даатгалын гэрээний зүйл нь эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхол байна
- Даатгалын гэрээг хэлбэрийн хувьд бичгээр хийх Бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байдаг
- "Энэ гэрээ нь онцлог хэд хэдэн төрөлтэй байдаг. Үүнд: даатгалын гэрээг объектоор нь шалгуур болгон эд хөрөнгийн даатгал, амин хувийн даатгал, хууль зүйн фактын онцлогоор нь сайн дурын, заавал даатгах даатгал, хамтран даатгал /нэг буюу нэг хэсэг даатгалын зүйлийг хэд хэдэн этгээд нэгэн зэрэг даатгахыг ойлгоно/, давхар даатгал /даатгагч даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ гэрээний үндсэн дээр өөр даатгагчид даатгуулах/
 - нийгмийн даатгал, гэм хорын даатгал /даатгагч нь даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эд хөрөнгийн бус ашиг сонирхолд учирсан гэм хорыг даатгалын үнэлгээний хэмжээгээр мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх үүрэг бүхий байдаг/, хариуцлагын даатгал /хариуцлагын даатгалаар даатгагч нь даатгалын хугацаанд үүсэх хариуцлагатай холбоотойгоор гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүргээс даатгуулагчийг чөлөөлөх үүрэг бүхий даатгал/ гэсэн төрлүүдтэй байна
- Даатгалын гэрэний нөхцөлүүд нь онцлог. Даатгалын гэрээнд заавал тусгах нөхцөлүүд бий. Энэ нь даатгалын гэрээний агуулгыг тодорхойлох нөхцөл, байдлууд юм



ЖИШЭЭ НЬ



Эрүүл мэндийн даатгал, амь насны даатгал, эд хөрөнгийн даатгал, дуучид хоолойгоо буюу эд эрхтнээ даатгуулах, нэр төрөө даатгуулах г.м

- Даатгалын үнэлгээний хэмжээг талууд харилцан тохиролцож тодорхойлно. Эд хөрөнгийг даатгах, тохиолдолд даатгагч эд хөрөнгийг үзэж үнэлгээний хэмжээг тогтоох эрхтэй. Эд хөрөнгийн даатгалын үнэлгээний хэмжээ түүний өртгөөс илүүгүй байна. Даатгалын гэрээнд заасан бол даатгалын тохиолдол бий болсны улмаас олж чадаагүй ашиг, орлогыг даатгалын үнэлгээний хэмжээнд хамааруулж болно
- Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байхад даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээнд заасан үүрэг хүлээхгүй
- Даатгуулагчийн хувьд, даатгагч даатгуулагчид даатгалын баталгаа олгосон бол даатгуулагч ашиг сонирхол бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр гэрээ ёсоор эдлэх аливаа эрхийг эдлэх, гэрээнд зааснаар шагнал авах, эсхүл ашиг сонирхол бүхий этгээд даатгалын баталгаа авсан нөхцөлд түүнд эрхийг нь пшлжүүлэх, даатгагчийн төлбөрийн чадвар үлэмж доройтож, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахааргүй нөхцөл бий болсон бол даатгуулагч даатгалын хураамж төлөхөөс татгалзах эрхтэй
- Амь нас, эрүүл мэндээ даатгуулсан этгээд санаатайгаар амь нас, эрүүл мэндээ хохироосон бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх онцлогтой



Дасгал

1. Иргэн Дорж нэгэн даатгалын компанитай даатгалын гэрээ байгуулж, өөрийн нэр төрөө даатгуулахыг хүссэн байна. Даатгалын компани нь хүний нэр төрийг даатгуулахгүй, учир нь үнэлгээ хийх боломжгүй юм гэсэн шалтгаанаар гэрээ байгуулахаас татгалзжээ. Хуулиар олгогдсон эрх зөрчсөн үндэслэлээр Дорж шүүхэд ханджээ.
 - Даатгалын компани ийнхүү татгалзах эрх бий юу?
 - Даатгалын гэрээний зүйлийг тодорхойлон ярилцаж, дүгнэлт хийнэ үү?
2. Иргэний хуулийн 431-444 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болон даатгагч, даатгуулагчийн эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

1. Даатгалын гэрээ нь,
a. урьдчилан тохиролцсон гэрээ юм
яагаад гэвэл
b. бодит гэрээ юм
яагаад гэвэл
2. Даатгагч даатгалын зүйлийг гэрээний үндсэн дээр өөр даатгагчид даатгасан даатгалыг,
a. хамтран даатгал, b. гэм хорын даатгал
c. хариуцлагын даатгал, d. давхар даатгал
3. Даатгалын гэрээний зүйл нь,
a. амь нас d. эдийн бус ашиг сонирхол
b. эд хөрөнгө, e. эрүүл мэнд
c. аль аль нь хатаарна.
4. Даатгалд хамрагдсан зүйлсэд хохирол учруулж болох нөхцөл, орчинг,
a. даатгалын эрсдэл гэнэ,
b. даатгалын тохиолдол гэнэ,
c. даатгалын зүйл гэнэ,
d. бусад. Тухайлбал
5. Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байхад даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээнд заасан үүрэг хүлээхгүй
a. тийм б. үгүй
яагаад гэвэл



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 431-444 р зүйл
- Иргэний эрх зүй. Үүргийн тусгай төрөл. Т.Мөнхжаргал. 123-127 р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 152-153 р тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 80-82 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 509-566 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под.ред. Платонова.Д.И 108-110 р тал



11. Хамтран ажиллах гэрээ

Сэдвийн зорилго: Хамтран ажиллах гэрээний эрх зүйн зохицуулалтыг танин мэдсэнээр уг гэрээг байгуулах, тухайн гэрээтэй холбоотой маргаан шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх чадвар эзэмшинэ.



Нэр томъёоны тайлбар

Бүртгэгдээгүй холбоо - нэгдмэл тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр ашгийн бус зорилгоор нэгдэж байгуулсан улсын бүртгэлд бүртгэгдээгүй байгууллага

Бүртгэгдээгүй нөхөрлөл - гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хариуцдаг улсын бүртгэлд бүртгэгдээгүй байгууллага

Хоёр буюу түүнээс дээш этгээд хуулийн этгээд байгуулахгүйгээр ашиг олох болон бусад тодорхой зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хамтран ажиллах үүрэг хүлээнэ

Амаар болон
бичгээр байгуулж
болно

Хамтран
ажиллах гэрээ
нь урьдчилан
тохиролцсон, хоёр
буюу олон талын,
хариу төлбөртэй
гэрээ

Тодорхой
хугацаатай буюу
тодорхой бус
хугацаатай байгуулж
болно. Гэрээнд
хугацаа заагаагүй
бол тодорхой бус
хугацаатай гэж үзнэ

Гэрээний онцлог

- Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр байгуулагдах ашгийн бус нэгдлийг холбоо, ашгийн төлөө нэгдлийг нөхөрлөл гэж нэрлэхээр хуульд заажээ.
- Хамтран ажиллах гэрээний үр дүнд бие даасан хуулийн этгээд байгуулагддаггүйгээрээ онцлогтой боловч хуулийн этгээдийн нэгдэл үүсэж болно
- 2002 оны Иргэний хуулийн 481-ийн 1 дэх хэсэгт "Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд холбоо ба нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ийм байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхгүй ба бүтэц, зохион байгуулалтыг гишүүд харилцан тохиролцож байгуулна" гэж заасан

- Иргэний эрх зүй дэх уламжлалт үүргийн харилцаа нь үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч гэсэн хоёр талын харилцан бие биерүүгээ хандсан /худалдагч худалдан авагч, зээлдэгч зээлдүүлэгч, гэх мэт/ ашиг сонирхлоос үүсдэг бол хамтран ажиллах гэрээнээс үүсэх үүрэг нь гэрээнд оролцогч талуудын нэгдмэл ашиг сонирхлоос үүсдэгээрээ бусад гэрээнээс онцлогтой
- Нэгдмэл зорилгыг хангахын тулд байгуулагддаг хамтран ажиллах гэрээнд оролцогч бие даасан эрх, үүрэг бүхий талуудын тоонд хязгаарлалт тавьдаггүйгээрээ онцлогтой. Ийм учраас хамтран ажиллах гэрээ нь хоёр буюу олон талын байж болдог. Үүгээрээ хоёр талын гэрээнээс ялгагдана
- Хамтран ажиллах гэрээ нь хариу төлбөртэй гэрээ гэж зарим хуульчид үздэг. Гэрээнд оролцогчдын аль нь ч гэрээнд оролцогч нөгөө этгээдийнхээ ашиг сонирхлын төлөө үйлдэл хийх үүрэг хүлээдэггүй. Учир нь хамтран ажиллах гэрээ гэдэг бол нэгдмэл нэг ашиг сонирхлын төлөө ажил үйлчилгээ, хөрөнгөө нэгтгэсэн хэд хэдэн этгээдийн нэгдлийг үүсгэдэг хэлцэл юм. Гэвч талууд нэгдмэл ашиг сонирхлоо хангахын тулд гэрээнд заасан үйл ажиллагаагаа эрхлэхээр тодорхой хөрөнгө нэгтгэх үүрэг хүлээдэг. Хамтран ажиллах гэрээний талуудын гэрээ байгуулах болсон үндэслэл нь бусад талууд тэрхүү гэрээнд оролцож буй явдал бол нэгдмэл зорилгоо биелүүлэхээр тодорхой үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрч буй шалтгаан нь бусад оролцогчид түүнтэй төсөөтэй үүрэг хүлээсэн явдал байдаг. Энэ нь хамтран ажиллах гэрээг хариу төлбөртэй гэрээ гэж үзэх үндэслэл болдог
- *Гишүүдийн үүрэг.* Хамтран ажиллах гэрээнд оролцогчдын үндсэн хоёр үүрэг байдаг. Үүнд: а. Гэрээнд заасан зорилгоо биелүүлэхийн тулд хөрөнгө нийлүүлэх, б. Бусад оролцогчидтой хамтран гэрээнд заасан үйл ажиллагаа эрхлэхгэсэн үндсэн үүргүүд хамаарна
- Хамтран ажиллах гэрээний талуудын хүлээх хариуцлагыг үндсэнд нь тухайн гэрээний зорилго, оролцогчдын хүлээх эрх үүргээс нь хамаарч хэсгээр хүлээх ба хамтаар хүлээх хариуцлага гэж 2 төрөлд ангилна



Дасгал

1. "Тэгш" ХХК нь "Тэг" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан тоосгоны үйлдвэр байгуулсан бөгөөд өдөр тутмын үйл ажиллагааг "Тэг" компани эрхлэн явуулдаг "Тэгш" компани хувьд итгэмжлэгдсэн төлөөлөгчөө ажиллуулдаг. Хөрөнгө оруулалт 50:50 хувиар хийгдсэн бөгөөд саналын эрхийн хувьд "Тэгш" компани 51 хувийг эзэмшихээр тохиролцон үйл ажиллагаагаа явуулж байсан. Гэтэл тус үйлдвэрт ажиллаж байсан иргэн Х ажлын байран дээр үйлдвэрлэлийн ослоор гэмтэл авсан. Х нь бичгээр ямар нэгэн гэрээ байгуулаагүй байсан.
 - Х-д учирсан хохирлыг хэн төлөх вэ?



- "Тэгш" болон "Тэг" компаний хооронд байгуулсан гэрээнд хууль зүйн тайлбар хийж санал солилцоно уу?

2. Өгөгдсөн гэрээн дээр ажиллан анализ хийж, боловсронгуй болгоно уу?

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот

2005 оны ... сарын ... өдөр

Дугаар №

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Нэг талаас "Тэг" ХХК-г төлөөлж овогтой нөгөө талаас "Тэгш" ХХК-г төлөөлж овогтой нар харилцан тохиролцсоны үндсэн дээр Иргэний хуулийн 476-р зүйлийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээний зорилго нь хуулийн этгээд байгуулахгүйгээр тоосгоны үйлдвэрт хамтран ажиллаж ашиг олоход оршино.
- 1.3 Хамтран ажиллагч талууд нь тавь, тавин хувийн хөрөнгө оруулан уг үйлдвэрийг байгуулах бөгөөд уг хөрөнгөөс бий болох ашиг орлого, үр шим, түүнийг нэгтгэсэн, нийлүүлсэн, татан буулгаснаас бий болох хөрөнгийг талуудын оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувь тэнцүүлэн хуваана.
- 1.4 Талуудын дундын өмчлөлийн зүйлсийг Хавсралт 1-д тусгах бөгөөд хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.5 Талуудын аль нэг нь өөрт ноогдох хувиа нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
- 1.6 "Тэгш" ХХК нь тоосгоны үйлдвэрлэлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах бөгөөд аливаа хэлцэл, пшидюр гаргахдаа харилцан зөвшөөрлийг авна.

Хоёр. "Тэг" ХХК-ны эрх, үүрэг

- 2.1 Тус үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах.
- 2.2 Үйлдвэрийн ажилтан, мэргэжлийн боловсон хүчнийг сонгон шалгаруулж ажиллуулах, сургах.
- 2.3 Үйлдвэрлэлийн менежмент, маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх
- 2.4 Хамтран ажиллах гэрээнээс гарах эрхтэй.
- 2.5 Бүх шатны шийдвэр гаргалтанд хамтран ажиллагч талыг оролцуулах
- 2.6 Улирал тутмын санхүүгийн тайлан балансыг гаргаж хамтран ажиллагч талд тайлагнаж ашиг, алдагдлыг хувиарлаж байх.
- 2.7 Хамтран ажиллах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар санал оруулах.

Гурав. "Тэгш" ХХК-ны эрх, үүрэг

- 3.1 Тус үйлдвэрийн үйл ажиллагаатай холбоотой бүх шатны шийдвэр гаргалтанд оролцох.
- 3.2 Санхүүгийн тайлан баланстай танилцан, ноогдох хувь хүртэх

- 3.3 Байгууллагын бусадтай гэрээ хэлцэл байгуулахад оролцох, санал гаргах.
- 3.4 Хөрөнгийн эргэлт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих.
- 3.5 Хамтран ажиллах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар санал оруулах эрхтэй.
- 3.6 Үйлдвэрлэлийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцон туслах үүрэгтэй.

Дөрөв. Бусад

- 4.1 Хамтран ажиллах гэрээнээс талууд хэдийд ч гарах эрхтэй бөгөөд хөрөнгийн 50%-г авах эрхтэй.
- 4.2 Талууд маргаан гарвал асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс чадвал Монгол Улсын арбитраар шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулагч талууд:

"Тэг" ХХК-нийг
төлөөлж

----- овогтой

Гарын үсэг
Харилцах утас
Тамга

"Тэгш" ХХК-нийг
төлөөлж

----- овогтой

Гарын үсэг
Харилцах утас
Тамга

- 3. Иргэний хуулийн 476-482 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж хамтран ажиллагч талуудын эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

- 1. Хамтран ажиллах гэрээ нь
 - a. хоёр талын гэрээ
 - b. нэг талын гэрээ
 - c. олон талын гэрээ
 - d. хоёр ба олон талын гэрээ
- 2. Хамтран ажиллах гэрээ нь хэлбэрийн хувьд:
 - a. амаар байгуулна
 - b. бичгээр байгуулна
 - c. заавал бичгээр байгуулна
 - d. амаар болон бичгээр байгуулна
- 3. Намтран ажиллах гэрээ байгуулж А талын лицензээр, Б тал эд хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж шинжилгээний лаборатори ажиллуулжээ. Ашиг, алдагдал хуваах талаар гэрээнд тодорхой заалт байхгүй байжээ. Ашгаа хуваах асуудал дээр маргаан гарч шүүхэд хандсан байна. Шүүх



яаж шийдвэрлэх вэ?

- a. хоёр талд тэнцүү ашиг хуваарилна*
- b. талуудын төлсөн хураамжинд хувь тэнцүүлэн хуваарилна*
- c. А талд 60 хувь, Б талд 40 хувийг хуваарилна*
- d. Б талд 60 хувь, А талд 40 хувийг хуваарилна*

4. Хоёр компани хамтран ажиллах гэрээ байгуулж хулсан шалны үйлдвэр ажиллуулжээ. Гэрээндээ аль нэг тал нь өөрийн хүсэлтээр гэрээнээс гарахыг хориглосон байна. Энэ гэрээ нь:

- a. хүчин төгөлдөр байна*
- b. хүчин төгөлдөр бус байна*
- c. хүчин төгөлдөр бус гэж тооцож болно*
- d. хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй тул шүүх шийднэ*

5. Хамтран ажиллах гэрээнд талууд хураамжийг дараахь хэлбэрээр оруулж болно.

- a. гагцхүү эдийн хэлбэрээр*
- b. гагцхүү эдийн бус хэлбэрээр*
- c. гагцхүү үйлчлэлгээ байна*
- d. эдийн болон эдийн бус хэлбэрээр*

6. Дараахь сэдвээс аль нэгийг сонгон эссе бичнэ үү.

- хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх нь
- хамтран ажиллах гэрээ хүчин төгөлдөр бус болох нь
- хамтран ажиллах гэрээний хөрөнгө оруулалт
- хамтран ажиллах гэрээний хариуцлага



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I - III дэд хэсэг, II хэсэг 476-482 р зүйл
- Иргэний эрх зүй. Үүргийн тусгай төрөл. Т.Мөнхжаргал. 116-120 р тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 80-82 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 630-646 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под.ред Платонова.Д.И 133-135 р тал

12. Асран тэтгэх гэрээ

Сэдвийн зорилго: Асран тэтгэх гэрээний эрх зүйн зохицуулалтыг танин мэдсэнээр тухайн гэрээг байгуулах, тухайн гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх чадвар эзэмшинэ.



Нэр томъёоны тайлбар

Асран тэтгэгч - бусдыг асран тэтгэхээр үүрэг хүлээсэн эрх зүйн бүрэн чадамжтай иргэн, энэ төрлийн үйл ажиллагааг эрхэлдэг байгууллага

Тэтгүүлэгч - Эрх зүйн бүрэн чадамжтай боловч өндөр настай эсхүл эрүүл мэндийн хувьд бие даан амьдрах чадваргүй, асран тэтгүүлэх хэрэгцээ шаардлага гарсан тул асран тэтгэгчээс мөнгөн болон биет байдлаар туслалцаа авч байгаа этгээд

Асран хамгаалах - эрх зүйн бүрэн чадамжгүй болон зарим чадамжтай этгээдийг эрх, ашиг сонирхолд нийцүүлэн тэдний нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээх, тэднийг асарч тэтгэх үйл ажиллагаа

Асран тэтгэх
гэрээний хувьд

Асран тэтгэх хугацааг
түүний зорилго, шинж чанарыг
харгалзан гэрээгээр тогтооно

Асран
тэтгэх гэрээ

Хоёр талын, урьдчилан тохиролцсон, хариу
төлбөргүй болон хариу төлбөртэй гэрээ

Гэрээний зүйл нь, мөнгө болон биет
хэлбэрээр асрах үйл ажиллагаа. Биет хэлбэр
гэдэг нь орон сууц, хоол, хувцсаар хангах
зэрэг байж болно

Бичгээр байгуулах гэрээ

Асран тэтгэгч нь асруулагчийг
тэжээн тэтгэх үүрэг хүлээсэн этгээд байна



Асран тэтгэх гэрээний онцлог:

- Асран тэтгэх гэрээ нь туслалцаа үзүүлэх гэрээний үүрэгт хамаарна
- Асран тэтгэх гэрээний нэг тал буюу асран тэтгэгч нь төр байвал энэ тухайн үйл ажиллагааг дагнан эрхлэх байгууллага байна
- Асран тэтгэх ажиллагаа нь нэг талын хэлцлээр дийлэнхдээ үүсдэг. Тухайлбал: эцэг эх нь үр хүүхдээ асран хамгаалж харгалзан дэмжих, эрх бүхий этгээд харгалзан дэмжих зэрэг үйл ажиллагааг асран тэтгэх гэрээнээс ялган авч үзнэ. Асран тэтгэх гэрээ нь талуудын хүсэл зоригийн үндсэнд үүсч байгаа эрх үүргийн харилцааг зохицуулна гэдгийг анхаарах шаардлагатай



Дасгал

1. Н 16 настай. Ганцаараа амьдардаг. Өөрийн аавын дүү болох М - д өв залгамжлан авсан ХХК-аа эд хөрөнгийн хамт шилжүүлэн удирдуулах, түүний ашгаас сар бүр өөрийн хэрэглээ, зардлын мөнгө болох 300 000 төгрөгийг гаргуулж байхаар тохиров. Энд ямар гэрээ байгуулах вэ?
 - Гэрээний загварыг бичнэ үү
 - Гэрээний нөхцөлд юуг анхаарах вэ?
 - М нь Н-ийн өмнөөс хариуцлага хүлээх үү
 - М ХХК-ы хариуцлагыг хүлээх үү
2. Гэр бүлийн тухай хуульд асран хамгаалах үйл ажиллагааны талаар зохицуулсан байдаг. Асран тэтгэх гэрээ үүнтэй холбоотой эсэх талаар эссэ бичнэ үү.
3. Иргэний хуулийн 483485 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох асран тэтгэгч, асруулагчийн эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

1. Асран тэтгэх гэрээ хэдийд хүчин төгөлдөр болох вэ?
 - a. гэрээ байгуулснаар
 - b. асруулагч эд хөрөнгөө шилжүүлснээр
 - c. гэрээг гэрчлүүлснээр
 - d. асрах үйл ажиллагааны хэлбэрээс хамааран өөр өөр байдаг
2. Ажил эрхэлдэг 15 настай хүүгийн аав нь хуульд зааснаар харгалзан дэмжигчийн үүргийг гүйцэтгэдэг. Эдгээрийн хооронд үүсч байгаа харилцаа нь асран тэтгэх гэрээгээр зохицуулагдах уу?

a. тийм

b. үгүй

c. хэлцэл үүсч байгаа тул гэрээгээр үүссэн гэж үзнэ

3. Асран тэтгэгч нь асруулагчаас шилжүүлсэн хөрөнгөөр барьцаа болгон зээл авчээ. Энэ нь зөвшөөрөгдөх үйлдэл мөн үү?

a. болно. Асран тэтгэгч нь шилжүүлэн авсан тул

b. болно. Асран тэтгэгч асруулагчийн ашиг тусын тулд үйлдэл хийж байгаа бол

c. болно. Асран тэтгэгч өөрийн нэр дээр хөрөнгийг шилжүүлсэн бол



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 483-485 р зүйл
- Иргэний эрх зүй. Үүргийн тусгай төрөл. Т.Мөнхжаргал. 111-114 р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг. /1999 он/ 151 р тал
- Гэрээний эрх зүй. Ц.Амарсайхан, Д.Цолмон. /2002 он/ 80-82 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу

13. Үнэт цаасны эргэлтээс үүсэх үүрэг

Сэдвийн зорилго: Үнэт цаасны тухай ойлголт, ангилалт, төрөл, эрх зүйн зохицуулалтын талаар онолын мэдпэг олж, эдийн засгийн харилцаа тухайлбал, хөрөнгө оруулалтанд үнэт цаасны үүрэг ач холбогдолыг танин мэдэж, үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх чадвар эзэмшиж, шударга ёс, хууль ёсыг дээдлэх хандлага төлөвшинө.



Нэр томъёоны тайлбар

Хөрөнгө оруулагч - үнэт цаасыг хариу төлбөртэйгөөр худалдан авах замаар аж ахуйн харилцаанд оролцож буй этгээд

Үнэт цаасны зах зээл - үнэт цаас гаргах, бүртгүүлэх, худалдах, арилжих, хадгалах, түүгээр гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбогдсон харилцаа

Үнэт цаасны анхдагч зах зээл - үнэт цаас гаргагч үнэт цаасаа өөрөө буюу андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх компаниар дамжуулан худалдах, арилжихтай холбогдсон харилцаа



Үнэт цаасны хоёрдогч зах зээл - анхдагч зах зээлд гарсан үнэт цаасыг дахин худалдах, худалдан авах, арилжихтай холбогдсон харилцаа

Брокерийн үйл ажиллагаа - үнэт цаасны зах зээл дээр бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагаа

Дилерийн үйл ажиллагаа - үнэт цаасны зах зээл дээр ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах, арилжих ажиллагаа

Андеррайтерийн үйл ажиллагаа - үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу гаргаж буй үнэт цаасны тухай танилцуулга бэлтгэх, шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасыг бүгдийг буюу түүний тодорхой хэсгийг худалдан авах, худалдах, эсхүл үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс үнэт цаасыг нь нийтэд санал болгон арилжих ажиллагаа

Биет үнэт цаас - тогтоосон журмын дагуу биет байдлаар хэвлэсэн үнэт цаас

Биет бус үнэт цаас - тусгайлан хэвлээгүй, бүрдүүлбэр нь тооцоолох машины санах байгууламжид байгаа үнэт цаас

Үүсмэл үнэт цаас - тодорхой үнэт цаастай холбоотой гаргасан, түүнээс үнэ, ханш нь хамаарч байдаг, хувьцаа худалдах, худалдан авах эрх олгосон опцион, энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг тодорхой хугацааны дотор энгийн хувьцаанд хөрвүүлэх эрх олгодог бусад үнэт цаас

Хувьцаа - компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаас

Өрийн бичиг - тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаас

Вексель - тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацаанд төлөх тухай ямар нэг нөхцөл болзол заагаагүй үүргийг өөртөө багтаасан төлбөр тооцооны үнэт цаас

Үнэт цаас нь хөрөнгийн оршин байх хэлбэр бөгөөд онцгой төрлийн таваар юм. Үнэт цаасыг хууль зүйн болоод эдийн засаг талаас нь харьцуулан авч үзэх нь зүйтэй.

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд "Үнэт цаас гэж Засгийн газар болон Бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг, компаний бүх төрлийн хувьцаа.... опцион, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн үнэт цаасны хорооноос энэ хуульд нийцүүлэн гаргасан үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг" хэлнэ.

ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ 2

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Тодорхой эд хөрөнгийн эрхийг гэрчилж, эзэмшигч этгээдлээ эд хөрөнгийн шаардах эрхийг бий болгох чадвартай эрх бүхий байгууллагаас үнэт цаас хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн баримтыг үнэт цаас гэнэ.

Үнэт цаасны үндсэн шинж	• тодорхой эд хөрөнгийн эрхийг гэрчилнэ • төрийн эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн байна • хөрөнгө оруулалтын хэрэгсэл болно • инфляциас хамгаалах хэрэгсэл болно
Үнэт цаасны бүрдүүлбэр /бүрдүүлбэр, гарын үсэг буруу үнэт цаасыг хүчин төгөлдөр бус гэж үзнэ/	• үнэт цаасны нэр төрөл • үнэт цаас гаргагчийн оноосон нэр • үнэт цаасны нэрлэсэн үнэ • нэрийн үнэт цаасны хувьд үнэт цаас эзэмшигчийн нэр хүү төлөх нөхцөл • төлбөр хийгдэх нөхцөл • үнэт цаасны бүртгэлийн болон регистрийн дугаар • үнэт цаас гаргагчийн тамга • үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг
Үнэт цаасны өмчлөгч /үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдлэгч нь үнэт цаасны өмчлөгч байна/	• мэдүүлгийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг уг үнэт цаасыг хууль ёсоор олж авсан этгээд • нэрийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг гагцхүү түүнд нэр заасан этгээд • зөвшөөрлийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг уг үнэт цаасыг өмчлөгч буюу түүнээс уг эрхийг шилжүүлж авахаар өөрийн нэр дээр холбогдох бичилт хийсэн этгээд
Үнэт цаасны төрөл /үнэт цаасанд өөрт нь байгаа бүх шинж чанарын нийлбэр цогцыг илэрхийлэх тухайн төрлийн үнэт цаас/	• хувьцаа • өрийн бичиг • банкны сертификат • вексель • чек • коносомонт • варрант • опцион • форвард гэрээ • фьючерсийн гэрээ г.м



Үнэт цаасны ангилалт /үнэт цаасанд өөрт нь байгаа тодорхой шинжээр нь үнэт цаасны төрлүүдийг хуваахыг ойлгоно/	• биет болон биет бус • нэрийн, мэдүүлгийн, зөвшөөрлийн • үндсэн үнэт цаас, үүсмэл үнэт цаас • засгийн газрын, засаг даргын, хуулийн этгээдийн • үүргийн эрх зүйн, өмчийн эрх зүйн • хөрөнгө оруулалтын, төлбөр тооцооны • гадаадын, дотоодын г.м
---	---

Үнэт цаас нь мөнгө ч биш, материаллаг таваар ч биш. Түүний үнэт чанар нь эзэмшигчдээ эрх олгодогт оршдог

Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг

❖ Үнэт цаас эзэмшигч нь үнэт цаасыг эзэмших эрхийг санаатай, илт хайхрамжгүй зэрэг хууль бус бусад замаар олж авсан бол түүнийг шударга бус эзэмшигч гэж үзнэ
❖ Үнэт цаас гаргагч нь үнэт цаастай холбоотой аливаа шаардлагыг үнэт цаас эзэмшигчид гаргаж болно
❖ Үнэт цаас гаргагч үнэт цаасан дээр гарын үсгээ техник хэрэгслийн тусламжтайгаар үйлдсэн бол үнэт цаас эзэмшигч нь гарын үсэг хуурамч болохыг мэдэж байсан, эсхүл хайхрамжгүй хандсанаас бусад тохиолдолд үнэт цаас гаргагч нь тухайн техник хэрэгслийг ашиглах эрхгүй байсан гэсэн тайлбарыг үнэт цаас эзэмшигчид гаргах эрхгүй
❖ Үнэт цаасыг өөр этгээдийн өмчлөлд шилжүүлсэн бол үнэт цаас гаргагч нь түүнд санаатайгаар хохирол учруулснаас бусад тохиолдолд өмнөх эзэмшигчид шууд тавьж болох шаардлагыг дараагийн эзэмшигчид тавих эрхгүй
❖ Шууд тавьж үл болох татгалзлыг зөвхөн бусад санаатайгаар гэм хор учруулах, эсхүл илт хайхрамжгүй хандах замаар үнэт цаасыг өмчлөлдөө шилжүүлэн авсан эзэмшигчид гаргажболно
❖ Үнэт цаас гаргагч хүлээсэн үүргээ үнэт цаасыг түүнд шилжүүлэн өгсөн тохиолдолд биелүүлнэ

Үнэт цаасыг гаргасан, үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг болон үнэт цаасыг шилжүүлсэн бүх этгээд үнэт цаас өмчлөгчийн өмнө хууль тогтоомжид заасны дагуу хамтын хариуцлага хүлээдэг. Тодорхой этгээдийн нэр дээр бичигдсэн үнэт цаас нь амласан төлбөрийг түүнийг үзүүлэгч аливаа этгээдэд хийх тухай заалт агуулсан бол үүрэг гүйцэтгэгч болон үнэт цаас эзэмшигчийн хооронд хийсэн аливаа хэлцэл үүрэг гүйцэтгэгч нь санаатай, эсхүл илт хайхрамжгүй хандсанаас үл хамааран хүчин төгөлдөр байна.



Дасгал

1. Дараахь өгөгдөл дээр ажиллан нэрийн, мэдүүлгийн, зөвшөөрлийн үнэт цаасны алинд хамаарах хийгээд гэрээ мөн эсэхэд анализ хийн ярилцаарай.

ЭНГИЙН ВЕКСЕЛЬ

Вексель бичигчийн нэр хаяг

...../Батлан даах төлбөрийн мөнгөний

дүн, тоо, үсэг, валютын нэр /

...../Батлан даасан тухай тэмдэглэл/

200.. он ... сар... өдөр

.....

/Батлан даагчийн гарын үсэг тамга/

.....-д

/даалгавраар/

/вексель эзэмшигчийн нэр хаяг/

..... төгрөгийг /мөнгөний дүн тоо

үсгээр/, /төлбөр хийгдэх валютын нэр/

Энэ векселиэр төлөхийг баталж байна.

Төлбөр хийгдэх хугацаа.....хүү.....

Төлбөр хариуцагчийн нэр, хаяг

Төлбөр хариуцагчийн банкны нэр, хаяг

.....

.....

Төлбөр гүйцэтгэх дансны дугаар

Тамга

.....

/вексель бичигчийн гарын үсэг/



Энгийн векселийн ар тал

Дамжуулах бичилт

1.
2.
3.
4.
5.

2. Факторинг, опцион, форвард зэрэг аль нэг гэрээний загвар боловсруулж, гэрээнүүдийн загвар дээр багаар ажиллан ярилцаарай.
3. Үнэт цаасны төрөл тус бүрийг өгөгдсөн эх сурвалжийг ашиглан гүнзгийрүүлэн судалж давуу болон сул талыг жишээ гарган тайлбарла



Сорил

1. МУ-н Засгийн газраас хүүхдийн тэтгэлэгийг санхүүжүүлэхэд зориулж 10 тэрбум төгрөгний өрийн бичиг /бонд/ гаргахыг Улсын Их Хурлаас зөвшөөрчээ. Бонд нь:
 - a. зөвшөөрлийн үнэт цаас
 - b. мэдүүлгийн үнэт цаас
 - c. нэрийн үнэт цаас
 - d. үнэт цаас биш
2. Аль нь үнэт цаасны үндсэн шинжид хамааралгүй вэ?
 - a. биет болон биет бус
 - b. тодорхой эд хөрөнгийн эрхийг гэрчлэх
 - c. хөрөнгө оруулалтын хэрэгсэл
 - d. төрийн эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрөгдөх
3. Үнэт цаасны гүйлгээний талаархи маргааныг:
 - a. үнэт цаасны хороо шийдвэрлэнэ
 - b. шүүх шийдвэрлэнэ
 - c. хөрөнгийн бирж шийдвэрлэнэ
 - d. аль нь ч биш
4. "Жигүүр гранд" компани орон сууц барих чиглэлээр 2004 оноос эхний ээлжинд хагас тэрбум төгрөгийн сертификат Хөрөнгийн биржээр арилжаалж эхэлжээ. Эдгээр сертификат нь:
 - a. зөвшөөрлийн үнэт цаас
 - b. нэрийн үнэт цаас
 - c. мэдүүлгийн үнэт цаас
 - d. дээр дурдсан гурвын аль нь ч биш
5. Газар тариалан эрхэлдэг нэгэн компани хөрөнгө оруулалт хийх зорилгоор энгийн хувьцаа гарган нийтэд зарлан худалдахаар шийдвэрлэсэн байна.

Энэ тохиолдолд:

- a. хөрөнгийн биржээс зөвшөөрөл авах шаардлагатай*
 - b. үнэт цаасны хорооноос зөвшөөрөл авах шаардлагатай*
 - c. аль нэг байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагагүй*
 - d. харьяа брокерийн пүүсэд бүртгүүлэх*
6. Брокерийн нэгэн пүүст худалдахаар ирүүлсэн 5 сая төгрөгийн үнэт цааснаас 1 сая төгрөгийн үнэт цаасыг зээлээр худалдаалсан байна. Зээлээр худалдаалах нь:
- a. хуулиар зөвшөөрөгдсөн*
 - b. хуулиар хориглосон*
 - c. хуульд заагаагүй үйлдэл*
 - d. хөрөнгийн биржээр зөвшөөрөгдсөн*
7. Хөрөнгийн бирж нь үнэт цаасны худалдааг зохион байгуулахдаа дараахь шаардлагыг баримтална:
- a. үнэт цаасыг худалдахад хамгийн бага үнээс, худалдан авахад хамгийн өндөр үнээс эхлэх*
 - b. үнэт цаасыг худалдахад хамгийн өндөр үнээс, худалдан авахад хамгийн бага үнээс эхлэх*
 - c. харилцан тохиролцсон үнээр худалдах, худалдан авах*
 - d. ямар нэгэн журам баримтлахгүй*
8. Монгол Улсын иргэн та үнэт цаас гаргаж болох уу?
- a. болно*
 - b. болохгүй*



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I - III дэд хэсэг, II хэсэг 467-475 р зүйл
- Монгол улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /2002 он/
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу



IV бүлэг. ЗЭЭЛ ТООЦООНЫ ҮҮРЭГ, ТӨРӨЛ, ОНЦЛОГ

Бүлгийн зорилго: Иргэний эрх зүйн үүргийн харилцааны субъектууд буюу төлбөр-тооцооны үйл ажиллагааг эрхлэх байгууллага-хуулийн этгээдээс эд хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой ба бусад үндэслэлээр үүсч байгаа төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбогдсон иргэний эрх зүйн харилцааны үндсийн талаар мэдлэгтэй болох, төлбөр тооцоотой холбогдсон гэрээ байгуулах чадвар эзэмших, дээрх ойлголтыг эдийн засгийн болон бизнесийн харилцааны агуулгатай зэрэгцүүлэн судлах ханддага төлөвшинө.

1. Төлбөр тооцооны гэрээ

Сэдвийн зорилго: Банк болон эрх бүхий хуулийн этгээд нь иргэд болон хуулийн этгээдийн бэлэн болон бэлэн бусаар хийх төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбогдсон үүргийн харилцааны эрх зүйн зохицуулалт, онцлогийн талаар мэдлэг эзэмших, төлбөр тооцооны гэрээг байгуулах, уг харилцаанд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө өгөх чадвартай болно.



Нэр томъёоны тайлбар

Бэлэн ба бэлэн бус төлбөр тооцоо - бэлэн мөнгө болон тооцооны хэрэгсэл ашиглан гүйлгээ хийх

Төлбөр тооцоо гүйцэтгэгч - төлбөр тооцоо гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээд болон банк

Харилцагч - төлбөр тооцоо гүйцэтгэгчээр үйлчлүүлэгч этгээд


Нягтлан бодох бүртгэл - эдийн засгийн тоон мэдээллийг танин мэдэж, мөнгөн нэгжээр тооцон хэмжиж, шинжлэн боловсруулж, хэрэглэгчдийг оновчтой дүгнэлт пшидвэр гаргах боломжоор хангадаг мэдээллийн систем

Дансны гүйлгээ - банк болон эрх бүхий хуулийн этгээдийн нэр дээр нээсэн дансаар дамжуулан хийгдэх мөнгөн хөрөнгийн урсгал

Бенефициар - үүрэг гүйцэтгүүлэх ашигтай хувилбарыг сонгож аккредитив нээлгэсэн болон даатгалын байгууллагаар хамгаалагдсан этгээд

Принципал - үндсэн үүрэг гүйцэтгэгч

Зах зээл хөгжсөн улс орнуудад байгууллага иргэдийн хооронд бэлэн мөнгөөр гүйлгээ хийх нь эрс багасаж бэлэн мөнгийг орлох төрөл бүрийн төлбөрийн хэрэгслийг өргөн хэрэглэж байна. Манай улсын хувьд ч уг төлбөр тооцооны хэрэгслийг өргөн ашигладаг болж байна. Төлбөр тооцооны үйлчилгээг төрөл бүрийн санхүүгийн хэрэгсэл ашиглан санхүүгийн байгууллага болох банк, банк бус санхүүгийн байгууллага үзүүлдэг.



Төлбөр тооцооны гэрээний онцлог

➤ Төлбөр тооцоо гүйцэтгэгч нь харилцагчийн өгсөн үүрэг буюу зөвшөөрлийн үндсэн дээр гэрээнд заасны дагуу төлбөр тооцоог гүйцэтгэнэ
➤ Дансан дахь мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах харилцагчийн эрхийг төлбөр тооцоо гүйцэтгэгч хязгаарлах, хянах эрхгүй
➤ Бэлэн болон бэлэн бус төлбөр тооцооны нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үүрэгтэй
➤ Гэрээнд заасан хугацаанд харилцагчид түүний дансны талаар мэдээлэл, дансны хуулга өгөх
➤ Харилцагчийн данснаас түүний өгсөн үүрэг буюу зөвшөөрлийн үндсэн дээр гүйлгээхийх
➤ Хуульд зааснаас бусад тохиолдолд данс, гүйлгээтэй холбоотой нууцыг задруулахгүй байх
➤ Алдаатай хийсэн мөнгөн төлбөрийн гүйлгээг залруулж, харилцагчийг хохиролгүй болгох
➤ Харилцагчийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх
➤ Харилцагчийн хувьд, өөрийн данс, гүйлгээний талаархи мэдээллийг хэдийд ч авах, Мөнгөн төлбөрийн гүйлгээг гүйцэтгэхээс өмнө төлбөрийн даалгавраа цуцлах эрхтэй. Ингэсэн нөхцөлд харилцагч нь төлбөр тооцоо гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэх бөгөөд төлбөр тооцоо гүйцэтгэгч нь төлбөрийн даалгаварт заасан мөнгийг харилцагчийн дансанд буцаан оруулна



Төлбөр
тооцоог

Банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан гүйцэтгэнэ. Бэлэн бусаар хийх төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, аккредитив, инкасс, чек, вексель, төлбөрийн карт, электрон төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр гүйцэтгэдэг

Гадаад төлбөр тооцоо, дотоод төлбөр тооцоо гэсэн хэлбэртэй бөгөөд гадаад төлбөр тооцоонд хамгийн их хэрэглэдэг нь аккредитив, инкасс болон олон улсын эрхтэй төлбөрийн карт юм. Төлбөрийн карт нь мондекс, терминал, виза, мастер, смарт г.м олон төрөлтэй

Аккредитив
нь

Төлбөр
тооцооны
гэрээ нь

Олон улсын худалдаанд төлбөрийн найдвартай байдлыг хангадаг хамгийн үр ашигтай хэрэгсэл боловч зардал нь харьцангуй өндөр байдаг. Аккредитив нээсэн банк нь үйлчлүүлэгчийн гаргасан хүсэлт, өгсөн үүрэг, зааврын дагуу гуравдагч этгээд /төлбөр авагч/-ээс тодорхой бичиг баримт хүлээн авч, хариуд нь түүнд буюу түүний заасан этгээдэд мөнгө шилжүүлэх, төлбөр авагчийн бичсэн шилжих вексельд заасан төлбөрийг төлөх буюу зөвшөөрөх, эсхүл уг гүйлгээг гүйцэтгэхийг өөр банкинд даалгах үүрэг хүлээнэ

Аккредитив

Үйлчлүүлэгч нь харилцан тохиролцсон хөлсийг банкинд төлнө. Аккредитивийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална. Аккредитивийн үйл ажиллагаанд аккредитив нээлгэгч, нээгч банк, мэдэгдэгч банк, батлагч банк, бенефициар гэсэн талууд оролцдог. Аккредитивийн дараахь төрлүүд байдаг.

- ❖ баримтаар шууд төлбөр хийх аккредитив /sight credit/
- ❖ хугацаанд нь төлбөр хийх аккредитив /deferred payment credit
- ❖ акцептаар төлбөр хийх аккредитив /acceptance credit/
- ❖ хэлцэлийн аккредитив /negotiation credit /
- ❖ урьдчилгаа зээл бүхий аккредитив /red clause credit /
- ❖ сэргээгдэх аккредитив /revolving credit /
- ❖ стэндбай өюуу бэлэн байдлыг илтгэх\standby credit\
- ❖ дамжин төлөгдөх баримтын аккредитив /transferable credit /

Инкасс

Инкасс нь аккредитивийн адил мөн олон улсын худалдаанд өргөн хэргэлдэг. Инкассаар төлбөр тооцоо хийж байгаа үед экспортлогч тал бараа ачуулахдаа худалдан авагч мөнгөө төлнө гэдэгт бүрэн итгэлтэй байж чаддаггүй. Иймээс инкассийг талууд маш сайн бизнесийн харилцаатай импортлогч орны улс төр эдийн засагтогтвортой үедхэрэглэхнь зүйтэй байдаг. Инкассийн төлбөр тооцоогоор төлбөр тооцоо гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчийн өгсөн даалгаврын дагуу, түүний зардлаар, төлбөр хариуцагчаас төлбөрийг хүлээн авах буюу төлбөр хийх үүрэг хүлээнэ. Инкассийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд хууль, олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг мөн баримтална. Инкасс нь харилцах данс нээж урьдчилж бараа нийлүүлэх тооцоо хийхээс илүү хэмжээгээр найдвартай байдлыг хангаж өгдөг. Учир нь импортлогч тал төлбөр хийгээгүй эсвэл төлбөр нэхэмжлэх вексельд акцент хийгээгүй үед барааг эзэмшлдээ шилжүүлэн авч чадахгүй бөгөөд холбогдох банкууд худалдан авагчийн өмнөөс төлбөр хийх үүрэг хүлээдэггүй. Ийнхүү албан ёсны хатуу шаардлага бага байдгаараа энэ нь оролцогч талуудад хямд, уян хатан байдаг.



Дасгал

1. ОХУ-н иргэн Семёнова.М.М өөрийн олон улсын виза картаар "Номин" супермаркетаас хүнсний зүйл худалдан авч тооцоог хийжээ.
 - Ямар төрлийн гэрээ хийгдсэн бэ?
 - Гэрээнд ямар ямар талууд оролдсон бэ?
 - Гэрээний зүйлийг тодорхойлно уу.
2. "ХХХ" банкны харилцагч Алтай нь "АСА" компаниас 2006 оны 01 сарын 08-нд 100,000,000Т хагас жилийн хугацаатай 2%-н хүүтэй, сар бүр үндсэн төлбөрөөс 20,000,000Т төлөхөөр зээлсэн. "АСА" компани сар бүрын 8-нд "ХХХ" банкин дахь Алтайгийн харилцах данснаас нь зээлийн төлбөрийг татаж авч байхаар тохиролцсон бөгөөд хугацаа хоцорсон хоног тутамд 0,5 % -н алданги төлөхөөр тохирсон. Алтай Хөвсгөл аймагт ажлаар явж байх зуураа хоёр сарын 7-нд 22,000,000Т дансандаа "ААА" банкнаас пшлжүүлэн хийсэн боловч харилцах дансанд нь мөнгө хугацаандаа ороогүйн улмаас 3 хоногийн алданги / 330,000Т/ тооцсон нэхэмжлэх Алтайд иржээ. Алтай хугацаандаа мөнгөө шилжүүлсэн тул уг шаардлагыг биелүүлэхгүй гэсэн. Өгөгдөлд хууль зүйн тайлбар хийж асуудлыг шийдвэрлэнэ үү.
 - Алдангийг хэн барагдуулах вэ?
3. Дараахь сэдвээс сонгон эссэ бичнэ үү.
 - Төлбөр, тооцоотой холбогдох харилцаа гэрээний эрх зүйгээр зохицуулагдахын хууль зүйн учир холбогдол
 - Төлбөр тооцооны хэрэгсэл
 - Гадаад төлбөр тооцоо
 - Дотоод төлбөр тооцоо



Сорил

1. Төлбөр тооцооны гэрээгээр төлбөрийг дараахь хэлбэрээр хийнэ.
 - a. бэлэн мөнгөөр
 - b. бэлэн бусаар
 - c. бэлнээр болон бэлэн бусаар
2. Бэлэн бусаар хийх төлбөрийн хэрэгсэлд үл хамаарахыг дугуйлна уу.
 - a. чек
 - b. голомтын алтан карт
 - c. валют
 - d. аккредитив
3. Төлбөр тооцооны гэрээ нь
 - a. хариу төлбөртэй
 - b. хариу төлбөргүй
 - c. хариу төлбөртэй ба төлбөргүй
4. Төлбөр тооцоо гүйцэтгэгчийн үүрэгт аль нь хамааралтай вэ?
 - a. төлбөр тооцооны нягтлан бодох бүртгэл хөтлөх
 - b. харилцагчийн данснаас дурын гүйлгээг хийх
 - c. данс гүйлгээтэй холбоотой нууцыг задруулахгүй байх
 - d. А болон В хариулт зөв
5. Төлбөр тооцоо, зээл, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна гэж Иргэний хуульд заасан. Энэ хууль нь:
 - a. банкны тухай хууль
 - b. банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль
 - c. хадгаламжийн тухай хууль
 - d. даатгалын тухай хууль



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судааарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 445-450 р зүйл
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 443479 р тал, 408440 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под ред Платонова. Д.И 95-99 р тал

2. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс зээл олгох гэрээ

Сэдвийн зорилго: Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд тохирсон хугацаанд /гэрээнд заасан бол хүүгийн хамт/ буцаан төлөх үүргээс үүсэх харилцааг гэрээгээр зохицуулах онцлог, шинжийн талаар мэдлэг эзэмших, банкны зээлийн гэрээний шаардлагад нийцүүлэн гэрээг байгуулах, үүргийн гүйцэтгэлийг хангах аргуудыг тухайн гэрээнд хэрэглэх чадвартай болно.



Нэр томъёоны тайлбар

Банк - санхүүгийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээд
Зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага - Монгол Банкнаас зээлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд /банк бус санхүүгийн байгууллага/

Зээлийн хүү - зээлийн гэрээний хариу төлбөр

Нэмэгдүүлсэн хүү - зээлдэгч гэрээнд заасан үүргээ зохих ёсоор хугацаанд нь гүйцэтгээгүй нөхцөлд гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс тогтоосон үндсэн хүү дээр гэрээнд зааснаар нэмж төлж буй хүүгийн төлбөр

Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ нь банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /"зээлдүүлэгч"/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүрэг бүхий гэрээ

Энэ гэрээ нь
урьдчилан
тохиролцсон,
хоёр талын,
хариу төлбөртэй
болон төлбөргүй,
хугацаатай гэрээ юм



**ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН
ШИНЖ:**



Гэрээний онцлог

- Хэлбэрийн хувьд уг гэрээг бичгээр байгуулна
- Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээнд зээлдүүлэгч, /эрх бүхий хуулийн этгээд/ зээлдэгч /иргэн, хуулийн этгээд/ гэсэн талууд оролцоно
- Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй буюу хүүгүй байж болно. Зээлдүүлэгч зээлийн хүүгийнхээ хэмжээг нийтэд мэдээлэх үүрэгтэй
- Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд зааж болно
- Гэрээний үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгээгүй бол үүрэг гүйцэтгэгчид нэмэгдэл үүрэг бий болгох, үүрэг гүйцэтгэгчийн зэрэгцээ гуравдагч этгээдэд үүргийн гүйцэтгэлийг хариуцуулах, мөнгөн төлбөр гаргуулах /**батлан даалт, баталгаа**/, түүнчлэн тодорхой эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангах /**дэнчин, барьцаа, фидуци**/ зэрэг эрхийг үүрэг гүйцэтгүүлэгч эдлэх боломжтой. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд үндсэн гэрээтэй хамт дээр дурьдсан нэмэгдэл гэрээг байгуулна
- Зээлдэгчийн **хариуцлагын** хувьд зээлдэгч авсан зээлээ гэрээнд заасан хугацаанд нь төлөөгүй бол дээр дурьдсанчлан хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд барьцааны зүйлийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд заасан бол гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн тухайн барьцааны зүйлээр өөрийн шаардлагаа хангуулах эрхтэй. Гэхдээ барьцааны зүйл нь ямар хөрөнгө байхаас шалтгаалан эрх зүйн зохицуулалт нь ялгамжтай



Дасгал

1. Иргэн А нь "XXX" банк бус санхүүгийн байгууллагаас 10,000,000Т-н зээлийг сарын 3 % -ийн хүүтэй 5 сарын хугацаатай зээлсэн бөгөөд барьцаанд нь өөрийн ланд 105 маркын машинаа тавьсан. Гэрээндээ "хэрвээ хугацаандаа үүргээ гүйцэтгэхгүй бол машиныг үл маргах журмаар "XXX" компаний өмчлөлд шилжүүлэхээр тохиролцжээ. Хууль зүйн тайлбар хийж асуудлыг шийдвэрлэнэ үү.
 - Шаардах эрх хэдий үеэс үүсэх вэ?
 - "XXX" компани уг хөрөнгийг шууд захиран зарцуулж болох уу? /яагаад/
2. Дасгал 1-д өгөгдсөн тохиолдлын үүсмэл гэрээ нь үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ байсан бол асуудлыг хэрхэн зохицуулах вэ?

Дараахь сэдвээс сонгон эссэ бичнэ үү

- Банкны зээлийн гэрээг өөрчлөх, цуцлах, дуусгавар болгох үндэслэл
 - Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээнд фидуцийг хэрэглэх нь -
 - Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээнд дэнчинг хэрэглэх нь
3. Иргэний хуулийн 451-453 р зүйлүүдийг гүнзгийрүүлэн судалж гэрээний талууд болох зээлдэгч, зээлдүүлэгчийн эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

1. Иргэн А нь "XXX" Банк бус санхүүгийн байгууллагаас 10 сая төгрөгийг, сарын 3 хувийн хүүтэй, 1 сарын хугацаатай зээлж авсан. Зээлийн гэрээгээ бичгээр хийгээгүй. Энэ нь:
 - a. зээлийн гэрээг байгуулсан .
 - b. гэрээний саналд хариу өгсөн
 - c. гэрээний хэлбэрт тавигдах шаардлагыг зөрчсөн
 - d. дээр дурдсан гурвын аль нь ч биш
2. Банкны зээлийн гэрээнд зээлдэгч зээлийг эргүүлэн төлөх хугацаа хэтрүүлсэн тохиолдолд анз төлүүлэх тухай заасан байна. Энэ заалт нь:
 - a. буруу заалт
 - b. зөв заалт
 - c. гэрээнд заасан тул анз төлүүлнэ
 - d. дээр дурдсан гурвын аль нь ч биш
3. Иргэн А нь банкнаас зээлдэн авсан 10 сая төгрөгийн зээлээ 1 сар хожимдуулан эргүүлэн төлжээ. Банк зээлийн хугацаа хэтэрсэн 1 сард хүүг 20 хувь нэмэгдүүлэн тооцож төлөхийг А- аас шаардсан байна. Энэ шаардлага нь
 - a. хүүг нэмэгдүүлэн тооцох нь зөв
 - b. гэрээгээр тохиролцсон бол болно
 - c. хүүг нэмэгдүүлэн тооцох нь буруу
 - d. дээр дурдсан гурвын аль нь ч биш
4. Банкны зээлийн нэмэлт /үүсмэл/ гэрээнд доорх нөхцөлүүдийн аль нь илүү тохиромжтой вэ?
 - a. фидуцийн зүйл нь зээлдэгчийн өмчлөлд байх
 - b. барьцааны зүйл зээлдүүлэгчийн өмчлөлд байх
 - c. дэнчингийн зүйл нь гагцхүү эд хөрөнгө байх
 - d. зээлдэгч гуравдагч этгээдээр баталгаа болон батлан даалт гаргуулах
5. Банк бус санхүүгийн байгууллагаас зээл олгох гэрээнд нэмэгдүүлсэн хүүг



- a. үндсэн хуулийн 20 хувиас хэтрүүлэхгүй*
 - b. үндсэн зээлийн 20 хувиас хэтрүүлэхгүй*
 - c. төлөгдөөгүй үлдсэн зээлийн 20 хувиас хэтрэхгүй*
 - d. нэмэгдүүлсэн хүү хэрэглэхгүй*
6. Иргэн А нь Банк бус санхүүгийн байгууллагаас зээл авч барьцаанд нь өөрийн хашаа байшинг тавихаар болсон. Банк бус санхүүгийн байгууллагын ажилтан барьцаа хөрөнгийн үнэлгээг тогтоохдоо:
- a. зах зээлийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрүүлэхгүй тогтооно*
 - b. гэрээ байгуулахдаа харилцан тохиролцоно*
 - c. орон сууцны ҮХЭХБГэрчилгээнд бичигдсэн үнийг баримтална*
 - d. аль нь ч биш*
7. Иргэн А нь Банк бус санхүүгийн байгууллагаас авсан зээлийн барьцаанд мод боловсруулах тоног төхөөрөмж тавьсан. Гэтэл зээлдүүлэгч байгууллагын агуулахад гал гарч тоног төхөөрөмж шатаж гэмтсэн байна.
- a. энэ тохиолдолд Банк бус санхүүгийн байгууллага хуульд заасан хариуцлага хүлээнэ*
 - b. банк бус санхүүгийн байгууллага хариуцлага хүлээхгүй*
 - c. банк бус санхүүгийн байгууллагын гэм бурууг харгалзан хариуцлага хүлээлгэнэ.*



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I - III дэд хэсэг, II хэсэг 451-453 р зүйл
- Монгол улсын банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль /1995 он/
- Иргэний эрх зүй. Үүргийн тусгай төрөл. Т.Мөнхжаргал. 137 р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг /1999 он/ 155 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 381-382 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под.ред Платонова. Д.И 85-86 р тал

3. Мөнгөн хадгаламжийн гэрээ

Сэдвийн зорилго: Мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, хадгалуулагч нарын хооронд мөнгөн хөрөнгийг хадгалуулах, олгохтой холбогдон үүсч байгаа харилцааг гэрээгээр зохицуулах, түүний шинж, элементийн талаар цэгцтэй мэдлэг эзэмших, тухайн гэрээг байгуулах, хууль зүйн зөвлөгөө өгөх чадвартай болоход оршино.



Нэр томъёоны тайлбар

Мөнгөн хадгаламж - хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд хадгалуулахаар өгсөн мөнгөн хөрөнгө

Хадгалуулагч - хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдэд хөрөнгөө хадгалуулахаар өгсөн этгээд

Мөнгөн хадгаламжийн гэрээ - нэг тал болох хадгалуулагч нь мөнгөө хадгалуулах эрхтэй, банк болон мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь хадгалуулагчийн мөнгийг хадгалах, хадгалуулсан мөнгийг тухайн мөнгөн тэмдэгтээр хүүгийн хамт буцаан олгох үүрэг бүхий гэрээ.

Энэ гэрээ нь бодит, хоёр талын, хариу төлбөртэй, тодорхой болон тодорхой бус хугацаатай гэрээ юм



ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ШИНЖ:

Мөнгөн хадгаламжийн гэрээний онцлог:

- Мөнгөн хадгаламжийн гэрээний гол нөхцөлд
 - мөнгөн хөрөнгийн хэмжээ
 - хадгалалтын хугацаа
 - хүүгийн хэмжээ, түүнийг тооцох журам,
 - гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд талуудын хүлээх хариуцлага талууд гол нөхцөл болгон оруулсан бусад зүйлийг тусгана



- мөнгөн хадгаламжийн гэрээг хадгаламжийн дэвтэр, хадгаламжийн сертификат, болон хуульд заасан бусад арга хэрэгслийг ашиглан бичгээр байгуулна
- мөнгөн хадгаламжийн гэрээний нэг онцлог бол хадгалуулагч хадгалуулсан мөнгөө буцаан шаардахад хөөн хэлэлцэх хугацаа хамаардаггүй явдал юм. Мөн түүнчлэн хадгалуулагч эрх эдэлж, хадгалагч үүрэг хүлээж байдаг
- мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой хугацаатай байгуулсан бол банк уг хугацаа дууссаны дараа хадгалуулагчийн анхны шаардлагаар хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүү төлөх бөгөөд гэрээнд заасан хугацаа дууссан боловч хадгалуулагч мөнгөө буцаан авах шаардлага тавиагүй бол уг гэрээг цаашид тодорхой бус хугацаагаар сунгасанд тооцно



Дасгал

1. Иргэн Б нь өвчний улмаас хэвтэрт байсан тул өөрийн эхнэр Д-г банкин дахь мөнгөн хадгаламжаас мөнгө авахуулахаар явуулсан. Эхнэр нь хадгаламжийн дэвтэр болон нөхрийнхөө иргэний үнэмлэхийг авч очин банкнаас мөнгө авах гэтэл банк мөнгө өгсөнгүй.
 - Банкны үйлдэл зөв үү
 - Мөнгийг хэрхэн авах талаар зөвлөгөө өгнө үү
2. Иргэн А нь "XXX" банктай мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулсан бөгөөд гэрээний хугацаа дуусахаас 3-н сарын өмнө гэрээг цуцалж, хадгалуулсан мөнгөө хүүгийн хамт буцаан авахыг шаарджээ.
 - Иргэн А нь хугацаанаас өмнө гэрээг цуцлах эрхтэй эсэх
 - Дээрхи тохиолдол дээр мөнгөн хадгаламжийн гэрээг хугацаатай ба хугацаагүй байгуулахын учир холбогдлыг тайлбарлана уу
3. Дараахи сэдвээс сонгон эссэ бичнэ үү.
 - Мөнгөн хадгаламжийн гэрээг харьцуулан судлах нь
 - Мөнгөн хадгаламжийн гэрээний хариуцлага
 - Мөнгөн хадгаламжийн даатгалын зохицуулалт
4. Иргэний хуулийн 454-456 р зүйлүүдийг судлан гэрээний талууд болох хадгалагч, хадгалуулагчийн эрх, үүргийг тодорхойлон ярилцарай.



Сорил

1. "XXX" банкны гүйцэтгэх захирлын тушаал гарч өөрийн банкны хадгаламжийн хүүгийн хэмжээг өөрчлөх тухай шийдвэр гаргасан байна. Банк хүүгийн хэмжээний тухай:

- a. өөрийн байгууллагын ажилчдад мэдээлнэ
 - b. хадгаламж эзэмшихийг хүссэн этгээдэд мэдээлнэ
 - c. нийтэд мэдээлэх үүрэгтэй
2. Банкин дахь мөнгөн хадгаламжаа буцаан шаардах шаардлагын хөөн хэлэлцэх хугацаа нь:
 - d. гэрээний үүрэгт хамаарах учраас 3 жил
 - e. хөөн хэлэлцэх ерөнхий хугацаагаар 10 жил
 - f. хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй
 - g. хугацаатай байгуулсан гэрээний хугацаагаар
3. Иргэн А-аас 15 сая төгрөгийн авлагатай Б нь А-ийн банкинд хадгалуулсан мөнгөний талаар мэдээлэл авахыг хүссэн боловч, банкны ажилтан татгалзсан хариу өгчээ
 - a. банкны ажилтны зөв
 - b. банкны ажилтны татгалзал үндэслэлгүй
 - c. цагдаагийн ажилтанд л гаргаж өгнө
 - d. А, Б, В-н аль нь ч биш
4. Иргэн А банкбуссанхүүгийн байгууллагад мөнгөө хугацаатай хадгалуулсан. Уг мөнгийг иргэн Ц-д бэлэглэн, түүний нэр дээр шилжүүлэхийг хүссэн. Гэтэл хадгалагч тал "гэрээний хугацаа дуусаагүй тул ийнхүү шилжүүлэх боломжгүй" гэсэн
 - a. банк бус санхүүгийн байгууллагын хариу үндэслэлтэй
 - b. А хадгаламж дахь мөнгөө бусдад бэлэглэх эрхтэй
 - c. гэрээгээр тохиролцсон бол болно
 - d. А, Б, В -н аль нь ч биш



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 454-456 р зүйл
- Монгол улсын банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль /1995 он/
- Иргэний эрх зүй. Үүргийн тусгай төрөл. Т.Мөнхжаргал. 140 р тал
- Иргэний эрх зүйн үндсэн асуудал. Д.Наранчимэг /1999 он/ 154 р тал
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 391-407 р тал
- Конспект лекций. Гражданское право Часть 2. /обязательственное право/ под.ред. Платонова. Д.И 89-90 р тал, 92-94 р тал



4. Банкны баталгаа ба батлан даалтын гэрээ

Сэдвийн зорилго: Банктай харилцах харилцааны нэг зохицуулалт болох банкны баталгаа /үүрэг гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс банк нь үүрэг гүйцэтгүүлэгчид мөнгөн төлбөр төлөх, үүрэг гүйцэтгэгч нь тухайн баталгаа гаргагч банкинд төлбөр төлөх/, батлан даалт /үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө батлан даагч нь үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэнэ гэж батлах, улмаар гүйцэтгээгүй бол өөрөө хариуцах үүрэг хүлээх/-ын зохицуулалтын онцлог, ялгаа, эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэг эзэмших, баталгаа болон батлан даалтыг оновчтой хэрэглэх чадвартай болно.



Нэр томъёоны тайлбар

Баталгаа - үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар гуравдагч этгээдээс үүрэг гүйдэтгүүлэгчийн өмнө хүлээж буй, үл маргах журмаар биелүүлэх, үндсэн ба нэмэгдэл үүргийн хосолмол шинжтэй үүрэг бүхий үүргийн гүйцэтгэлийг хангах арга

Батлан даалт - гуравдагч этгээд нь үүрэг гүйцэтгэгч өөрийн үүргийг гүйцэтгэж чадна гэж үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө баталж гүйцэтгэхгүй бол өөрөө тухайн үүргийг бүрэн болон хэсэгчлэн хариуцах үүрэг хүлээдэг үүргийн гүйцэтгэлийг хангах арга

Ердийн боломжит хугацаа - хэлцэл байгуулагч этгээдийн байдал, хэлцлийн зүйлийн мөн чанар онцлогоос хамааран тооцдог хугацаа

Батлан даагч үүргээсээ татгалзах - батлан даагч нь үүрэг гүйцэтгэгчийн даалгавраар үүрэг хүлээсэн, бусдын үүргийг даалгаваргүйгээр гүйцэтгэх журмын дагуу үүрэг гүйцэтгэгчийн төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэх тохиолдолд хуульд заасан үндэслэл журмын дагуу үүргээсээ татгалзах

Баталгааны гэрээ

Батлан даалтын болон баталгааны гэрээнүүд аль аль нь нэмэгдэл үүргийн шинжтэй ч ялгагдах гол шинж нь баталгаа нь бие даасан шинжтэй бөгөөд тухайлбал үндсэн үүрэг хүчин төгөлдөр бус болсон явдал нь баталгааг дуусгавар болгох үндэслэл болдоггүй байх явдал юм.

Банкны баталгаа нь баталгааны гэрээний нэг төрөл юм

Банкны баталгааны онцлог

- Банк үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахаас өмнө үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн, тухайн үүрэг бусад үндэслэлээр дуусгавар болсон, эсхүл хүчин төгөлдөр бус болсон бол баталгаа гаргагч банк энэ тухай үүрэг гүйцэтгүүлэгчид нэн даруй мэдэгдэнэ

- Үүрэг гүйцэтгүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш баталгаа гаргагч банкнаас мөнгөн төлбөр төлөхийг дахин шаардвал банк шаардлагыг хангаж, гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлнэ гэж хуульд заасан байна
- Банкны баталгаа нь үүргийн эрх зүйд зарим нэг онцлогтой. Тухайлбал, нийтлэг журмын дагуу үүрэг гүйцэтгүүлэгч эрхээ өөр этгээдэд шилжүүлэхийн тулд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авах шаардлага байдаггүй
- Банкны баталгааны үед бенефициар баталгаа гаргагчаас шаардах эрхээ өөр этгээдэд шилжүүлж болдоггүй. Шаардлага шилжих явдал нь гагцхүү баталгаа гаргагчийн зөвшөөрлөөр хийгдэх ба уг зөвшөөрөл нь баталгааны гэрээнд тэрээр шууд гарын үсэг зурсан эсхүл, бенефициарын шаардлагыг баталгаа гаргагч хүлээн авахаас өмнө хожим нь хүлээн зөвшөөрөх байдлаар илэрч болно
- Банкны баталгааг
принципалын гэрээлэгчийн ашиг тусын тулд /шууд баталгаа/
гэрээлэгчид үйлчилдэг банкны ашиг тусын тулд /шууд бус баталгаа / хийж болно
- Бенефициар мөнгөн хөрөнгийг төлөх тухай шаардлагыг баталгаа гаргагчид тавих үед уг шаардлагаа нотолсон баримтуудыг хавсаргасан байх байх ба уг баримтууд банкны баталгааны нөхцлийг хангаагүй бол бенефициарын шаардлагыг хангахаас баталгаа гаргагч татгалзах эрхтэй. Мөн банк баталгаа гаргаж өгснийхөө төлөө баталгааны мөнгөн дүнгийн тодорхой хувиар эсвэл хатуу тогтоосон хэмжээгээр шагнал авах эрхтэй
- Банк, үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж төлсөн мөнгийг үүрэг гүйцэтгэгчид сөрөг нэхэмжлэл гаргах замаар буцаан авах талаар баталгаа гаргагч болон үүрэг гүйдэтгэгч гэрээгээр харилцан тохиролцож болдог
- Баталгаа гаргагч банк гэрээний нөхцөлийг зөрчиж үүрэг гүйцэтгүүлэгчид төлбөр төлсөн, эсхүл хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас хариуцлага хүлээсэн бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгэгчээс уг төлбөрийг шаардах эрхгүй

Банкны баталгааны гэрээгээр банк нь үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр тавьсан шаардлагаар үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг гүйцэтгэх, үүрэг гүйцэтгэгч нь баталгаа гаргагч банкинд төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ



Энэ гэрээ нь хоёр талын, урьдчилан тохиролцсон, хариу талбөртэй гэрээ юм



Баталгаа гаргагч банкны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх үүрэг дараахь тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

- баталгаа гаргагч банк үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн
- гэрээнд заасан хугацаа дуусгавар болсон
- үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнд заасан шаардах эрхээсээ татгалзсан.

Батлан даалтын гэрээ- батлан даагч нь үүрэг гүйцэтгэгч өөрийн үүргийг гүйцэтгэж чадна гэж үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө баталж гүйцэтгэхгүй бол өөрөө хариуцах үүрэг хүлээдэг үндсэн гэрээтэй холбогдон үүсдэг нэмэгдэл гэрээ юм

Энэ гэрээ нь хоёр
талын, хариу
төлбөртэй болон
төлбөргүй, урьдчилан
тохиролцсон гэрээ
юм



**ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН
ШИНЖ:**

Батлан даалтын гэрээний онцлог

- Батлан даалтын гэрээг хэлбэрийн хувьд бичгээр байгуулахыг шаарддаг боловч ажил үүргийн хүрээнд батлан даалт гаргасан бол батлан даалтын гэрээг бичгээр байгуулахгүй байж болдог
- Батлан даалтын гэрээнд батлан даагчийн хүлээх хариуцлагын дээд хязгаарыг батлан даалтын гэрээнд заавал тусгах шаардлагатай
- Батлан даалтын гэрээ нь баталгаатай харьцуулахад эрсдэл багатай боловч батлан даагч маань батлан даалтын хүрээ үндсэн гэрээний агуулгад анхаарч батлан даалтын нөхцлөө ул суурьтай, тодорхой тохиролцох нь чухал


Батлан даалтын хариуцлага:

Батлан даагч нь үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс нөхөх хариуцлага хүлээнэ.

А- үүрэг гүйцэтгүүлэгч

Б- үүрэг гүйцэтгэгч

С- батлан даагч



А нь эхлээд үүрэг гүйцэтгэгч Б-ээс үүргээ гүйцэтгэхийг шаардах бөгөөд Б үүргээ бүрэн болон хэсэгчлэн гүйцэтгээгүй бол гүйцэтгээгүй хэмжээгээр А нь С-ээс шаардана. Батлан даалтын гэрээний дагуу үүргийг гүйцэтгэсэн батлан даагч С-д үүргийн гүйцэтгэлийг Б-ээс шаардах эрх шилжинэ. Өөрөөр хэлбэл Б батлан даасан хэмжээгээр үүргийг батлан даагч С-ийн өмнө хариуцна

Мөн түүнчлэн хэд хэдэн этгээд батлан даагч байх тохиолдолд тэдгээр нь батлан даалтыг хамтран гаргасан эсэхээс үл хамааран үүрэг гүйцэтгээгүйн хариуцлагыг хамтран хүлээнэ. Батлан даагч нь дээр өгүүлсэнчлэн батлан даалтын хэмжээг тодорхой заах шаардлагатай бөгөөд уг заасан хэмжээгээрээ л хариуцлага хүлээнэ.

Батлан даалтын гэрээг дараахь үндэслэлээр дуусгавар болгоно.

- Батлан даалтын гэрээг тодорхой хугацаа заалгүй хийсэн бол батлан даагч нь гэрээг дуусгавар болгохоос гурваас доошгүй сарын өмнө мэдэгдэнэ.
- Таван жилээс дээш хугацаатайгаар байгуулсан батлан даалтын гэрээг таван жил өнгөрсний дараа дээр дурьдсаны дагуу дуусгавар болгож болно.

Дасгал

1. Иргэн А нь өөрийн охиныг ХБНГУ-д сургуульд явуулахаар болж Х банкаар өөрийн хадгаламжийг барьцаалан 10 сая төгрөгийн төлбөрийн баталгааг сургуульд нь гаргуулжээ. Гэрээндээ /А болон Х банк нь/ хадгаламжийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ гэж тохиролцсон бөгөөд хадгаламжинд нь 8 сая төгрөг байсан. Охин нь сургалтын төлбөрөө хугацаанд нь төлөөгүйн улмаас баталгаа гаргагчаас 9 сая төгрөгийг гаргуулсан.

Хууль зүйн үндэслэлтэй тайлбар хийнэ үү

- Банк нь А-н хадгаламжийн мөнгийг авч болох уу
- Банк ямар хэмжээгээр хариуцлага хүлээх вэ?
- Баталгаа гаргагч үүрэг гүйцэтгүүлэгчийн үүргийн шаардлагыг хангасны дараа өөрийн эрх ашгийг хэрхэн хамгаалахыг өгөгдсөн тохиолдол дээр тайлбарлана уу

2. Баталгаа ба батлан даалтын гэрээний ялгааг багаар ажиллан тайлбарлан ярилцана уу.



3. Иргэн А, Б хоёрын хооронд 2006.04.20-ны өдөр 50 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулах үед А-ын найз Н болон Х нар нь хамтран хариуцах үүрэг хүлээж батлан даалтын гэрээ хийжээ. Гэтэл 2006.04.21-ны өдөр А, Б нар уулзаж дахин 15 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулжээ. Гэтэл 50 сая төгрөгийн зээлийн гэрээ хүчингүй болсон байна.

Хууль зүйн тайлбар хийнэ үү

- Батлан даагчийн үүрэг үндсэн үүрэгтэй ямар хамааралтай болохыг тайлбарлана уу
- Н, Х, А нарыг хамтран үүрэг гүйцэтгэгч гэж үзэж болох уу
- Батлан даагчид үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх, үүрэг шилжиж болохыг өгөгдсөн тохиолдол дээр тайлбарлана уу

4. Баталгааны болон батлан даалтын гэрээний загвар боловсруулна уу

5. Иргэний хуулийн 457-465 р зүйлүүдийг судлан гэрээний талууд болох батлан даагч, үүрэг гүйцэтгүүлэгч, баталгаа гаргагчийн эрх, үүргийг тодорхойлон ярилцаарай.



Сорил

1. Үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө баталгаа гаргагч банкны хүлээх үүрэг ямар тохиолдолд дуусгавар болохгүй вэ?

- a. баталгаа гаргагч банк үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн.
- b. гэрээнд заасан хугацаа дуусгавар болсон.
- c. баталгаа гаргагч үүргээсээ татгалзсан.
- d. үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнд заасан шаардах эрхээсээ татгалзсан.

2. Зээлээр худалдах, худалдан авах гэрээтэй холбоотойгоор худалдан авагч тал 20 сая төгрөгийн баталгааг банкнаас гаргуулан авсан байна. Гэвч гэрээний үүргээ гүйцэтгээгүйн улмаас баталгаа гаргасан банк хариуцлага хүлээх болсон. Энэ нөхцөлд банкны хүлээх хариуцлагын хэмжээ нь:

- a. Зээлээр худалдах, худалдан авах гэрээнд заасны дагуу бүхий л хохирлыг хариуцна.
- b. Зохих ёсоор гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хэмжээтэй тэнцүү байна.
- c. Банкны баталгааны гэрээнд заасан хэмжээгээр хязгаарлагдана.
- d. Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хэмжээтэй тэнцүү байна.

3. Батлан даалтын болон баталгааны гэрээ нь гэрээний үүргийн аль төрөлд хамаарах вэ?

- a. бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг
- b. бусдын эзэмшил ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон

гэрээний үүрэг

с. ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон үүрэг

д. зөрчлийн улмаас үүсэх үүрэг

4. Үүрэг гүйцэтгэгч А-гийн өмнөөс 10 сая төгрөгийг төлнө гэж түүний найз Б нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө баталж батлан даалтын гэрээ хийжээ. Хэрэв А тогтоосон хугацаанд үүргээ гүйцэтгэхгүй бол хариуцлагыг хэн хүлээх вэ?
- а. А өөрөө хүлээнэ*
 - б. батлан даагч Б хүлээнэ*
 - с. хоёулаа хамтын хариуцлага хүлээнэ*
 - д. А өөрөө хүлээх ба нөхөн төлөгдөөгүй хэсгээр Б хүлээнэ*
5. Иргэн А, Б нарын хооронд гэрээ байгуулах үед К нь А-д баталгаа гаргаж гэрээ хийжээ. Гэтэл А нь Б-г хууран мэхэлж гэрээ байгуулсан болох нь тогтоогдож, шүүх тэдний хооронд хийсэн гэрээг хүчин төгөлдөр бусад тооцсон байна. Энэ тохиолдолд баталгааны гэрээ:
- а. баталгааны гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна*
 - б. баталгааны гэрээ мөн адил хүчин төгөлдөр бус болно*
 - с. гэрээг дахин байгуулна*
 - д. зөв хариулт алга*
6. Иргэн А, Б хоёрын хооронд 2006.04.20-ны өдөр 20 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулах үед А-ын найз Н нь үүрэг хүлээж батлан даалтын гэрээ байгуулжээ. Гэтэл 2006.04.21-ны өдөр А, Б нар уулзаж дахин 15 сая төгрөгийн зээлийн гэрээ байгуулжээ. Үүрэг гүйцэтгэгч А гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд батлан даагч Н ямар хэмжээгээр хариуцлага хүлээх вэ?
- а. А-ын 15 сая төгрөгийг төлнө*
 - б. батлан даалтын гэрээг нөхөж байгуулсны дараа хариуцлага хүлээнэ*
 - с. хариуцлага огт хүлээхгүй*
 - д. 20 сая төгрөгийг төлнө*



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийж гүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 457-465 р зүйл
- Монгол улсын банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль /1995 он/
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 1035, 1044-р тал, 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Договорное право М.И.Брагинский В.В.Витрянский /общие положения 450-470-р тал



5. Тооцоо нийлэх гэрээ

Сэдвийн зорилго: Гэрээний талууд ажил хэргийн харилцаанаас үүссэн шаардлагыг гэрээнд заасан хугацааны дотор харилцан тооцоо нийлэх замаар хаахаар тохиролцох, түүнтэй холбогдох эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэгтэй болох, тооцоо нийлэх гэрээг байгуулах чадвар эзэмших, цаашид төлбөр тооцооны үүрэг, харилцааг гүнзгийрүүлэн судлахад суурь болно.



Нэр томъёоны тайлбар

Тооцоо нийлэх - үүрэг гүйцэтгүүлэгч болон үүрэг хүлээгч нь нийлүүлсэн бараа, үйлчилгээ, төлбөрөө харилцан тооцож тулгалт хийх
Тооцооны үлдэгдэл - төлбөл зохих төлбөрийн үлдэгдэл

Тооцоо нийлэх гэрээ - талууд хоорондын ажил хэргийн харилцаанаас үүссэн шаардлагыг гэрээнд заасан хугацааны дотор харилцан тооцоо нийлэх замаар хаахаар тохиролцох бөгөөд тооцоо нийлэх хүртэл шаардлага гаргахгүй байх үүрэг бүхий гэрээ

Хоёр талын, хариу төлбөргүй, хугацаатай, /гэрээнд өөрөөр заагаагүй бол тооцоог жилд нэг удаа нийлнэ/, урьдчилан тохиролцсон гэрээ

Тооцоо нийлэх гэрээний онцлог:

- Тооцоо нийлэх гэрээ нь хэлбэрийн хувьд амаар болон бичгээр хийнэ.
- Тооцооны үлдэгдлийг гэрээнд заасан хугацаанд төлөх бөгөөд тооцоог хааснаар тооцооны үлдэгдлийг төлөхийг шаардах эрх үүснэ
- Тооцооноос үүссэн үлдэгдлийг төлснөөр тооцоо нийлэх гэрээний шаардлагыг хангасанд тооцно
- Тооцоо нийлэх гэрээний дагуу төлөх төлбөрт хүү тооцож болох бөгөөд үүргийн гүйцэтгэлийг хангах аргуудыг хэрэглэж болно
- Тооцоо нийлэх гэрээний дагуу үүссэн шаардлагыг үүргийн гүйцэтгэлийг хангах аль нэг аргаар хангасан бол үүрэг гүйцэтгүүлэгч тооцоо нийлсний дараа ийнхүү хангасан хэмжээгээр тооцооны үлдэгдлийг төлөхийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй



Дасгал

- Иргэн У нь "Зургаадай" сүлжээ дэлгүүрт тараг нийлүүлдэг бөгөөд бараа бүтээгдэхүүнийхээ төлбөрийг сард хоёр удаа борлуулалтаар нь тооцон авч байхаар тохиролцсон. Хэрвээ зарагдсан барааны төлбөрийг сүлжээ дэлгүүр өгч чадахгүй бол төлөгдөөгүй үлдэгдэл төлбөрт хоногийн 0,5 хувийн алданги бодож, 2 хувийн хүү тооцохоор тохиролцсон. Гэтэл тус дэлгүүр сүүлийн хоёр сар тооцоог тулгасан боловч мөнгө дууссан байна гээд гүйлгээний мөнгийг 15,000,000Т хүртэл хуримтлуулан олгоогүй байна.
 - Ямар гэрээ байгуулагдсан бэ?
 - Уг гэрээнээс үүсэх хариуцлагыг тодорхойлно уу.
 - Тооцоо нийлсний дараа үүсэх үлдэгдлийг төлөх талаар талууд ямар үүрэг хүлээхийг өгөгдсөн жишээн дээр тайлбарлана уу.
- Багаар ажиллан тооцоо нийлэх гэрээний загвар боловсруулна уу.
- Иргэний хуулийн 466 р зүйлийг судлан тооцоо нийлэгч талуудын эрх, үүргийг харилцан ярилцаарай.



Сорил

- А тал Б талтай 2005 оны жилийн эцсийн тооцоог 2006.01.15-ны дотор нийлж дуусгахаар гэрээгээр тохиролцжээ. Гэтэл Б тал А талыг үйл ажиллагаагаа явуулахаа болих гэж байгаа тул 2006.01.10-ны дотор тооцоо нийлэх шаардлагыг тавьж утсаар мэдэгдсэн байна. Б талын шаардлага хууль ёсных уу
 - А тал Б талын шаардсан хугацааны дотор тооцоо заавал нийлнэ
 - Б тал гэрээний дагуу тооцоо нийлэх хүртэл шаардлага гаргах ёсгүй
 - А, Б талууд хугацааг дахин тохиролцож тооцоо нийлнэ
 - Б талын шаардлагыг биелүүлэхээс татгалзана
- Тооцоо нийлэх гэрээний талууд тооцоог хэдийд нийлж хаах талаар заагаагүй тохиолдолд жилд хэдэн удаа тооцоо нийлэх вэ?
 - сар бүр
 - улирал бүр
 - жилд 1 удаа
 - жилд 2 удаа
- Тооцоо нийлэх гэрээний дагуу төлөх төлбөрт хүү тооцож болох уу
 - болно
 - болохгүй
 - хуулиар зохицуулаагүй
 - шүүхээр шийдвэрлүүлнэ



4. Тооцоо нийлэх гэрээгээр А тал Б талд 15 сая төгрөгийн үлдэгдлийг 2006.04.10-ны дотор төлж дуусгахаар тохиролцжээ. А тал 15 сая төгрөгийн үлдэгдлийг 2006.04.09-ний орой дансаар төлсөн боловч Б талд мэдэгдэж амжаагүй байна. Тооцоо нийлэх гэрээний шаардлагыг хэзээ хангасан гэж үзэх вэ?

- a. дараагийн тооцоог нийлснээр*
- b. Б талын дансанд 15 сая төгрөг шилжин орсноор*
- c. Б талын дансруу 15 сая төгрөгийг шилжүүлснээр*
- d. А тал Б талд тооцооноос үүссэн үлдэгдлийг төлсөн тухай мэдэгдсэнээр*



Эх сурвалж

Дээрх сэдвийг бататгах болон өгөгдсөн даалгаврыг хийжгүйцэтгэхдээ дараах хэрэглэгдэхүүнийг жишиглэн судлаарай.

- Монгол улсын Иргэний хуулийн /2002 он/ I- III дэд хэсэг, II хэсэг 466 р зүйл
- Монгол улсын банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль /1995 он/
- Монгол улсын иргэний хуулийн тайлбар /ерөнхий анги/ 2005 он. ХЗДХЯ, ГТХАН 16-21-р бүлгийн тайлбарыг харна уу
- Комментарий к Гражданскому кодексу Российской Федерации часть второй. Москва 1998, 443-479 р тал